

БАТЛАВ.  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

С. БААТАРЖАВ

2020 оны 01 дүгээр сарын ...-ны өдөр

ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа	Хугацаа, давтамж /ажлын өдөр/	Хариуцах алба хаагч, хамтран хэрэгжүүлэх нэгж
<b>Төлөвлөлтийн зорилт 1. Цагдаагийн байгууллагын дотоод аудитын чадавхийг бэхжүүлэх</b>					
1.1	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад дотоод аудит, эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт зохион байгуулах	Холбогдох чиглэлээр алба хаагчдын мэдлэг, үр чадвар дээшилнэ.	Жилдээ	Тухай бүр	д/х А.Отгонсүх ЦДЦСНТ
1.2	Дотоод аудитын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүн, ач холбогдлыг цагдаагийн «байгууллагын дотоод болон гадаад орчинд сурталчлах	Дотоод аудитын үйл ажиллагаа, ач холбогдол, үр дүнгийн талаар талуудыг үнэн бодит мэдээллээр хангана.	Жилдээ	Тухай бүр	ХШДАХ-ийн Дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.3	Дотоод аудиторруудыг чадавхижуулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын үндэсний дотоод аудиторруудын холбооноос зохион байгуулах сургалтуудаад хамруулах	Дотоод аудиторруудын мэдлэг, үр чадвар дээшлэнэ.	Жилдээ	Тухай бүр	х/а А.Даваасүрэн ХШДАХ-ийн Дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.4	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тухайн оны дотоод аудитын жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтийг гаргаж, ХЗДХЯ-нд хургуулах	Удирдах байгууллагыг мэдээллээр хангана.	Дээд	Хагас, бүтэн жилд	2 удаа д/х А.Отгонсүх
Төлөвлөлтийн зорилт 2. Цагдаагийн байгууллагын эрсдэлийн үнэлгээ, байгууллага, алба хаагчийн хэрэгцээ шаардлага, тухайн аудитын ач холбогдол, үр дүнг харгалзан дотоод аудитыг хэрэгжүүлэх					

2.1	Гүйцэтгэлийн аудит	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллага, хуулийн этгээд, иргэнтэй байгуулсан гэрээ /түүвэрлэн/-ний хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Гэрээний хэрэгжилт, үр дүн, үр нөлөөнд үнэлэлт, дүгнэлт өгч, удирдлагыг мэдээлгээр хангана.	2 дугаар сард	20 өдөр	Д/х А.Отгонсүх х/а В.Отгонбаяр д/х С.Март х/ч Ц.Болормаа
2.2		Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас бусад байгууллагатай байгуулсан "Санамж бичиг"-ийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Санамж бийгийн хэрэгжилт, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч, удирдлагыг мэдээлгээр хангана.	1 дүгээр сард	20 өдөр	Д/х А.Отгонсүх ТЗБХ
2.3		Цагдаагийн байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Баримт бичгийн хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг тооцож үнэлнэ.	6 дугаар сард	20 өдөр	Д/х А.Отгонсүх ХНХ
2.4	Нийцлийн аудит	Албаны галт зэвсэг, хэрэглэлийн худалдан авалт, зарцуулалт, хадгалалт, хамгаалалтад дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг тооцож, ЦЕГ-ын удирдлага, холбогдох нэгжийг санал, зөвлөмжөөр хангана.	10 дугаар сард	20 өдөр	Д/х А.Отгонсүх САА, ТАГ
2.5		Цагдаагийн байгууллагын ил тод байдалд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Уг үйл ажиллагаа дахь эрсдэлийг тооцож, бууруулах, үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг тооцно.	6 дугаар сард	20 өдөр	х/а В.Отгонбаяр САА, ЗУГ, ХМТ
2.6	Мэдээлийн технологийн аудит	Хэрэглэгчийн хандах эрх ба нууц үгийн удирдлагын хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Цагдаагийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын зарим эрсдэлийг тооцож, үнэлэн, түүнийг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж гарч хэрэгжинэ.	9 дүгээр сард	20 өдөр	Д/х А.Отгонсүх МДШШУА

2.7	Үйл ажиллагааны аудит	Цагдаагийн байгууллагын мөрдөгчийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Мөрдөгчийн ажлын үйл ачаалал, ажиллагааны давхардлыг гаргаж, тэдгээрийг бууруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулж, хэрэгжилтийг тооцно.	3 дугаар сард	40 өдөр	х/а В.Отгонбаяр д/х А.Отгонсүх МДШШУА
2.8		Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын сахилгын мэдээ гаргах үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Сахилгын мэдээг шуурхай, бодитой гарах чиглэлээр зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтийг тооцно.	1 дүгээр сард	20 өдөр	х/а В.Отгонбаяр АБХ, ЦДЦАБ
2.9	НЦУГ-ын Эрүүлжүүлэх саатуулах төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Тус төвийн үйл ажиллагааг боловсронгуй болгож сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцно.	9 дүгээр сард	20 өдөр	х/а В.Отгонбаяр НЦУГ	
2.10	Санхүүгийн аудит	Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байранд байгаа иргэдийн хоолны зардалд санхүүгийн дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Аудитын мөрөөр санал, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцно.	10 дугаар сард	20 өдөр	д/х С.Март х/ч Ц.Болормаа
2.11		Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.8 дахь хэсгийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцсон байна.	3 дугаар сард	20 өдөр	д/х С.Март
2.12	Санхүүгийн аудит	Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.9 дэх хэсгийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох		4 дүгээр сард	20 өдөр	х/ч Ц.Болормаа
2.13		Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан	Зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт хангагдана.	Хагас, бүтэн жилээр	2 удаа	д/х С.Март

	Шаардлагад дотоод аудит хийж, хэрэгжилтийг хангуулах				
2.14	Цагдаагийн байгууллага, нэгжээс Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	2,7 дугаар сард	2 удаа	Х/ч Ц.Болормаа
2.15	Эргэн хянах аудит 2019, 2020 онд хийгдсэн дотоод аудитын мөрөөр өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтэд эргэн хянах аудит хийж, дүнг ЦЕГ-ын удирдлагад танилцуулах	Санал, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангах арга хэмжээ авагдана.	Жилдээ	Тухай бүр	ХШДАХ-ийн дотоод аудит хариуцсан алба хаагчид
2.16	Цагдаагийн байгууллагын удирдлагын шийдвэрээр төлөвлөгөөт бус дотоод аудитыг хэрэгжүүлэх	Удирдлагын шийдвэр хэрэгжиж, аудитын тайлан, үр дүнд үндэслэн санал, зөвлөмж боловсруулж хургуулсан байна.	Жилдээ	Тухай бүр	Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс

ЗӨВШӨӨРСӨН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ж.БОЛД

ХЯНАСАН:  
ХШДАХ-ИЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:  
ХШДАХ-ИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

А.ОТГОНСҮХ



БАТЛАВ  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧИ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Ж.БОЛД

2021 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр



ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2021 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа	Хугацаа, давтамж /ажлын өдөр/	Хариуцах алба хаагч, хамтран хэрэгжүүлэх нэгж
<b>Төлөвлөлтийн зорилт 1.Цагдаагийн байгууллагын дотоод аудитын чадвархийг бэхжүүлэх</b>					
1.1	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад дотоод аудит, эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалт зохион байгуулах	Холбогдох чиглэлээр алба хаагчдын мэдлэг, үр чадвар дээшлнэ.	Жилдээ	Тухай бүр	д/х А.Отгонсүх ЦДЦСНТ
1.2	Дотоод аудитын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүн, ач холбогдлыг цагдаагийн байгууллагын дотоод болон гадаад орчинд сурталчлах	Дотоод аудитын үйл ажиллагаа, ач холбогдол, үр дүнгийн талаар талуудыг үнэн бодит мэдээллээр хангана.	Жилдээ	Тухай бүр	ХШДАХ-ийн дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.3	Дотоод аудиторруудыг чадавхижуулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын үндэсний дотоод аудиторруудын холбооноос зохион байгуулах сургалтуудад хамруулах	Дотоод аудиторруудын мэдлэг, үр чадвар дээшлэнэ.	Жилдээ	Тухай бүр	х/а А.Даваасүрэн ХШДАХ-ийн дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.4	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тухайн оны дотоод аудитын жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтийг гаргаж, ХЗДХЯ-нд хүргүүлэх	Удирдах дээд байгууллагыг мэдээллээр хангана.	Хагас, бүтэн жилд	2 удаа	д/х А.Отгонсүх

Төлөвлөлтийн зорилт 2. Цагдаагийн байгууллагын эрсдэлийн үнэлгээ, байгууллага, алба хаагчийн хэрэгцээ шаардлага, тухайн аудитын ач холбогдол, үр дүнг харгалзан дотоод аудитыг хэрэгжүүлэх

2.1	Цагдаагийн байгууллага, нэгж дээрх орон тооны бус зөвлөл, ажлын хэсэг, комисс, багийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Тэдгээрийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж гаргах	3 дугаар сард	20 өдөр	д/х А.Отгонсүх ЦДЦАБ
2.2	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албаны автомашины ашиглалтад дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Албаны автомашины ашиглалтын үр нөлөөг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж гаргах	9 дүгээр сард	20 өдөр	х/а Д.Борхүү Автобааз
2.3	Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, нэгжийн удирдлагын тогтвортой байдал, төрийн албаны чадахуйн зарчмын хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Удирдлагын тогтвортой байдал, чадахуйн зарчмын хэрэгжилтийг хангах чиглэлээр санал, зөвлөмж гаргах	5 дугаар сард	20 өдөр	д/х А.Отгонсүх ХНХ
2.4	Цагдаагийн алба хаагчдын ял шийтгэлийн байдал, Цагдаагийн албаны тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь хэсгийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, алба хаагчдын сахилга, хариуцлага дээшилнэ.	5 дугаар сард	20 өдөр	х/а Д.Борхүү ХНХ
2.5	Нийцлийн аудит Цагдаагийн албаны тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан эдийн засгийн баталгааны хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг тооцож, ЦЕГ-ын удирдлага, холбогдох нэгжийг санал, зөвлөмжөөр хангана.	10 дугаар сард	20 өдөр	х/ч Ё.Мөнхзүл СААА

2.6	<p>Үйл ажиллагааны аудит</p> <p>Гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг арилгах, гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдэгдэл хүргүүлэх, түүний биелэлтэд хяналт тавих үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох</p>	<p>Мэдэгдэл хүргүүлэх үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх чиглэлээр санал, зөвлөмж гаргаж, хэрэгжилтийг хангуулна.</p>	3 дугаар сард	20 өдөр	<p>х/а Д.Борхүү НХЖХОНАБХА ЦДЦАБ</p>
2.7		<p>Цагдаагийн байгууллагын сэтгэл зүйчийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох</p>	<p>Сэтгэл зүйчийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр ЦЕГ-ын удирдлагыг мэдээлэл, санал, зөвлөмжөөр хангана.</p>	9 дүгээр сард	20 өдөр
2.8	<p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын газар, үл хөдлөх хөрөнгийн эрхийн байдалд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох</p>	<p>Аудитын мөрөөр санал, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцно.</p>	5 дугаар сард	20 өдөр	<p>а/д Ч.Эрдэнэболор СААД ЦДЦАБ</p>
2.9	<p>Төсвийн үр ашиггүй зардлыг бууруулах чиглэлээр санхүүгийн дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох</p>	<p>Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлж, хэрэгжилтийг тооцсон байна.</p>	3 дугаар сард	20 өдөр	<p>а/д Ч.Эрдэнэболор</p>
2.10	<p>Байнга давтагддаг санхүүгийн зөрчлийг арилгах чиглэлээр санхүүгийн дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох</p>		3 дугаар сард	20 өдөр	<p>х/ч Ё.Мөнхзүл</p>
2.11	<p>Санхүүгийн аудит</p> <p>Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах</p>	<p>Зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт хангагдана.</p>	Хатаг, бүтэн жилээр	2 удаа	<p>х/ч Ё.Мөнхзүл</p>

2.12	Цагдаагийн байгууллага, нэгжээс Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	2, 7 дугаар сард	2 удаа	а/д Ч.Эрдэнэболор
2.13	Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг ХЗДХЯ, Үндэсний аудитын газарт тайлагнах	Удирдлагын шийдвэр хэрэгжиж, аудитын тайлан, үр дүнд үндэслэн санал, зөвлөмж боловсруулж хургуулсан байна.	Улирал бүр	4 удаа	х/ч Ё.Мөнхзул а/д Ч.Эрдэнэболор
2.14	Цагдаагийн байгууллагын удирдлагын шийдвэрээр төлөвлөгөөт бүс дотоод аудитыг хэрэгжүүлэх		Жилдээ	Тухай бүр	Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс

ЗӨВШӨӨРСӨН:  
 ДЭД ДАРГА,  
 ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Р.ОТГОНЖАРГАЛ

ХЯНАСАН:  
 ХШДАХ-ИЙН ДАРГА,  
 ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
 БОЛОВСРУУЛСАН:  
 ХШДАХ-ИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
 ЦАГДААГИЙН ДЭД ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

А.ОТГОНСҮХ

The image shows two handwritten signatures in black ink. Below them is a red rectangular official stamp with Mongolian text and a central emblem. The stamp contains the text 'МОНГОЛ УЛСЫН АУДИТ АГЫ' (Mongolian State Audit Agency) and the date '2019.05.19'. There are also some handwritten numbers and marks on the stamp.



БАТЛАВ  
ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ТАЗАРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДИЛАГЧ,  
ХОШЛУУЧ ГЕНЕРАЛ



Ж.БОЛД

2021 оны 12 дугаар сарын .....-ны өдөр

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа	Хугацаа, давтамж /ажлын өдөр/	Хариуцах алба хаагч, хамтран хэрэгжүүлэх нэгж
<b>Төлөвлөлтийн зорилт 1.Цагдаагийн байгууллагын дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх</b>					
1.1	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад дотоод аудитын чиглэлээр сургалт зохион байгуулах	Холбогдох чиглэлээр алба хаагчдын мэдлэг, үр чадвар дээшилнэ.	Жилдээ	Тухай бүр	а/д Ч.Эрдэнэболор ЦДЦСНТ
1.2	Дотоод аудитын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүн, ач холбогдлыг цагдаагийн байгууллагын дотоод болон гадаад орчинд сурталчлах	Дотоод аудитын үйл ажиллагаа, ач холбогдол, үр дүнгийн талгаар талуудыг үнэн бодит мэдээллээр хангана.	Жилдээ	Тухай бүр	Дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.3	Дотоод аудиторуудыг чадавхжуулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын үндэсний дотоод аудиторуудын холбоо, бусад байгууллагаас зохион байгуулах сургалтуудад хамруулах	Дотоод аудиторуудын мэдлэг, үр чадвар дээшилнэ.	Жилдээ	Тухай бүр	х/а А.Даваасүрэн Дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.4	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тухайн оны дотоод аудитын жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтийг гаргаж, ХЗДХЯ-нд хүргүүлэх	Удирдах дээд байгууллагыг мэдээллээр хангана.	Хугаас, бүтэн жилд	2 удаа	х/а Д.Борхүү

Төлөвлөлтийн зорилт 2.Цагдаагийн Байгууллагын эрсдэлийн үнэлгээ, Байгууллага, алба хаагчийн хэрэгцээ шаардлага, тухайн аудитын ач холбогдол, үр дүнг харгалзан дотоод аудитыг хэрэгжүүлэх

2.1	Гүйцэтгэлийн аудит	Нийслэлийн дүүргүүд дэх цагдаагийн газрын алба хаагчдад үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийн байдалд гүйцэтгэлийн аудит хийж санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Уг үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	9 дүгээр сард	20 өдөр	Дотоод аудит хариуцсан алба хаагчид АБХ, НЦУГ
2.2	Гүйцэтгэлийн аудит	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр цагдаагийн байгууллагад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрөөс сонгон дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	3 дугаар сард	20 өдөр	Б.Лхагважаргал Х/ч УСХ
2.3	Нийцлийн аудит	Цагдаагийн ерөнхий газрын Автобаазын байгууллагжийн ашиглалт, насжилтын байдал /стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх/-д дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж боловсруулан хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	2 дугаар сард	20 өдөр	Б.Намгинжав Х/а СААА
2.4	Нийцлийн аудит	Цагдаагийн байгууллага, нэгжээс Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж, хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	10 дугаар сард	20 өдөр	Х/ч Ё.Мөнхзул а/д Ч.Эрдэнэболор
2.5	Үйл ажиллагааны аудит	Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн Нарстай дахь хээрийн сургалт дадлагын төвийн үйл ажиллагаанд дотоод	Төвийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	3 дугаар сард	20 өдөр	Х/а Д.Борхүү ЦДЦСНТ

		аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох					
2.6		Орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд байгуулагдсан сургалтын төвийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Орон нутаг дахь сургалтын төвийн үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	5 дугаар сард	20 өдөр	Дотоод аудит хариуцсан алба хаагчид ЦДЦСНТ	
2.7		Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хөвсгөл аймаг дахь "Сүүж-Уул-2" амралтын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Амралтын газрын үйл ажиллагааг Монгол улсад мөрдөгдөж байгаа стандартад шаардлагад нийцүүлэх талаар зөвлөмж хүргүүлж, биелэлт үр дүнг тооцсон байна.	6 дугаар сард	20 өдөр	Дотоод аудит хариуцсан алба хаагчид СААД	
2.8	Санхүүгийн аудит	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Зөвлөмж, акт, албан шаардлагын хангагдана.	5 дугаар сард	1 удаа	х/ч Ё.Мөнхзүл а/д Ч.Эрдэнэболор ЦДЦАБ	
2.9		Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг ХЗДХЯ, Үндэсний аудитын газарт тайлагнах		Хагас, бүтэн жилээр	2 удаа	х/ч Ё.Мөнхзүл а/д Ч.Эрдэнэболор	
2.10		Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг ХЗДХЯ, Үндэсний аудитын газарт тайлагнах	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	Улирал бүр	4 удаа	х/ч Ё.Мөнхзүл а/д Ч.Эрдэнэболор	
2.11	Цагдаагийн шийдвэрээр хэрэгжүүлэх	байгууллагын удирдлагын шийдвэрээр төлөвлөгөөт бус дотоод аудитыг хэрэгжүүлэх	Удирдлагын шийдвэрээр хийгдсэн дотоод аудитын мөрөөр санал, зөвлөмж	Жилдээ	Тухай бүр	Дотоод аудит хариуцсан алба хаагчид	

	хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.			
--	--	--	--	--

ЗӨВШӨӨРСӨН:  
 ДЭД ДАРГА,  
 ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.АМАРСАНАА

ХЯНАСАН:  
 ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН ДАРГА,  
 ЦАГДААГИЙН ХУРАНДАА

А.ДАВААСҮРЭН

БОЛОВСРУУЛСАН:  
 ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН  
 ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ  
 ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ



*(Handwritten signature)*

БАТЛАВ  
 ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
 ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДИЛГАГЧ,  
 ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

2022 оны 12 дугаар сарын .....-ны өдөр

**ЦАГДАА, ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН 2023 ОНЫ ДОТООД АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ	Хүрэх үр дүн	Хугацаа	Хугацаа, давтамж /ажлын өдөр/	Хариуцах алба хаагч, хамтран хэрэгжүүлэх нэгж
<b>Төлөвлөлтийн зорилт 1. Цагдаагийн байгууллагын дотоод аудитын чадавхыг бэхжүүлэх</b>					
1.1	Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдад дотоод аудитын чиглэлээр сургалт зохион байгуулах	Холбогдох чиглэлээр алба хаагчдын мэдлэг, үр чадвар дээшилнэ.	Жилдээ	Тухай бүр	Дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.2	Дотоод аудитын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүн, ач холбогдлыг цагдаагийн байгууллагын хэмжээнд сурталчлах	Дотоод аудитын үйл ажиллагаа, ач холбогдол, үр дүнгийн талаар талуудыг үнэн бодит мэдээллээр хангана.	Жилдээ	Тухай бүр	Дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.3	Дотоод аудиторуудыг чадавхжуулах чиглэлээр Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Монголын үндэсний дотоод аудиторуудын холбооноос зохион байгуулсан сургалтад хамруулах	Дотоод аудиторуудын мэдлэг, үр чадвар дээшилнэ.	Жилдээ	Тухай бүр	Д.Манлайбаатар Дотоод аудит хариуцсан алба хаагчид
1.4	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын тухайн оны дотоод аудитын жилийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, биелэлтийг гаргаж, ХЗДХЯ-нд хүргүүлэх	Удирдах дээд байгууллагыг мэдээллээр хангана.	Хягас, бүтэн жилд	2 удаа	Дотоод аудит хариуцсан алба хаагчид
<p>Төлөвлөлтийн зорилт 2. Цагдаагийн байгууллагын эрсдэлийн үнэлгээ, байгууллага, алба хаагчийн хэрэгцээ шаардлага, тухайн аудитын ач холбогдол, үр дүнг харгалзан дотоод аудитыг хэрэгжүүлэх</p>					


2.1	Гүйцэтгэлийн аудит Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын дүрэмт хувцасны өр төлбөрийг баратдуулсан байдалд гүйцэтгэлийн аудит хийж санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Уг үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	1 дүгээр сард	20 өдөр	Х/ч Ё.Мөнхзул Дотоод аудит хариуцсан алба хаагчид СААА
2.2	Гүйцэтгэлийн аудит Цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа мэдээллийн сангийн ашиглалт, давхардлын байдалд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Уг үйл ажиллагааг боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх талаар санал, зөвлөмж хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	2 дугаар сард	20 өдөр	Х/а М.Азжаргал Дотоод аудит хариуцсан алба хаагчид МДШШУА
2.3	Нийцлийн аудит Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн "Түр хяналтын цэг /пост/ байгуулж, алба хаагчдыг ажиллуулах тухай" А/93 дугаарын тушаалын хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Эрх зүйн акт, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэх талаар зөвлөмж боловсруулан хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	3 дугаар сард	20 өдөр	Х/а М.Азжаргал Дотоод аудит хариуцсан алба хаагчид ЭкоЦА
2.4	Нийцлийн аудит Цагдаагийн байгууллага, нэгжээс Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж, хэрэгжилтэд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	11 дүгээр сард	20 өдөр	Х/ч Ё.Мөнхзул Х/х Э.Анхчимэг ЦДЦАБ
2.5	Үйл ажиллагааны аудит Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын нормын хүлээц, хэрэглэлийн ашиглалтын байдалд дотоод аудит хийж, санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Уг үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	9 дүгээр сард	20 өдөр	а/х Э.Анхчимэг Дотоод аудит хариуцсан алба хаагчид СААА
2.6	Үйл ажиллагааны аудит Төсвийн хөрөнгөөр гадаад улсад суралцаж төгссөн алба хаагчдын гэрээний хэрэгжилтийн байдалд дотоод аудит хийж санал, зөвлөмж хүргүүлэн, биелэлт, үр дүнг тооцох	Гэрээний хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж хүргүүлж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	1 дүгээр сард	20 өдөр	Х/а М.Азжаргал Х/х Э.Анхчимэг СГАСХ
2.7	Үйл ажиллагааны аудит Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны "Сүүж-Уул-2" амралт, сувиллын газрын үйл ажиллагаанд дотоод аудит хийж,	Уг үйл ажиллагааг Монгол улсад мөрдөгдөж байгаа стандарт, шаардлагад	3 дугаар сард	20 өдөр	Х/а Б.Намгинжав

	санал, зөвлөмж хургуулэн, биелэлт, үр дүнг тооцох	нийлүүлэх талгаар зөвлөмж хургуулж, биелэлт үр дүнг тооцсон байна.			Дотоод аудит хариуцсан алба хаагчид СААА
2.8	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг ХЗДХЯ, Үндэсний аудитын газарт тайлагнах	Уг үйл ажиллагааг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль, стандарт, шаардлагад нийлүүлэх талгаар зөвлөмж хургуулж, биелэлт үр дүнг тооцсон байна.	5 дугаар сард	20 өдөр	Х/ч Ё.Мөнхзүл а/х Э.Анхчимэг ЦДЦАБ
2.9	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд дотоод аудит хийх	Уг үйл ажиллагааг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль, стандарт, шаардлагад нийлүүлэх талгаар зөвлөмж хургуулж, биелэлт үр дүнг тооцсон байна.	2 дугаар сард	20 өдөр	Х/ч Ё.Мөнхзүл а/х Э.Анхчимэг
2.10	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад ашиглагдаж байгаа автомашины шатахуун зарцуулалтын нормын байдалд дотоод аудит хийх	Уг үйл ажиллагааг Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль, стандарт, шаардлагад нийлүүлэх талгаар зөвлөмж хургуулж, биелэлт үр дүнг тооцсон байна.	4 дүгээр сард	20 өдөр	Х/ч Ё.Мөнхзүл а/х Э.Анхчимэг
2.11	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд 2023 онд хэрэгжүүлсэн дотоод аудитын мөрөөр өгсөн зөвлөмжийн биелэлт, үр дүнг тооцож, ХЗДХЯ-нд тайлагнах	Хэрэгжүүлсэн аудитын үр дүн бодитой гарсан байна.	III, IV улиралд	44 өдөр	Х/а Б.Намгинжав Дотоод аудит хариуцсан алба хаагчид
2.12	Цагдаагийн байгууллагын удирдлагын шийдвэрээр төлөвлөгөөт бус дотоод аудитыг хэрэгжүүлэх	Удирдлагын шийдвэрээр хийгдсэн дотоод аудитын мөрөөр санал, зөвлөмж хургуулж, биелэлт, үр дүнг тооцсон байна.	Жилдээ	Тухай бүр	Дотоод аудит хариуцсан алба хаагчид

ЗӨВШӨӨРСӨН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

ХЯНАСАН:  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛИЙН ГАСНЫ ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

БОЛОВСРУУЛСАН:  
МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН  
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



П.ОРОСТОГОО

Д.МАНЛАЙБААТАР

A handwritten signature in black ink, appearing to be 'M. AZHARGAL'.

М.АЗЖАРГАЛ





МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Улаанбаатар хот, 15160, Утас 70191087 Факс: (976) 70191087  
Цахим шуудан: info@police.gov.mn  
Цахим хуудас: www.police.gov.mn

2023.02.10 № 6/1518  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Г СААА, ЗУГ, ХХ, ХНХ, СГАСХ-ИЙН Г  
ДАРГА НАР ТАНАА

ГДотоод аудитын тайлан хүргүүлэх тухайГ

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөөний 2.6-д заасны дагуу “Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцаж төгссөн алба хаагчдын гэрээний хэрэгжилтийн байдал”-д хийсэн дотоод аудитын тайланг хүргүүлж байна.

Удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлт, үр дүнг 2023 оны 10 дугаар сарын 10-ны дотор ирүүлж, хамтран ажиллана уу.

Холбогдох албан тушаалтан: Дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал /Утас: 70191048, 91999033/.

Хавсралт 12 хуудастай.



Цагдаагийн Ерөнхий Газар  
Цагдаагийн Ерөнхий Газар  
Дотоод Хяналт-Аюулгүй Байдлын Газрын Дарга  
Довдон Манлайбаатар  
2023.02.10 12:45

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцаж төгссөн алба хаагчдын гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүн, дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдалд дотоод аудит хийсэн талаар”

2023 оны 02 дугаар  
сарын 09-ний өдөр

№ 1/33

Улаанбаатар  
хот

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн ахмад Э.Анхчимэг нар “Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцаж төгссөн алба хаагчдын гэрээний хэрэгжилтийг хангах чиглэлээр зохион байгуулсан ажлын үр дүн, дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал”-д дотоод аудит хийлээ.

**Нэг. Өнөөгийн нөхцөл байдлын талаар:**

Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцаж төгссөн алба хаагчдын гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Сургалтын бодолго боловсруулж, хэрэгжүүлэх /код 118/”, “Гадаадад суралцагчид санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх /код 808/”, “Гадаадад суралцагчийг сонгон шалгаруулах /код 946/ журмуудаар зохицуулагдаж байна.

2018-2022 онд суралцаж төгссөн 99 алба хаагчийн цалингийн зардалд 2.1 тэрбум төгрөг, замын зардалд 188.9 сая төгрөг, нийт 2.3 тэрбум төгрөгийг төсвөөс санхүүжүүлж, зарцуулсан байна /Хавсралтаас үзнэ үү/.

Суралцаж төгссөн алба хаагчдыг оноор нь авч үзвэл;

Он	2018	2019	2020	2021	2022	Нийт
Суралцагчийн тоо	12	20	17	28	22	99

Дээрх төгсөгчдийг суралцсан улс орноор нь үзвэл, Австрали улсад 2, Америкийн Нэгдсэн улсад 2, Бүгд Найрамдах Солонгос улсад 2, Бүгд Найрамдах Турк улсад 14, Бүгд Найрамдах Хятад Ард улсад 5, Оросын Холбооны улсад 73, Тайвань улсад 1 алба хаагч тус тус суралцсан байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/144 дүгээр тушаалаар баталсан “Гадаадад суралцагчийг сонгон шалгаруулах /код 946/ журам”-ын 946.11.3-т “...хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын баталгаажсан шийдвэрийг үндэслэн цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж суралцагч болон түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчтэй “Сургалтын гэрээ”-г байгуулна” гэж заасан боловч гэрээ байгуулсан нотломж байгаа 63, гэрээ байгуулсан талаарх мэдээлэл, нотломж байхгүй 36 байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/247 дугаар тушаалаар баталсан “Гадаадад суралцагчид санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх /код 808/ журам”-ын 808.4.3-т “Гадаадад суралцагчийн гэрээг цагдаагийн төв байгууллагын Хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгж хариуцан, суралцагчийн гэрээний үүргийн биелэлтийг суралцуулагч улсын хичээлийн хагас, бүтэн жилээр суралцагчаас авч дүгнэх ажлыг хариуцна” гэж заасан боловч 99 алба хаагчийн 63 буюу 64.0 хувьд нь гэрээ байгуулсан нотломж байгаа бөгөөд, үүнээс зөвхөн 9 алба хаагчийн гэрээг албан ёсоор дүгнэсэн баримт байна.

Гэрээг бодитой дүгнээгүй, явцын дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс шалтгаалан төсвийн мөнгөөр суралцсан алба хаагчаас 19 нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, 7 алба хаагч томилогдоогүй, 6 алба хаагч Дотоод хэргийн Их сургууль /3/, Шүүх шинжилгээний ерөнхий газар /1/, Авилгатай тэмцэх газар /2/-т тус тус шилжсэн, 2 алба хаагч цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан, 1 алба хаагч сургалтын чөлөөтэй, 1 алба хаагч цагдаагийн албанаас халагдсан байна.

Одоогийн байдлаар 99 алба хаагчаас 64 алба хаагч нь цагдаагийн байгууллагад ажиллаж, сургалтын гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлж байна.

Сургалтын гэрээний 3.5-т “Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу ажлын байраар хангагдаж, томилсон албан тушаалд 3-аас доошгүй жилийн хугацаанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллах”, 3.6-т “Суралцагч нь энэхүү гэрээ болон алба хаах гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас захиалагчтай байгуулсан гэрээ дуусгавар болсон тохиолдолд суралцах хугацаанд гарсан бүх зардлыг нөхөн төлнө”, 4.3-т “Зардлын нөхөн төлбөрийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Төрийн сангийн ..... дансанд төвлөрүүлнэ” гэж заасны дагуу өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, 3 жил болоогүй шилжсэн, албанаас халагдсан алба хаагчаас суралцах хугацаанд гарсан бүх зардлыг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох шаардлагатай байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-ын 2.1.2-т “... суралцах орныхоо хэлийг зохих түвшинд эзэмшсэн, тухайн улс орны академи, их, дээд сургуулиас шаардах хэлний түвшин, шалгуурыг бүрэн хангасан байх”, 2.2.1.3-т “элсэгчийн судалгаа, шинжилгээний ажлын сэдэв, агуулга нь харьяа байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг онол, практикийн талаас судалсан байх ба амьдралд нэвтэрч үр дүнгээ өгөхүйц байна”, 6.4-т “Журмын хэрэгжилтэд жил бүр хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч дүгнэнэ” гэсэн заалтуудын хэрэгжилт хангалтгүй байгаагаас Олон улсад цагдаагийн албаны нэр хүнд унах, гадаадын их, дээд сургуульд төсвийн хөрөнгөөр суралцаж төгссөн алба хаагчид байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, олон улсын шинэ туршлага, арга зүйг нэвтрүүлэхэд идэвх санаачилга гаргахгүй байх, дотоод хяналтыг үр дүнтэй, тогтмол хэрэгжүүлээгүйгээс алба хаагчид гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, төсвийн хөрөнгийг үр дүнтэй, үр өгөөжтэй зарцуулахгүй байх, сонгон шалгаруулалтыг бодитой, шударга явуулаагүйгээс албандаа сэтгэлтэй, зүтгэлтэй алба хаагчдын боломжийг алдагдуулах зэрэг эрсдэл үүсэхээр байгааг анхааруулж байна.

#### **Хоёр. Дүгнэлт:**

Хууль зүй, дотоод хэргийн яам болон Цагдаагийн төв байгууллагын Төлөвлөлт, зохион байгуулалтын болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсээс Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг

сонгон шалгаруулах, суралцуулах журам” болон холбогдох цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хэрэгжилтийн байдалд сүүлийн 5 жилд хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч дүгнээгүй, явцын дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцаж төгссөн алба хаагчдын талаарх мэдээллийн санг бодитой бүрдүүлээгүй, Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөцийн болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсүүдийн хоорондын мэдээлэл зөрүүтэй, сургалтын гэрээний хэрэгжилтийг журмаар тогтоосон хугацаанд үнэлж, дүгнээгүй, дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлээгүйгээс шалтгаалан цагдаагийн байгууллагын зардлаар суралцсан алба хаагчдаас 19 нь өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, 6 нь гэрээний хугацаа дуусаагүй байхад өөр байгууллагад шилжсэн, 1 нь албанаас халагдсан байна.

Иймд сургалтын гэрээний 3.5-т “Гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу ажлын байраар хангагдаж, томилсон албан тушаалд 3-аас доошгүй жилийн хугацаанд тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллах”, 3.6-т “Суралцагч нь энэхүү гэрээ болон алба хаах гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйн улмаас захиалагчтай байгуулсан гэрээ дуусгавар болсон тохиолдолд суралцах хугацаанд гарсан бүх зардлыг нөхөн төлнө”, 4.3-т “Зардлын нөхөн төлбөрийг Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Төрийн сангийн ..... дансанд төвлөрүүлнэ” гэж заасны дагуу дээрх 26 алба хаагчаас суралцах хугацаанд гарсан бүх зардлыг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам”-д сургалтын гэрээний дээрх заалтуудыг тусгаж, эрх зүйн зохицуулалтын хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцах алба хаагчдыг сонгон шалгаруулах үйл явцыг ил тод, нээлттэй, бодитой зохион байгуулах, дүнг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдад мэдээлж байх, сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчдаас төгсөж ирээд цагдаагийн байгууллагад 5-аас доошгүй жил ажиллах, хэрэв ажиллаагүй тохиолдолд суралцах хугацаанд гарсан бүх зардлыг нөхөн төлүүлэх үүргийн гүйцэтгэлийг хангуулах талаар баталгаа авч, сургалтын гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тогтмол тооцож, хувийн хэрэгт нь хавсаргаж, гэрээний явцын байдалд хяналт шинжилгээ хийдэг байх шаардлагатай байна.

#### Гурав. Санал:

Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцаж төгссөн алба хаагчдын гэрээний хэрэгжилтийг хангах үйл ажиллагаа сайжруулах чиглэлээр дараах ажил, арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

Нэг. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан “Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам” болон холбогдох цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын хэрэгжилтийн байдалд жил бүр хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч дүгнэж байх /ЗУГ, СГАСХ/; ✓

Хоёр. Сургалтын гэрээний үүргээ биелүүлээгүй 26 алба хаагчаас суралцах хугацаанд гарсан бүх зардлыг нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох /CAAA, СГАСХ, ХХ/; ✓

Гурав. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/45 дугаар тушаалаар баталсан "Гадаадын их, дээд сургуульд хууль сахиулах байгууллагын алба хаагчийг сонгон шалгаруулах, суралцуулах журам"-д сургалтын гэрээний заалтуудыг тусгаж, эрх зүйн зохицуулалтын хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ЗУГ, СГАСХ, ХХ/; ✓

Дөрөв. Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцах алба хаагчдыг сонгон шалгаруулах үйл явцыг ил тод, нээлттэй, бодитой зохион байгуулах, дүнг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдад мэдээлж байх, сонгон шалгаруулалтад тэнцсэн суралцагчдаас төгсөж ирээд цагдаагийн байгууллагад 5-аас доошгүй жил ажиллах, хэрэв ажиллаагүй тохиолдолд суралцах хугацаанд гарсан бүх зардлыг нөхөн төлүүлэх үүргийн гүйцэтгэлийг хангуулах талаар баталгаа авч, сургалтын гэрээний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр тогтмол тооцож, хувийн хэрэгт нь хавсаргаж, гэрээний явцын байдалд хяналт шинжилгээ хийдэг байх /ЗУГ, СГАСХ/; ✓

Тав. Цагдаагийн байгууллагын захиалгаар гадаад улсад суралцаж төгссөн алба хаагчдын талаарх мэдээллийн санг бодитой бүрдүүлэх, Санхүү, аж ахуйн алба, Хүний нөөцийн болон Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтсүүдийн хоорондын мэдээллийн зөрүүг арилгах, дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн сан үүсгэж, баяжилтыг тухай бүр хийж байхад анхаарах /СААА, СГАСХ, ХНХ/; ✓

Зургаа. Зөвлөмжийн биелэлтийг заалт тус бүрээр гаргаж, 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлж, биелэлт, үр дүнг тооцуулах саналтай байгааг Танд илтгэн танилцуулъя. ✓

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

УДИРДЛАГЫН ШИЙДВЭР:.....  
.....  
.....

ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

ХЯНАСАН:  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:  
МӨН ГАЗРЫН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА

**ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН**

2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

**Аудитын нэр:** Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны өр төлбөр, тооцоо, зарцуулалтын байдалд хийх дотоод аудит.

**Аудит хийгдсэн нэгж:** Хүний нөөцийн хэлтэс, Хангалт үйлчилгээний төв, Цагдаа, дотоодын цэргийн 53 анги, байгууллага.

**Аудитын объект:** Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дүрэмт хувцас, хэрэглэлийн өр төлбөр, тооцоо, зарцуулалт, халагдсан чөлөөлөгдсөн алба хаагчийн тухай баримт, мэдээлэл түүнд холбогдох бусад үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

**Аудитын төрөл, код:** Санхүүгийн аудит, ЦЕГ-ДХАБГ/СА-2023/02

**Аудитын хугацаа:** 2023.01.26-2023.02.10

**Аудитын багийн ахлагч:** Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал.

**Аудитын багийн гишүүн:** Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит /санхүүгийн/ хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул.

**1. ТАНИЛЦУУЛГА**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчийн дүрэмт хувцас, хэрэглэлийн өр төлбөр, тооцоо, зарцуулалттай холбоотой харилцаа Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Цагдаагийн албаны тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны /код 911, 917/ журмаар зохицуулагдаж байна.

**Норм хувцас хангалтын программд тусгагдсан төлбөрийн талаар:**

Хангалт үйлчилгээний төв нь хүний нөөцийн цахим сангийн мэдээллээс албанаас халагдсан чөлөөлөгдсөн алба хаагчийн мэдээллийг татан авч, нормт хувцас, хангалтын программд шивснээр эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр тооцоотой алба хаагчийн жагсаалтыг гарган, нэхэмжлэлийг холбогдох нэгжид хүргэж, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын төлбөр барагдуулалтад улирал бүр үнэлэлт, дүгнэлт өгч ажиллаж байна.

Норм хувцас хангалтын программаас түүвэрлэн ирүүлсэн 2020-2022 оны 3 жилийн мэдээллээс үзэхэд 2020 онд 326, 2021 онд 503, 2022 онд 971, нийт 1800 халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчдад эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны 1.3 тэрбум төгрөгийн тооцоо гарчээ.

Дээрх эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны тооцоог нийт 627.3 сая төгрөгийн шинэ дүрэмт хувцсаар, 384.9 сая төгрөгийг дансанд тушааж, 2022 оны байдлаар 354.7 төгрөгийн төлбөрийн үлдэгдэлтэй байна. /Хүснэгт 1/

Он	Халагдсан чөлөөлөгдсөн алба хаагчийн тоо		Төлбөл зохих хувцасны төлбөр	Үүнээс төлсөн дүн /сая төгрөгөөр/			Үлдэгдэл
	ХНХ-ээс	ХҮТ-өөс		Шинэ дүрэмт хувцсаар	Мөнгөөр	Нийт төлсөн дүн	
2020	290	326	191.9	114.6	59.6	174.2	17.8
2021	450	503	381.1	191.1	138.5	329.6	51.5
2022	1004	971	793.8	321.6	186.8	508.4	285.5
Дүн	1,744	1,800	1,366.8	627.3	384.9	1,012.2	354.8

Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсээс ирүүлсэн хүний нөөцийн гаралтын сүүлийн 3 жилийн мэдээллээс үзэхэд цагдаа, дотоодын цэргийн алба хаагч өөрийн санаачилгаар албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан, халагдсан, тэтгэвэр тогтоолгох болзол хангасан, алба хаах насны дээд хязгаарт хүрсэн, шилжин болон сэлгэн томилогдсон, сургуульд суралцуулсан, хүүхэд асрах чөлөө авсан, нас барсан зэрэг үндэслэлээр 2020 онд 558, 2021 онд 882, 2022 онд 1664, нийт 3104 алба хаагч албанаас чөлөөлсөн байна.

Үүнээс халагдаж, чөлөөлөгдсөн алба хаагчаас эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны тооцоо үүсэхээр алба хаагч 2020 онд 290, 2021 онд 450, 2022 онд 1004, нийт 1744 байна. /буцаж албанд томилогдсон алба хаагч хамрагдаагүй/

#### **Гүйцэтгэлээр данс бүртгэлд тусгагдсан талаар:**

Мөнгөн хөрөнгөөр эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны төлбөр барагдуулсан байдал: Хангалт үйлчилгээний төвд өөрийн орлого /эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны төлбөр тушаасан/ 2020 онд 112.2 сая, 2021 онд 154.9 сая, 220.5 сая, нийт 487.6 сая төгрөг төвлөрснөөс, 226.0 сая төгрөгийг урсгал төсвийн дагуу зарцуулан, давсан орлогоос Хангалт үйлчилгээний төвд нэг цэгийн барилгын зураг төслийн үнийн урьдчилгаа, 1 ширхэг бохирын автомашин худалдан авахад, мөн төвийн конторын коридорын болон дотор агуулахын засвар, үүдний вакум хаалт, [www.intr.gov.mn](http://www.intr.gov.mn) цахим хуудасны сайжруулалтад нийт 127.5 сая төгрөгийг зарцуулж, 2020-2021 оны эцэст нийт 116.2 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 917.9.8-д "Цагдаагийн төв байгууллагын Санхүү, аж ахуйн алба нь тухайн жилд төвлөрсөн төлбөрийг дүрэмт болон ажлын хувцас бэлтгэхэд зарцуулна" гэж заасны дагуу 19.5 мянган төгрөгийн нэг бүрийн үнэ бүхий 918 ширхэг, нийт 17.9 сая төгрөгийн савхин бээлий худалдан авч бэлтгэжээ. /Хүснэгт 2/

Он	Дансанд тушаасан дүрэмт хувцасны төлбөр /сая. төгрөг/	Үүнээс: Зарцуулсан байдал /сая. Төгрөгөөр/			Улсад татан төвлөрүүлсэн
		Урсгал санхүүжилтээр батлагдсан төсвийн дагуу	Давсан орлогоос:		
			Журмаас бусад зардалд зарцуулсан	Журмын дагуу дүрэмт хувцас бэлтгэсэн	
2020	112.2	112.0	0.2		
2021	154.9	42.0	49.1		63.8

2022	220.5	72.0	78.2	17.9	52.4
Дүн	487.6	226.0	127.5	17.9	116.2

Шинэ дүрэмт хувцсаар эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны төлбөр барагдуулсан байдал: Хангалт үйлчилгээний төвийн санхүүгийн тайланд 2020 онд 151.2, 2021 онд 235.3, 2022 онд 384.7, нийт 771.2 сая төгрөгийн шинэ дүрэмт хувцас, агсамж тушаасныг данс бүртгэлд орлогоор тусгажээ. /Хүснэгт3/

Хүснэгт 3

Үзүүлэлт	2020 он	2021 он	2022 он	Дүн
Мөнгөн дүнгээр /сая, төгрөгөөр/	151.2	235.3	384.7	771.2

### **Цагдаа дотоодын цэргийн анги байгууллагын дүрэмт хувцасны төлбөр барагдуулах талаар хийж хэрэгжүүлсэн ажлын талаар:**

Цагдаа дотоодын цэргийн анги байгууллага нь албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр тооцоог нэхэмжлэлийн дагуу барагдуулах талаар "Нэг хувцас нэг сэтгэл" аян, төлбөр барагдуулах ажлын хэсэг байгуулах, иргэний хэргийн анхан шатны шүүхэд баримт бүрдүүлэх хүргэх, алба хаагчдаас хэрэглээгүй шинэ дүрэмт хувцас хандивлах уриалга гаргах зэрэг ажлыг зохион байгуулжээ.

Эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр барагдуулалтын үлдэгдэл дүн 2020 онд 17.8, 2021 онд 51.5, 2022 онд 285.5 сая төгрөг байна.

## **2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **2.1 Аудитын зорилго**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дүрэмт хувцас, хэрэглэлийн өр төлбөр, тооцоо, зарцуулалтын байдалд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгох.

### **2.2 Аудитын цар хүрээ**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дүрэмт хувцас, хэрэглэлийн өр төлбөр, тооцоо, зарцуулалт, халагдсан чөлөөлөгдсөн алба хаагчийн тухай баримт, мэдээлэл түүнд холбогдох бусад үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

### **2.3 Аудитын зохион байгуулалт**

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад албан бичгээр хүргүүлэн танилцуулж, Хүний нөөцийн хэлтсээс 2020-2022 оны байдлаар хүний нөөцийн гаралтын талаарх судалгаа болон Хангалт үйлчилгээний төвөөс эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны төлбөрийн талаарх судалгаа, тооцоолол, цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын дүрэмт хувцасны төлбөр тооцоо барагдуулсан талаар сүүлийн 3 жилийн байдлаар хийж гүйцэтгэсэн ажлын тайлан, танилцуулга болон хамааралтай бусад баримт бичгийг гаргуулан авч, судалсан.

Түүнчлэн аудитын явцад цуглуулсан мэдээлэлд үндэслэн тулган баталгаажуулах, нэгтгэн дүгнэх, аргыг ашиглан дүгнэлт гарган, нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.



### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Аудитын хүрээнд цугларсан мэдээлэл, баримт материал үндэслэн энэхүү тайланд тусгаж, удирдлагад танилцуулан, шийдвэрлүүлбэл зохих дараах асуудлууд байна. Үүнд:

3.1. Хүний нөөцөөс ирүүлсэн мэдээлэлд албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцасны тооцоо үүсэх алба хаагч 2020 онд 290, 2021 онд 450, 2022 онд 1004, нийт 1744, хангалт үйлчилгээний төвийн норм хувцас хангалтын программаас түүвэрлэн ирүүлсэн мэдээллээс үзэхэд 2020 онд 326, 2021 онд 503, 2022 онд 971, нийт 1800 байгаа нь зөрүүтэй байна.

3.2. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 911/-ын 911.7.6-д "Албанаас чөлөөлөгдсөн, халагдсан, тэтгэвэрт гаргаж, тэтгэмж тогтоогдсон, томилогдсон шийдвэр болон бусад хүний нөөцийн чиглэлээр батлагдан гарсан эрх зүйн актыг хүний нөөц, сургалтын ажил хариуцсан нэгжээс Санхүү, аж ахуйн албанд хүргүүлэх үүрэг хүлээнэ." гэж заасан боловч төв байгууллагын хүний нөөц хариуцсан нэгжээс 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дээрх эрх зүйн актыг Санхүү, аж ахуйн албанд хүргүүлээгүй байна.

3.3. Хангалт үйлчилгээний төвийн 2020-2022 оны байдлаар зарцуулалтыг үзэхэд төвлөрсөн төлбөр 487.6 сая төгрөгөөс 226.0 сая төгрөгийг урсгал төсвийн дагуу зарцуулан, давсан орлогоос Хангалт үйлчилгээний төвд нэг цэгийн барилгын зураг төслийн үнийн урьдчилгаа, 1 ширхэг бохирын автомашин худалдан авахад, мөн төвийн конторын коридорын болон дотор агуулахын засвар, үүдний вакум хаалт, [www.intr.gov.mn](http://www.intr.gov.mn) цахим хуудасны сайжруулалтад нийт 127.5 сая төгрөгийг зарцуулж, 2020-2021 оны эцэст нийт 116.2 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Энэ нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 917/-ын 917.9.8-д "Цагдаагийн төв байгууллагын Санхүү, аж ахуйн алба нь тухайн жилд төвлөрсөн төлбөрийг дүрэмт болон ажлын хувцас бэлтгэхэд зарцуулна" гэж заасантай нийцэхгүй байна.

3.4. Аудитад ирүүлсэн сүүлийн 3 жилийн мэдээллээс үзэхэд өөрийн санаачилгаар албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан, халагдсан, тэтгэвэр тогтоолгох болзол хангасан, алба хаах насны дээд хязгаарт хүрсэн, шилжин болон сэлгэн томилогдсон, сургуульд суралцуулсан, хүүхэд асрах чөлөө авсан, нас барсан зэрэг үндэслэлээр 2020 онд 558, 2021 онд 882, 2022 онд 1664 болж чөлөөлөгдсөн алба хаагчийн тоо өссөн байна.

Мөн бэлтгэн нийлүүлж буй дүрэмт хувцасны зах зээлийн үнэ нэмэгдсэнтэй холбоотой эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр барагдуулалтын үлдэгдэл дүн 2020 онд 17.8, 2021 онд 51.5, 2022 онд 285.5 сая болон өр төлбөр өсчээ.

### 4. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичиг үндэслэн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцас, хэрэглэлийн өр төлбөр, түүний барагдуулалт, тооцоолол, төлбөрийн зарцуулалт, түүнд холбогдох үйл ажиллагааг "Хангалттай" гэж үнэлж, илэрсэн зөрчил дараах нөхцөл байдлаас шалтгаалсан гэж дүгнэж байна. Үүнд:

4.1. Хүний нөөцийн цахим сан, хангалт үйлчилгээний төвийн норм хувцас, хангалтын программ дахь албанаас халагдсан, чөлөөлөгдсөн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр үүсэхээр алба хаагчийн тоо зөрүүтэй байгаа нь тухайн байгууллагын хүний нөөц хариуцсан алба хаагч хүний

нөөцийн цахим программд эрх зүйн актад тусгагдсан үндэслэлийг тохирсон ангилалд мэдээлээгүй, хугацаа хоцроон мэдээлснээс шалтгаалсан;

**4.2.**Цагдаагийн төв байгууллагын хүний нөөцийн ажил хариуцсан нэгж нь харьяалах байгууллага бүрийн гаргасан тушаал шийдвэр, эрх зүйн актыг хүргүүлдэггүй зөвхөн төв байгууллагаас гарсан тушаал шийдвэр, эрх зүйн актыг хүргэх зохицуулалттай байгаа нь зохиомол ажлын ачаалал үүсгэж байгаа тул энэ үйл ажиллагааг цахимжуулж, хүний нөөцийн цахим сан, норм хувцас хангалтын программтай уялдаатай байхаар зохицуулалтыг тусгах шаардлага үүссэн;

**4.3.**Төсвийн тухай хууль, цагдаагийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нийцүүлэн тухайн жилд төвлөрсөн төлбөрийн зарцуулалтыг дүрэмт хувцас бэлтгэхээс гадна санхүүжилтийг бүрдүүлэн, зарцуулах талаар тодорхой тусгаагүй;

**4.4.** Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын аж ахуйн ажилтан, нягтлан бодогчид албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр нэмэгдэж, өр буурахгүй байгаа нь хүний нөөцийн гаралт ихэссэн, бэлтгэн нийлүүлж байгаа дүрэмт хувцасны зах зээлийн үнэ өссөн, тухайн нэгжүүд төлбөр барагдуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна гэж үзлээ.

## **5. ЗӨВЛӨМЖ**

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд суурилан эдэлгээний хугацаа дуусаагүй алба хаагчийн дүрэмт болон ажлын хувцасны төлбөр барагдуулалтыг эрчимжүүлэх, илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгжид хүргүүлэх саналтай. Үүнд:

**5.1.**Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хүний нөөц хариуцсан алба хаагчийн “Хүний нөөцийн цахим сан”-д албанаас халагдаж, чөлөөлөгдсөн алба хаагчтай холбоотой гарсан эрх зүйн акт, үндэслэлийг оновчтой, тохирсон ангилалд, тухай бүр, үнэн зөв мэдээлсэн эсэхэд хяналт тавих, ажлын чиглэл хүргэх /ХНХ/;

**5.2.** Хүний нөөцийн ажил хариуцсан нэгжээс хүний нөөцийн цахим санд тухай бүр оруулах, хангалт үйлчилгээний төвөөс дээрх цахим санд нэвтрэх эрх бүхий алба хаагчийг томилон, эрх зүйн актын дагуу нормын хувцас, хангалтын программд холбогдох өөрчлөлт хөдөлгөөнийг шивж, эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт хувцас болон ажлын хувцасны төлбөр тооцоог өдөр бүр гарган холбогдох нэгжид хүргэх үйл ажиллагааны зохистой дэс дарааллыг боловсруулж, журамд тусгах /СААА, ХНХ, ХХ/;

**5.3.**Тухайн жилд төвлөрсөн албанаас халагдсан, чөлөөлөгдсөн алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөрийг Хангалт үйлчилгээний төвийн өөрийн орлогоор бүртгэж, урсгал төсвийн санхүүжилтийг бүрдүүлэн зарцуулах, тухайн жилийн давсан орлогоос дүрэмт хувцас болон ажлын хувцас бэлтгэж, нэн шаардлагатай зардалд зарцуулах зохицуулалтыг журамд нарийвчлан тусгах /СААА, ХХ/;

**5.4.**Албанаас халагдаж, чөлөөлөгдсөн алба хаагчийн эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр бууруулах, төлбөр барагдуулах ажлыг эрчимжүүлэхэд зохион байгуулалтын ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

**5.4.1.**Эдэлгээний хугацаа дуусаагүй дүрэмт болон ажлын хувцасны төлбөр барагдуулах талаар хийж хэрэгжүүлсэн ажлыг тухайн нэгжийн төлбөр барагдуулалт, орон тоо, хүний нөөцийн гаралтын хэмжээтэй уялдуулан үнэлж, тооцох /ХҮТ/;

5.4.2. Хүний нөөцийн тогтвор суурьшилтай ажиллахад онцгой анхаарч, цагдаагийн байгууллагыг олон нийтэд сурталчлах үр дүнтэй ажил, арга хэмжээг тогтмол зохион байгуулах /СГАСХ, ЦДЦАБ/.

Дотоод аудитаар илэрсэн асуудлыг сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2023 оны 04 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

## **6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР**

Аудитын тайлангийн төслийг Санхүү, аж ахуйн алба /Хангалт үйлчилгээний төв/, Хүний нөөцийн хэлтэс, Хуулийн хэлтэст хүргүүлсний дагуу тус нэгжүүдээс 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 14е/38, 56/1849, 5г/1792 дугаар албан бичгээр “Удирдлагын тайлбар”-ыг ирүүлсэн нь тайланд дурдсан болон илэрсэн асуудалд тусгуулах саналгүй гэсэн болно.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА

**ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН**

2023 оны 06 дүгээр сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

**Аудитын нэр:** Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд хийх гүйцэтгэлийн дотоод аудит.

**Аудит хийгдсэн нэгж:** Санхүү, аж ахуйн алба.

**Аудитын объект:** Аудитаар санхүү, аж ахуйн албаны 2022 оны 01 дүгээр сарын 01-нээс 2022 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал хугацааны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа.

**Аудитын төрөл, код:** Гүйцэтгэлийн аудит, ЦЕГ/ДХАБГ/2023/03

**Аудитын хугацаа:** 2023.03.03-2023.06.03 /удирдлагын шийдвэрээр хойшлогдсон/

**Аудитын багийн ахлагч:** Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал.

**Аудитын багийн гишүүн:** Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул, Д.Рагчаадорж.

**1. ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын 2022 оны төсөв батлагдсантай холбогдуулан “Хууль зүй, дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-нд тусгуулах Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас ирүүлсэн саналыг Санхүү, аж ахуйн албанаас нэгтгэн хүргүүлснээр Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/250, 2022 оны А/52, А/118, А/235, А/318 дугаар нэмэлт тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр хавсралтад хөрөнгө оруулалт 10.5 тэрбум, хоёрдугаар хавсралтад урсгал төсөвт 23.6 тэрбум төгрөгөөр батлагдсан байна.

Цагдаагийн байгууллага нь хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дээрх төлөвлөгөөний хүрээнд 2022 онд төсвийн хөрөнгө оруулалт 10.5 тэрбум, урсгал төсвөөс 23.6 тэрбум, орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрээс 2.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ.

Аудитын ажлын хүрээнд хамарсан Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны худалдан авах ажиллагааны тайлангаас авч үзвэл:

**1.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар:**

“Хууль зүй дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр хавсралтаар төсвийн хөрөнгө оруулалтын зардлаас худалдан авах төсөл арга хэмжээний зардалд 2022 онд нийт 10.5 тэрбум төгрөг тусгаж, хөрөнгө оруулалтын 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 100 хувь буюу 10.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Үүнд:

Барилга байгууламжийн ажлын хүрээнд: Улсын төсвийн 2021-2022 оны хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймгийн Богд сум дахь сум дундын цагдаагийн

тасаг, Сүхбаатар аймаг дахь цагдаагийн газар, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс, Өвөрхангай аймгийн Хужирт сум дахь сум дундын цагдаагийн тасгийн байрны барилга угсралтын ажилд нийт 380.0 сая төгрөг батлагдснаас 2022 онд санхүүжих 280.0 сая төгрөг /шилжих/, Дархан-Уул аймгийн цагдаагийн газар, Баянхонгор аймгийн Богд, Жаргалант сумын цагдаагийн тасгийн барилга, Завхан аймгийн Отгон, Увс аймгийн Бөхмөрөн, Өмнөговь сумын цагдаагийн кобаны барилга, Хэнтий аймгийн Батноров сум, Бэрх тосгон, Баян-Овоо сумын цагдаагийн тасгийн байр, Сэлэнгэ аймгийн Сайхан сум сум дундын цагдаагийн хэлтсийн байр, Архангай аймгийн цагдаагийн газрын барилгын ажилд нийт 13.0 тэрбум төгрөгөөр батлагдаж /шинээр/, 2022 онд санхүүжих нийт дүн 5.8 тэрбум төгрөгийг тус тус олгосон нь нийт барилга байгууламжийн 2022 оны санхүүжилтийн гүйцэтгэл 100.0 хувьтай байна.

Их засварын ажлын хүрээнд: Завхан аймгийн Нөмрөг сумын цагдаагийн кобаны барилга, мөн аймгийн Тэлмэн сумын цагдаагийн хэсгийн байр, Эрүүгийн цагдаагийн албаны барилгын их засвар, нийт шинээр 231.1 сая төгрөг батлагдаж, энэ онд олгосон санхүүжилт 231.1 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Улсын төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламж , их засварын ажлын явц 100 хувийн гүйцэтгэсэн байна.

Тоног төхөөрөмжийн ажлын хүрээнд: Увс аймгийн цагдаагийн газрын авто парк шинэчлэлд 160.0 сая төгрөгийн төсөвт өртөгөөр /шилжих/ батлагдаж, аудитын хамрагдах онд санхүүжих 80.0 сая төгрөг, олгосон санхүүжилт 100 хувьтай хийгдсэн.

### **1.2.Урсгал төсвөөр:**

“Хууль зүй дотоод хэргийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”-ний хоёрдугаар хавсралтаар төсвийн урсгал зардлаас худалдан авах төсөл арга хэмжээний зардалд 2022 онд нийт 23.6 тэрбум төгрөг тусгаж, 37 төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 100 хувь буюу 22.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

### **1.3.Орон нутгийн төсөв, сангийн хөрөнгө, бусад эх үүсвэрээр:**

Орон нутгийн төсвөөр 757.1 сая, сангийн хөрөнгөөр 1.0 тэрбум, бусад эх үүсвэрээр 1.8 тэрбум төгрөг нийт 6 төсөл арга хэмжээний зардалд нийт 3.6 тэрбум төгрөг тусгасан арга хэмжээний гүйцэтгэл 72 хувь буюу 2.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

1.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хүрээнд Экологийн цагдаагийн албанд тусгай тоноглол бүхий автомашин худалдан авахад 110.0 сая төгрөг батлагдаж, нээлттэй цахим тендерээр бэлтгэн нийлүүлэгчээр “Киа моторс Монгол” ХХК шалгарч, 110.0 сая төгрөгийн гэрээ байгуулсан.

2.Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2022 оны захирамжаар Нийслэлийн цагдаагийн удирдах газар нийт 647.1 сая төгрөгийг шийдвэрлүүлж, гүйцэтгэл 612.8 сая төгрөг;

3.Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын сангаас Олон улсын болон улсын чанартай авто зам дагуу байрлах байнгын хяналтын цэг /пост/-ийг улсын дугаар таних зөрчил илрүүлэх болон бусад хяналтын камер, тоног төхөөрөмжөөр тоноглох 1.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий ажлыг Тээврийн цагдаагийн алба шийдвэрлүүлсэн.

4.Байгаль орчны яамны санхүүжилтээр Нийтийн хэв журам хамгаалах, Олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Хүрээлэн буй орчны хяналтын хэлтэст шаардлагатай нисгэгчгүй нисгэгч төхөөрөмж /дрон/ худалдан авахад 48.8 сая төгрөг батлагдаж, бэлтгэн нийлүүлэгчээр “Сүү хүнгий” ХХК шалгарч, 45.6 сая төгрөгийн гэрээг байгуулж, бүрэн нийлүүлэгдсэн.

5. Нийслэлийн шалган нэвтрүүлэх байнгын хяналтын 6 цэгт шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад 68.8 сая төгрөг, бэлтгэн нийлүүлэгчээр “Саммит компьютер технологи” ХХК шалгарч 62.7 сая төгрөгийн гэрээг байгуулж, бүрэн нийлүүлэгдсэн.

6. “Эрдэнэс Тавантолгой” ХХК-ийн санхүүжилтээр Дотоодын цэргийн 810 дугаар ангид туулах чадвар сайтай автомашин худалдан авахад 1.7 тэрбум төгрөгийн нээлттэй тендер шалгаруулалт амжилтгүй болсон тул хуулийн дагуу дараах компаниудтай гэрээ шууд байгуулсан. Үүнд: “Хьюндай моторс” ХХК-тай 152.0 сая, “Таван богд” ХХК-тай 965.3 сая, “Монгол хьюндай автмотив” ХХК-тай 129.0 сая, “Хьюндай моторс монгол” ХХК-тай 480.0 сая төгрөгийн гэрээ тус тус байгуулсан. гэрээг байгуулж, бүрэн нийлүүлэгдсэн.

7. Шалгах тоног төхөөрөмж худалдан авах 94.4 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тендер шалгаруулалтаар “Хайтек интернэйшнл” ХХК шалгарч, 83.4 сая төгрөгөөр гэрээ байгуулсан.

## **2. АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ**

### **2.1. Аудитын зорилго**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаанд гүйцэтгэлийн дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг үнэн зөв бодит мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход чиглэгдсэн болно.

### **2.2. Аудитын хамарсан цар хүрээ**

Дээрх зорилгын хүрээнд дараах чиглэлийн дагуу аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, бусад холбогдох мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Санхүү, аж ахуйн албанаас ирүүлсэн мэдээллээс түүвэрлэн аудитын объектод хамрууллаа.

### **2.3. Аудитын зохион байгуулалт**

Аудитыг хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам, Цагдаа, дотоод цэргийн анги, байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны харилцааг зохицуулсан хууль, тогтоомж, дүрэм, журам, бусад холбогдох бичиг баримттай танилцаж судалсан.

Санхүү, аж ахуйн албанаас ирүүлсэн “Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөө”, гүйцэтгэлийн жилийн эцсийн тайлан болон холбогдох мэдээллийг авч, түүвэрлэх, нэгтгэх аргыг аудитын тайланд ашиглаж, нотлох баримтыг бэлтгэсэн.

Аудитын явцад цугларсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурлан “Урьдчилсан тайлан”-г бичиж, Санхүү, аж ахуйн албанд хүргүүлэн “Удирдлагын тайлбар”-ыг энэхүү тайланд тусгасан.

Аудитын дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулахдаа аудитын явцад цуглуулсан мэдээлэл, нотлох баримтад тулгуурласан болно.

### 3. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

3.1. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны батлагдсан төсвийн урсгал зардлаас 1.6 тэрбум төгрөгийн компьютер, хэвлэгч, хувилагч, сервер, Баян-Өлгий, Ховд аймгийн цагдаагийн газарт болон нөөцөд /хуваарийн дагуу олгохоор/ нийт 639.2 сая төгрөгийн туулах чадвар сайтай автомашин, тусгай зориулалтын автомашины худалдан авалтыг хийсэн байна.

Гэвч 2022 оны төсвийн саналд компьютер, техник, тоног төхөөрөмж худалдан авах зардлыг хөрөнгө оруулалтын төсөвт тусгах санал хүргүүлсэн боловч дээд шатны байгууллагаас урсгал зардалд баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь хэсэгт "...батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь хэсэгт "...батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Өвөрхангай аймгийн Богд сумын сум дундын цагдаагийн тасгийн барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг тус аймгийн Засаг даргад шилжүүлснээр тус аймгийн Засаг даргын Тамгын газраас тендер сонгон шалгаруулалтыг зарлаж, Чусон ХХК шалгарч, барилгын гурвалсан ажлын ЦЕГ/202112004 дугаар гэрээг 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдөр 300.0 сая төсөвт өртөгтэйгээр 2021-2022 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийж гүйцэтгэхээр байгуулжээ.

Дээрх гэрээний нэмэлт өөрчлөлтийг оруулан батлуулснаар Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 40 дүгээр зүйлийн 40.6, Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоол, 2022 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 88-348/2022 тоот магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг үндэслэн гэрээний үнийг 92.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт дүнг 392.2 сая төгрөг болгон гэрээний хугацааг мөн 2023 оны 03 дугаар сарын 1-ний өдөр хүртэл байхаар сунгаж, улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

Барилга, гүйцэтгэлийн ажлын баримтыг үзэхэд 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөр баталгаажсан 1824/2021 бүртгэлийн дугаартай магадлал хийгдсэн бөгөөд төсөвт өртгийн дүн 831.9 сая төгрөг болсон хэдий ч олгосон санхүүжилт 380.0 сая төгрөг байгаа нь 451.9 сая төгрөгийн зөрүүтэй байна.

3.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Өвөрхангай аймгийн Хужирт сумын цагдаагийн тасгийн барилгын ажлыг гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалтаар Гүнчимэгтэй ХХК шалгарч, барилгын гурвалсан ажлын ЦЕГ/202112003 дугаар гэрээг 2021 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 364.9 сая төсөвт өртөгтэйгээр 2021-2022 оны хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хийж гүйцэтгэхээр байгуулжээ.

Ажил гүйцэтгэх гэрээний нэмэлт өөрчлөлтийг оруулан 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр батлуулснаар Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 40 дүгээр зүйлийн 40.6, Улсын Их Хурлын 2021 оны 88 дугаар тогтоол, 2022 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 88-212/2022 тоот магадлалын нэгтгэсэн дүгнэлтийг үндэслэн гэрээний үнийг 169.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт дүнг 534.8 сая төгрөг болгон гэрээний хугацааг мөн 2023 оны 06 дугаар сарын 1-ний өдөр хүртэл байхаар сунгасан.

Ажлын гүйцэтгэлийн талаар тодруулахад барилгын ажил дуусаагүй нь гэрээний 3 дугаар хэсэгт заасан хугацааг хэтрүүлсэн байна.

3.4. Өвөрхангай аймгийн Хужирт сумын цагдаагийн тасгийн барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх гэрээний хэрэгжилтийг шалгахад зураг төслийн "НГ"

ХХК-ны ерөнхий инженерийн 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн №02 дугаар бүхий Барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийсэн тайлангийн А "Барилга угсралтын ажлын үе шат, байдал" хэсэгт:

"Одоогийн байдлаар газар шороо, суурь, 1 давхрын өрлөгийн ажил дууссан, 2 дугаар давхрын өрлөг 70%, гадна шугамын ажил 50% орчим тус тус хийгдсэн байна.

Бусад угсралтын ажил эхлээгүй байна." гэж хяналтын тайланд тусгасан нь 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн №01 дүгээр тайланд тусгагдсантай адил тайлан гаргасан байна./хуулбарлан/

Энэ нь Өвөрхангай аймгийн Хужирт сум дахь цагдаагийн тасгийн барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх №ЦЕГ-2021/218 дугаар гэрээний 3 дугаар зүйлийн 2-т заасны дагуу чанартай хийсэн эсэхтэй нийцэхгүй байна.

Өөрөөр хэлбэл үүргийн биелэлтийг Санхүү, аж ахуйн алба хамтран дүгнээгүй, өөрчлөлт хийгдээгүй байхад санхүүжилтийг олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 5.2-т "Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага болон барилга байгууламж, их засварын ажил гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авч ажиллана" гэсэн заалттай нийцээгүй байна.

**3.5.** Улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэхээр баталсан цагдаагийн кабон барилга /Увс аймгийн Өмнөговь сум/ угсралтын ажил гүйцэтгэх ЦЕГ/202212014 дугаартай 157.5 сая төгрөгийн өртөгтэй гурвалсан гэрээг 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр Энх дормон ХХК, /Бөхмөрөн сум/ угсралтын ажил гүйцэтгэх ЦЕГ/202212013 дугаартай гурвалсан гэрээг 157.5 сая төгрөгийн өртөгтэй гэрээг 2022 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Арвижих Увс ХХК-тай тус тус байгуулжээ.

Энх дормон ХХК, Арвижих Увс ХХК нь гэрээний хугацаанд хийж гүйцэтгэсэн сумын цагдаагийн тасгийн барилгыг комисс чанартай сайн хийгдсэн гэж хүлээн авч ашиглалтад оруулсан байна.

Аудитын явцад Увс аймгийн Өмнөговь, Бөхмөрөн сумын цагдаагийн кобаны барилгыг ашиглаж буй цагдаагийн байгууллагаас тодруулахад уг 2 сумын цагдаагийн кобан барилга нь Монгол Улсын стандарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуй MNS 4990:2015. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага, уг стандартын 5.1 "Ажлын байрны бичил цаг уурын тохиромжтой ба зөвшөөрөгдөх хэмжээ"-нд заасан эрүүл ахуйн шаардлагыг хангаж, халаалтын систем халахгүй байгаа талаар ирүүлсэн нь дулааны холболтыг чанаргүй хийгдсэн гэж үзэхээр байна.

## 4. ДҮГНЭЛТ

**4.1.** Худалдан авах ажиллагааны 2022 оны төлөвлөгөөг хууль журамд заасан хугацаанд боловсруулж, батлуулан, хэрэгжилтийн явц, тайланг Төсвийн тухай хууль болон журмын дагуу тогтоосон хугацаанд дээд шатны байгууллагад хүргүүлсэн байна.

Худалдан авах ажиллагааны "www.tender.gov.mn" цахим системд давхардсан тоогоор нийт 18 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн урилга, үр дүнг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем "tender.gov.mn", "police.gov.mn", "shilendans.gov.mn"-нд болон өдөр тутмын сонин хэвлэлд холбогдох хууль, журмын дагуу байршуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн бөгөөд гүйцэтгэл нь 100 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн



дагуу тендерийн үнэлгээний хороонд хоёроос доошгүй хөндлөнгийн төлөөлөгч оролцуулж, хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлж, зохион байгуулжээ.

**4.2.**Дотоод аудитын явцад нэгтгэж, судалсан баримт, мэдээлэлд үндэслэн үзэхэд Цагдаагийн ерөнхий газраас 2022 онд зохион байгуулагдсан хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа нь хууль, журмын дагуу хугацаандаа, баримт бичгийн бүрдэл чанартай, бүрэн бүрдүүлсэн гүйцэтгэсэн хэдий ч урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн, Өвөрхангай аймгийн Хужирт сумын цагдаагийн тасгийн барилгын ажлын явцад зохиогчийн хяналт хийх гэрээг дүгнээгүй, тайланг хянаагүй /2 дахь/ санхүүжилт олгосон, мөн гүйцэтгэгч Гүнчимэгтэй ХХК нь барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасан хүлээлгэн өгөх хугацааг хэтрүүлсэн, тус аймгийн Богд сумын сум дундын цагдаагийн тасгийн барилга, гүйцэтгэлийн төсөвт Барилгын хөгжлийн төвөөр баталгаажсан 1824/2021 бүртгэлийн дугаартай магадлал хийгдсэн төсөвт өртгийн дүн 831.9 сая төгрөг болсон хэдий ч олгосон санхүүжилт 451.9 сая төгрөгийн зөрүүтэй, Увс аймгийн Өмнөговь, Бөхмөрөн сумын цагдаагийн кобаны барилгын дулааны холболтыг чанаргүй хийгдсэн зэрэг шалтгаан, нөхцлөөс шалтгаалан алдаа зөрчил гарсан гэж дүгнэлээ.

## **5.САНАЛ, ЗӨВЛӨМЖ**

Дотоод аудитын явцад нэгтгэж, судалсан баримт, мэдээлэлд үндэслэн илэрсэн асуудлыг шийдвэрлүүлэх болон цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр дараах санал, зөвлөмжийг Санхүү, аж ахуй албанд хүргүүлэх саналтай байгааг танилцуулж байна. Үүнд:

**5.1.**Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон бүрэн, чанартай гүйцэтгэгдэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах;

**5.2.**Цаашид хөрөнгө худалдан авах зардлыг хөрөнгө оруулалтын төсөвт тусгахаар саналаа дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах;

**5.3.**Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөр 2021 онд баталгаажсан 1824/2021 бүртгэлийн дугаартай магадлал хийгдсэн Өвөрхангай аймгийн Богд сумын сум дундын цагдаагийн тасгийн барилгын төсөвт өртгийн дүн, олгосон санхүүжилтийн зөрүүг тооцож, санхүүжилтийг шийдвэрлэж олгох эсэх талаар судалж, дээд шатны төсөв захирагчид хүргэх;

**5.4.**Өвөрхангай аймгийн Хужирт сумын цагдаагийн тасгийн барилгын ажлыг гүйцэтгэгчээр шалгарсан Гүнчимэгтэй ХХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилт, барилгын үйл явцад захиалагчаас тавих хяналтыг нэмэгдүүлэх, барилгын ажлыг эрчимжүүлэх талаар үүрэг чиглэл хүргэж, дорвитой арга хэмжээ авах;

**5.5.**Цаашид барилгын зураг зохиогчийн хяналтыг хийх хамтран ажиллах гэрээний биелэлтийг тооцож, тайланг хянаж, санхүүжилтийг олгож байхад анхаарах;

**5.6.**Увс аймгийн Өмнөговь, Бөхмөрөн сумын цагдаагийн кобаны барилгын дулааны холболтыг холбогдох байгууллагаар шалгуулж, Монгол Улсын стандарт Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуй MNS 4990:2015. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага, уг стандартын 5.1 “Ажлын байрны бичил цаг уурын тохиромжтой ба зөвшөөрөгдөх хэмжээнд заасан эрүүл ахуйн шаардлагыг хангаж, халаалтын системийг сайжруулах;

**5.7.**Цаашид улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх шинээр барилга барих ажлуудыг тухайн ондоо багтаан хэрэгжүүлэх, он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөж

хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулахгүй байх талаар судалж, анхаарч ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2024 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

## **6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР**

Аудитын тайлангийн төслийг Санхүү, аж ахуйн албанд хүргүүлсний дагуу тус нэгжээс 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 14/1232 дугаар албан бичгээр илэрсэн асуудал нэг бүрт “Удирдлагын тайлбар” ирүүлсэн болно. Уг тайлбарт:

Илэрсэн асуудал 5.1-т: Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хязгаарт тусгуулах хөрөнгө /компьютер тоног төхөөрөмж, машин.../ худалдан авах саналыг 2021 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн 01/478 дугаартай албан бичгийг дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, батлагдах үед уг санал хасагдсан тул зайлшгүй шаардлагаар урсгал зардлаас худалдан авалтыг хийсэн;

Илэрсэн асуудал 5.2-т: Тухайн жилийн төсөвт /Өвөрхангай аймгийн Богд сумын цагдаагийн тасгийн барилга/ тусгагдаагүй тул 2024 оны төсвийн төсөлд гэрээний зөрүү 531.9 сая төгрөгийн саналыг “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем” программд оруулсан;

Илэрсэн асуудал 5.3-т: Гэрээний тусгай нөхцлийн 46 дахь заалтыг үндэслэн гэрээ дүгнэхэд гэрээний үнийн дүнгээс 0.02 хувиар алданги тооцно;

Илэрсэн асуудал 5.4-т: Өвөрхангай аймгийн Хужирт сумын цагдаагийн тасгийн барилгын зураг зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэгч НГ ХХК-д гүйцэтгэл 2-ын 1 хувь болох 2.1 сая төгрөгийг бодит гүйцэтгэлийг хянаж олгосон;

Илэрсэн асуудал 5.5-т: Увс аймгийн Бөхмөрөн, Өмнөговь сумын цагдаагийн кобаны барилгын дулаанаар хангагч байгууллагын хүчин чадал хүрэхгүй мөн дулааны узель дээрх зарцуулалт тохируулах хаалт багадсан байж болох талтай талаар дурдсан байна.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Улаанбаатар хот, 15160. Утас 70191087 Факс: (976) 70191087  
Цахим шуудан: info@police.gov.mn  
Цахим хуудас: www.police.gov.mn

2023.05.01 № 6/4122  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

МЭДЭЭЛЭЛ, ДҮН ШИНЖИЛГЭЭ,  
ШУУРХАЙ УДИРДЛАГЫН АЛБАНЫ  
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА  
П.БАТБААТАР ТАНАА

Дотоод аудитын тайлан хүргүүлэх тухай

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.2-т заасны дагуу “Цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа мэдээллийн сан, программ хангамжийн ашиглалт, давхардлын байдал”-д хийсэн дотоод аудитын тайланг хүргүүлж байна.

Удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлт, үр дүнг 2023 оны 08 дугаар сарын 08-ны дотор ирүүлж, хамтран ажиллана уу.

Холбогдох албан тушаалтан: Дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал /Утас: 70191048, 91999033/.

Хавсралт 14 хуудастай.



Цагдаагийн Ерөнхий Газар  
Цагдаагийн Ерөнхий Газар  
Дотоод Хяналт-Аюулгүй Байдлын Газрын Дарга  
Довдон Манлайбаатар  
2023.05.01 14:33

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа мэдээллийн сан, программ хангамжийн ашиглалт, давхардлын байдалд дотоод аудит хийсэн талаар”

2023 оны 04 дүгээр  
сарын 27-ны өдөр

№ 1/72

Улаанбаатар  
хот

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөөний 2.2-т заасны дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал би “Цагдаагийн байгууллагад ашиглаж байгаа мэдээллийн сан, программ хангамжийн ашиглалт, давхардлын байдал”-д дотоод аудит хийлээ.

**Нэг. Өнөөгийн нөхцөл байдлын талаар:**

Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсын Их Хурлаас баталсан “Шинэ сэргэлтийн бодолго”, Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацийг хөгжүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж, “Цахим үндэстэн” болох уриалгыг дэвшүүлсэн.

Дээрх ажлын хүрээнд төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийн сэтгэл ханамжид хүрсэн төрийн үйлчилгээ үзүүлэх, дижитал дэд бүтэц, цахим засаглал, мэдээллийн аюулгүй байдал, тоон бичиг үсгийн чадавх, инноваци үйлдвэрлэл, үндэсний хөгжлийн хурдасгуур гэсэн стратегийн 6 зорилтыг баталсан.

Уг зорилтуудыг хэрэгжүүлэхэд төрийн бүтээмж, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэх, мэдээллийн аюулгүй байдал буюу цахим орчинд үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог бүрдүүлэх, орчин үеийн техник технологийг нэвтрүүлэх замаар алба хаагчдын мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг дээшлүүлж, мэдээллийн бүрэн бүтэн /МББ/, нууцлагдсан /МНБ/, хүртээмжтэй /МХБ/ байдлыг хангах шаардлага тавигдаж байна.

Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлийн санд 2021 онд 2.173.426, 2022 онд 3.442.614, 2023 онд 633.593 нийт 6.249.633 мэдээлэл бүртгэгдсэн байна.

Тус статистикийн сангийн 1 алба хаагч жилд 688.522, сард 57.376, ажлын нэг өдөрт 2608 мэдээлэлд хяналт тавьж байна.

Мэдээллийн сангийн бүрдүүлэлт, хяналтыг сайжруулах зорилгоор 2022 онд “Мэдээллийн сангийн тулгалт” арга хэмжээг улсын хэмжээнд хоёр сарын хугацаатай зохион байгуулж, 2010 оноос хойших ажиллагаанд байгаа гэмт хэргийн мэдээлэл бүрийг шүүж, Улсын ерөнхий прокурорын газартай хамтарсан хэргийн тулгалтыг хийснээр мэдээллийн санд шивэгдээгүй 115 хэргийг нөхөн шивүүлж, тус сангийн алба хаагчдын заавартай буцаажээ.

Санд бүртгэгдсэн зөрчилтэй болон архивласан мэдээлэл өмнөх оноос 25.5 хувиар өссөн нь шат шатанд тавих дотоод хяналт сайжирсан, нөгөө талаас нэгжийн мэдээлэл, судалгааны алба хаагчдыг сурган дадлагажуулж, хамтарч ажилласны үр дүн гэж үзлээ.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Монгол Улсад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо бүртгэл хөтлөх /код 701/”, “Зөрчлийн мэдээллийн сан бүрдүүлэх /код

702/” журам болон Цагдаагийн ерөнхий газрын даргын “Жагсаалт шинэчлэн батлах тухай” 2020 оны А/128 дугаар тушаалын дагуу цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн статистик мэдээ, тайланг сар бүр 23 төрлийн /нийт 575/ статистик, мэдээ тайланг боловсруулж, цагдаагийн байгууллагын дотоод сүлжээ, <http://police.gov.mn/>, <http://information.police.gov.mn/> цахим хуудсанд байршуулж, сар бүрийн мэдээг Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд зэрэг 36 байгууллага, албан тушаалтанд хүргүүлсэн байна.

Лавлагааны сан нь цахим мэдээллийн болон архивын сантай бөгөөд цахим сандаа давхардсан тоогоор 380,000 орчим хүний мэдээллийг оруулж, архивын санд шүүхээр ял шийтгэгдсэн иргэдийн 450,000 орчим ял шийтгэлийн тэмдэглэл, ялтны судалгааны карт, 1960-2023 онд хорих болон баривчлах ял эдлээд суллагдсан хүмүүсийн 208.900 ширхэг ялтны хувийн хэргийг архивлан хадгалж байна.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд 2009-2022 оны байдлаар 81 төрлийн программ хангамжийг ашиглаж байсан бөгөөд 2023 онд ашиглалт хангалтгүй байгаа 4, шинэ программ хангамж нэвтрүүлсэн тул шаардлагагүй болсон 6, шинээр хөгжүүлэлт хийж, дахин нэвтрүүлэхээр төлөвлөж байгаа 4 нийт 14 программ хангамжийн ашиглалтыг түр зогсоосон байна. Одоо ашиглаж байгаа 67 программ хангамж байна /Хавсралт №1-ээс үзнэ үү/.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан дижитал шилжилт хийх, шаардлагатай программ хангамжийг хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлан шинжлэн тодорхойлж, зохиомжлох, хөгжүүлэх, тестлэх, турших, нэвтрүүлэх, нэмэлт засвар, өөрчлөлт, шинэчлэлт хийх үйл ажиллагааг Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Мэдээллийн технологийн хэлтэс хариуцан ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/206 дугаар тушаалаар баталсан “Программ хангамж боловсруулалт /код 700.2/102/ журам”-ын 700.2/102.3.1-д заасан дараах дарааллын дагуу программ хангамжийг боловсруулж, ашиглалтад оруулан ажиллаж байна. Үүнд:

- Захиалагч талаас албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн программ хангамж шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт, засвар, шинэчлэлт хийх эсэхийг шийдвэрлэх;
- Захиалагч талын саналыг үндэслэн, шаардлагатай хүн хүч, захиалгыг хэрэгжүүлэх хугацааг тогтоох;
- Захиалагч талын хэрэгцээ шаардлагад тулгуурлан, харилцан тохиролцсоны үндсэн дээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд шаардлагатай программ хангамжийн системийн шинжилгээг боловсруулж батлах;
- Системийн шинжилгээний дагуу шаардлагатай программ хангамжийг хөгжүүлэх;
- Программын өөрчлөлтүүдийг хянаж, хийсэн өөрчлөлтүүдэд тайлбар өгөх;
- Программ хангамжийн хувилбарын дугаарыг тогтоох;
- Программ хангамж, сүлжээний хэвийн, найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байгаа эсэхийг тестлэх;
- Захиалагч байгууллагын саналыг үндэслэн программ хангамжийг боловсруулж дууссаны дараа программ хангамж хүлээлцэх актыг үйлдэж захиалагч талд хүлээлгэн өгөх зэрэг болно.

Захиалагч талаас цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай бус, нэг удаагийн шинжтэй, мэдээллийн технологийн бодлого, зорилттой нийцээгүй, мэдээллийн системийн удирдлага болон хөгжүүлэлт, гүйцэтгэлийн хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх, цаашид мэдээллийн системийг хөгжүүлэлтэд ямар зардал гарах, түүний хэвийн ажиллагааг хэрхэн ханган ажиллах, албаны нууцад хамаарах мэдээллийг яаж хамгаалах талаарх бодлого, төлөвлөлт байхгүй санал, хүсэлт ирүүлж байгаа нь цагдаагийн байгууллагад ашиглагдаж буй программ хангамжийн тоог зохиомлоор өсгөх, программ хангамж хөгжүүлэгч алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлэх, нийт алба хаагчдын үйл ажиллагаанд үр дүн, үр нөлөө багатай, мэдээлэл нь бүрэн гүйцэт бус, олон нийтэд хүртээмжгүй, мэдээллийн нууцлал хангалтгүй программ хангамжийг боловсруулж, үр ашиггүй зардал гаргах, байгууллагын сервер, өгөгдлийн сангийн нөөцийг багасгах эрсдэлийг үүсгэж байна.

Энэ нь тухайн захиалга ирүүлж байгаа албан тушаалтнуудын программ хангамжийн талаарх мэдээлэл хомс, мэдээллийн технологийн бодлого, зорилт, мэдээллийн системийн удирдлага болон хөгжүүлэлт, гүйцэтгэлийн хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлэх талаарх дадлага, туршлага дутмаг, зөвхөн алба, нэгжийн хэмжээнд ашиглалт, хандалт бага, мэдээлэл бүрэн бүтэн, хүртээмжтэй биш, нууцлал хангалтгүй программ хангамжийг боловсруулдаг, цаг хугацаа өнгөрөх тусам ашиглалт байхгүй болдог, мэргэшсэн алба, нэгж, ажилтнуудаас зөвлөмж мэдээлэл, санал авдаггүй, шууд санал, хүсэлтээ ирүүлдэг зэргээс шалтгаалж байна.

Иймд цагдаагийн байгууллагын мэдээллийн технологийн бодлого, зорилттой уялдуулан Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Мэдээллийн технологийн хэлтсээс цагдаагийн байгууллагын хэмжээнд тухайн жилд ямар программ хангамж боловсруулах талаар нэгжүүдээс санал авч, жилийн төлөвлөлтийг хариуцан зохион байгуулж, Цагдаагийн төв байгууллагын даргаар баталгаажуулж, хэрэгжилтийг бүрэн хариуцаж ажиллах шаардлагатай байна.

Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй программ хангамжийг шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт, засвар, шинэчлэлт хийх ажлын талаар санал гаргаж байгаа захиалагч нэгж нь Цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулж, шийдвэрлүүлж байх зохицуулалтыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/206 дугаар тушаалаар баталсан “Программ хангамж боловсруулалт /код 700.2/102/ журам”-д шинээр тусгах нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагын программ хангамжийг боловсруулж, нэвтрүүлэх үйл ажиллагааны нэгдсэн бодлого, төлөвлөлт алдагдсанаас нэг удаагийн шинжтэй цөөн хэрэглэгчтэй ашиглалт хангалтгүй программ хангамжууд дийлэнх хувийг эзэлж байгаа тул Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо /ISO 27001/-г нэвтрүүлэх, мэдээллийн бүрэн бүтэн /МББ/, нууцлагдсан /МНБ/, хүртээмжтэй /МХБ/ байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхийг одоо ашиглаж байгаа 67 программ хангамж нэг бүрээр нягтлан үзэх, хэрэглэгч болох цагдаагийн байгууллагын нийт алба хаагчдаас түүвэрлэн программ хангамжийн ашиглалтын талаар сэтгэл ханамжийн судалгаа авах, түүний мөрөөр хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөх, биелэлт, үр дүнг тооцох, жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу алба хаагчдаар гүйцэтгүүлж байгаа нь тэдний ажлын ачааллыг зохиомлоор нэмэгдүүлж байгааг таслан зогсоох, байгууллагын удирдлага, алба хаагчдад зориулсан цахим шилжилт, программ хангамжийн талаар сургалт зохион байгуулах, мэдээлэл өгөх, мэдээллийн аюулгүй байдлын шаардлага хангаагүй программ хангамж, системийг хөгжүүлэх ажлыг

зогсоох зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Дээрх арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлээгүйгээс программ хангамжийн хэвийн үйл ажиллагаа алдагдах, байгууллагын сервер, өгөгдлийн сангийн нөөц хомсдох, мэргэшсэн алба хаагчдын шилжилт хөдөлгөөнөөс шалтгаалан программ хангамж хариуцах эзэнгүй орхигдох, хөгжүүлэлт зогсох, албаны нууц мэдээлэл алдагдах, хэрэглэгч нарын мэдлэг, ур чадвар дутмагаас мэдээллийн сангийн баяжилт хийгдэхгүй байх, программ хангамжийн ашиглалт буурах зэрэг эрсдэл үүсэхээр байгааг анхаарах нь зүйтэй.

### **Хоёр. Дүгнэлт:**

Цагдаагийн байгууллагын мэдээллийн технологийн бодлого, зорилттой уялдуулсан программ хангамж, мэдээллийн сангийн үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, түүнд тавих дотоод хяналт сул, эрх зүйн зохицуулалт хийдэлтэй байна гэж дүгнэж байна.

Иймд Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Мэдээллийн технологийн хэлтсээс цагдаагийн байгууллагын хэмжээнд тухайн жилд ямар программ хангамж боловсруулах талаар нэгжүүдээс санал авч, жилийн төлөвлөлтийг хариуцан зохион байгуулж, Цагдаагийн төв байгууллагын даргаар баталгаажуулж, хэрэгжилтийг бүрэн хариуцаж ажиллах, тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй программ хангамжийг шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт, засвар, шинэчлэлт хийх ажлын талаар санал гаргаж байгаа захиалагч нэгж нь Цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулж, шийдвэрлүүлж байх зохицуулалтыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/206 дугаар тушаалаар баталсан “Программ хангамж боловсруулалт /код 700.2/102/ журам”-д шинээр тусгуулах саналаа боловсруулж Хуулийн хэлтэст хүргүүлэх нь зүйтэй.

Цагдаагийн байгууллагын хэмжээнд одоо ашиглаж байгаа 67 программ хангамжууд нь “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо /ISO 27001/ стандарт”-д заасан мэдээллийн бүрэн бүтэн /МББ/, нууцлагдсан /МНБ/, хүртээмжтэй /МХБ/ байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийж, шаардлага хангаагүй программ хангамжийг зогсоох, ашиглалтаас хасах, программ хэрэглэгч нэгжийн алба хаагчдад цахим шилжилт, программ хангамжийн талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл өгөх, тэднээс сэтгэл ханамжийн судалгаа авч цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөж, биелэлт, үр дүнг тооцож, дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Мэдээллийн технологи, программ хангамжийн талаар мэргэшсэн, чадварлаг алба хаагчдын хомсдол үүсэх эрсдэл байгааг анхаарч алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажлын ачаалал, үр дүн, бүтээмжид суурилсан цалин, урамшуулал олгох боломжийг судалж шийдвэрлүүлэх, албаны нууцыг хадгалах, хамгаалах сэдвээр ажлын байрны сургалтыг тогтмол зохион байгуулах, цагдаагийн албанд дасан зохицох асуудалд анхаарч ажиллах нь зүйтэй.

### **Гурав. Санал:**

3.1. Цагдаагийн байгууллагын хэмжээнд одоо ашиглаж байгаа 67 программ хангамжууд нь “Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо /ISO 27001/ стандарт”-д заасан мэдээллийн бүрэн бүтэн /МББ/, нууцлагдсан /МНБ/, хүртээмжтэй /МХБ/ байдлын шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд хяналт шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөж, биелэлт, үр дүнг тооцож, дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах /МДШШУА, МТХТ/;

3.2. Цагдаагийн байгууллагын мэдээллийн технологийн бодлого, зорилттой уялдуулан Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээллийн технологи, холбооны төвийн Мэдээллийн технологийн хэлтсээс цагдаагийн байгууллагын хэмжээнд тухайн жилд ямар программ хангамж боловсруулах талаар нэгжүүдээс санал авч, жилийн төлөвлөлтийг хариуцан зохион байгуулж, Цагдаагийн төв байгууллагын даргаар баталгаажуулж, хэрэгжилт, үр дүнг тооцож ажиллах /МДШШУА, МТХТ/;


3.3. Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдаагүй программ хангамжийг шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт, засвар, шинэчлэлт хийх ажлын талаар санал гаргаж байгаа захиалагч нэгж нь Цагдаагийн төв байгууллагын даргад танилцуулж, шийдвэрлүүлж байх зохицуулалтыг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/206 дугаар тушаалаар баталсан “Программ хангамж боловсруулалт /код 700.2/102/ журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ХүХ, МДШШУА, МТХТ/;

3.4. Программ хэрэглэгч нэгжийн алба хаагчдад цахим шилжилт, программ хангамжийн талаар сургалт зохион байгуулж, мэдээлэл өгөх, тэднээс сэтгэл ханамжийн судалгаа авч цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг төлөвлөж, биелэлт, үр дүнг тогтмол тооцож байх /МДШШУА, МТХТ/;

3.5. Мэдээллийн технологи, программ хангамжийн талаар мэргэшсэн, чадварлаг алба хаагчдын хомсдол үүсэх эрсдэл байгааг анхаарч алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний ажлын ачаалал, үр дүн, бүтээмжид суурилсан цалин, урамшуулал олгох боломжийг судалж шийдвэрлүүлэх, албаны нууцыг хадгалах, хамгаалах сэдвээр ажлын байрны сургалтыг тогтмол зохион байгуулах /ХНХ, МДШШУА/;

3.6. Зөвлөмжийн биелэлтийг заалт тус бүрээр гаргаж, 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлж, биелэлт, үр дүнг тооцуулах саналтайг Танд илтгэн танилцуулъя.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Ж.БОЛД

Удирдлагын шийдвэр:.....  
.....  
.....

ТАНИЛЦСАН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА




П.ОРОСТОГОО

ХЯНАСАН:  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Д.МАНЛАЙБААТАР

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:  
МӨН ГАЗРЫН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



М.АЗЖАРГАЛ



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлийн байдалд дотоод аудит хийсэн талаар”

2023 оны 04 дүгээр  
сарын 05-ны өдөр

№ 1/49

Улаанбаатар хот

Цагдаагийн ерөнхий газрын даргаас өгсөн үүргийн дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал, Хүний нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Батцэцэг, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Онцгой нөхцөл байдал, шуурхай удирдлага зохицуулалтын хэлтсийн системийн ахлах шинжээч, цагдаагийн дэд хурандаа Ч.Мөнхбаатар нар “Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс, Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлийн байдал”-д дотоод аудит хийлээ.

**Нэг. Өнөөгийн нөхцөл байдлын талаар:**

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтсийн үйл ажиллагаа нь Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/64 дугаар тушаалаар баталсан “Штабын бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Шуурхай удирдлагын үйл ажиллагаа /код 200/”, “Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх /код 201/”, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.3, 11 дүгээр зүйлийн 11.1.1, “Шуурхай удирдлагын үйл ажиллагаа /код 200/”, “Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх /код 201/”, Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл хүлээн авах /код 202/”, “Гэмт хэрэг, зөрчлийн газрыг хамгаалах /код 205/”, “Хэргийн газрын үзлэг хийх /код 206/”, “Мэдээллийн технологи, харилцаа холбооны бодлого, үйл ажиллагааг зохицуулах /код 700/” журмуудаар зохицуулагдаж байна.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээлэл, шуурхай удирдлагын төв нь Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2010 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 42/123/246 дугаартай тушаалаар байгуулагдсан бөгөөд бүтэц, орон тоог уг тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан байна.

Тус төв нь бүтэц зохион байгуулалтын хувьд Захиргааны удирдлагын, Техник ашиглалтын, Шуурхай удирдлагын /102/, Шуурхай удирдлагын /103/, Шуурхай удирдлагын /101,105/ гэсэн 5 хэлтэстэй ба өдөр тутмын үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны болон Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Эрүүл мэндийн болон Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Гамшгаас хамгаалах болон Галын аюулгүй байдлын тухай хууль, “Шуурхай удирдлагын үйл ажиллагаа /код 200/”, “Ноцтой гэмт хэргийн талаар мэдээлэх /код 201/”, “Мэдээллийн технологи, харилцаа холбооны бодлого, үйл ажиллагааг зохицуулах /код 700/” журмуудаар зохицуулагдаж байна.

Нэгжийн нэршил	Чиг үүрэг	Бүтэц, зохион байгуулалт	Орон тоо
Мэдээлэл, шуурхай удирдлагын төв	Гэмт хэрэг, зөрчил, гамшиг, осол, гал түймэр, эмнэлгийн яаралтай тусламжийн дуудлага мэдээллийг хүлээн авах, бүртгэх, дамжуулах, алба, нэгжийн үйл ажиллагааг уялдуулан холбож, шуурхай удирдлагаар болон цагдаагийн төв байгууллагын удирдлагыг шаардлагатай мэдээллээр шуурхай хангах	МДШШУА	161
Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс	Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд хоногийн хугацаанд авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, онцлог мэдээ, мэдээллээр Цагдаагийн ерөнхий газрын удирдлагыг шуурхай хангаж, өгсөн үүрэг, чиглэлийн хэрэгжилтийг хангуулахаар холболт, зохицуулалтыг зохион байгуулах, Шуурхай удирдлагын штабын албаны бэлэн байдлыг хангуулж, удирдлагын шийдвэрээр штабыг дэлгэн ажиллуулж, Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хооронд мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, харилцан ажиллагааг уялдуулан зохицуулах	МДШШУА	10
Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтэс	Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавих, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах хойшлуулшгүй ажиллагааг зохион байгуулах, хүч хэрэгслийг оновчтой хуваарилах, энэ чиглэлээр үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож, шуурхай байдлыг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах	НЦУГ	39

Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн Захиргааны удирдлагын хэлтэс нь /30/ төвийн дарга-1, захиргааны удирдлагын хэлтсийн дарга-1, санхүү, аж ахуйн тасгийн дарга-1, ахлах байцаагч, ахлах мэргэжилтэн, мэргэжилтэн-6, ахлагч-13, энгийн-8, Техник ашиглалтын хэлтэс нь /34/ дарга-1, техник ашиглалтын инженер-11, систем ашиглалтын тасаг-9, телехяналтын ашиглалтын тасаг-13, Шуурхай удирдлагын хэлтэс /102/ нь /42/ дарга-1, мэдээлэл, судалгаа хариуцсан ахлах мэргэжилтэн-1, ерөнхий зохицуулагч-4, мэдээлэл хүлээн авагч-36, Шуурхай удирдлагын хэлтэс /103/ нь /26/ дарга-1, сургалт хариуцсан ахлах ажилтан-1, ахлах зохицуулагч-8, мэдээлэл хүлээн авагч-16, Шуурхай удирдлагын хэлтэс /101,105/ нь /29/ дарга-1, ерөнхий зохицуулагч-4, ахлах зохицуулагч-4, шинжээч, ахлах зохицуулагч-4, мэдээлэл хүлээн авагч-12, жолооч-4 нийт 161 орон тоотойгоос 11 орон тоо дутуу нөхөн хангалт хийгдээгүй байна. Дутуу орон тоонд радио холбооны инженер 2, систем хариуцсан инженер 1, мэдээлэл хүлээн авагч 1, галын шинжээч 1, зарлага цагдаа 1, жижүүрийн цагдаа 1, гэрээт үйлчлэгч 3, мужаан 1 шаардлагатай байна.

Мөн албаны Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс нь /10/ дарга 1, системийн ахлах шинжээч 1, ерөнхий зохицуулагч 4, мэдээлэл хүлээн авагч, жижүүрийн цагдаа-4 гэсэн орон тоотойгоос нөхөн хангалт бүрэн хийгдсэн байна.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтэс нь /39/ дарга-1, ерөнхий жижүүр-4, ерөнхий жижүүр /цахим зураглал дүн шинжилгээ хариуцсан/-1, жижүүрийн ахлах офицер-12, жижүүрийн ахлах офицер /цахим зураглал, дүн шинжилгээ хариуцсан/-3, жижүүрийн ахлах мөрдөгч /хэргийн газрын үзлэг/-4, жижүүрийн ахлах мөрдөгч /ГССҮТ/-4, мэргэшсэн шинжээч-3, холбоо, мэдээллийн ахлах инженер-1, холбоо, мэдээллийн инженер-1, цагдаа жолооч-1, жижүүрийн цагдаа жолооч-4 гэсэн орон тоотойгоос нөхөн хангалт бүрэн хийгдсэн байна.

Олон улсын туршлагаас судалж үзэхэд, Оросын Холбооны улс, Бүгд Найрамдах Солонгос улс, Бүгд Найрамдах Турк улс, Америкийн Нэгдсэн улсын хувьд иргэдээс ирүүлж байгаа гэмт хэрэг, зөрчил, осол аваар, гал түймэр, эмнэлгийн түргэн тусламжийн дуудлагыг нэг сувгаар “911” эсхүл “112” дугаараар хүлээн авч, “Дуудлагын төв” нь /МШУТ/ холбогдох нэгжүүдэд шилжүүлж, шийдвэрлэлтийн байдлыг цахимаар шууд хянаж, үр дүнг тооцон ажилладаг байна.

Бүтцийн хувьд Дотоод хэргийн яамны шууд удирдлагад эсхүл цагдаагийн төв байгууллагын Дэд даргын эрхлэх асуудлын хүрээний бүтцийн нэгжид харьяалагдаж, бие даасан шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

Хүний нөөцийн хувьд харилцааны болон ёс зүйн тусгай сургалтад хамрагдсан, 15-аас дээш жилийн ажлын туршлагатай алба хаагчдыг мэргэшүүлэх сургалтад хамруулж томилох, эсхүл цэргийн байнгын тэтгэвэрт гарсан, туршлагатай алба хаагчдыг гэрээгээр авч ажиллуулах арга замаар хүний нөөцийг бүрдүүлдэг.

Манай улсын хувьд камерын хяналтын нэгдсэн системд холбогдоогүй, хиймэл оюун ухаан ашиглаж, дата өгөгдөлд дүн шинжилгээ хийх боломжгүй, олон улсын стандарт шаардлагыг хангасан “Дуудлагын төв”, “Шуурхай удирдлагын штаб”-ын барилга байгууламж байхгүй зэргээс шалтгаалан Мэдээлэл, шуурхай удирдлагын төв, Шуурхай удирдлагын штабыг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, нэгдмэл удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх эдийн засаг, хууль, эрх зүйн боломж бүрдээгүй байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох /код 100/ журам”-ын хавсралт 100.23-ын “Дэд дарга”-ын чиг үүрэгт “Цагдаагийн албаны тухай хуульд заасны дагуу нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, ... удирдлагын чиг үүргийг эрхлэх”, мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/14 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга”-ын албан тушаалтын тодорхойлолтын зорилгод “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж, ....мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.”, мөн тодорхойлолтын 1 дүгээр зорилтын 1 дэх хэсэгт “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд албадыг удирдан зохион байгуулж, удирдлагыг мэдээллээр хангах”, Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн 2023 оны “Штабын бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай” А/64 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтад “Шуурхай удирдлагын штабын дарга нь Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга” гэж заасныг үндэслэн “Онцгой нөхцөл байдлын шуурхай

удирдлага, зохицуулалтын хэлтэс"-ийг Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргын эрхлэх асуудлын хүрээний бие даасан нэгж болгон ажиллуулах нь цагдаагийн төв байгууллагын удирдлагыг нэг урсгалаар бодит, давхардал, хийдэлгүй баталгаажсан мэдээллээр хангах, удирдлагын шийдвэр гаргалт шуурхай байх, хэрэгжилт бүрэн хангагдах ач холбогдолтой.

Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтсийн нэршлийг Шуурхай удирдлагын штабын чиг үүрэгтэй уялдуулан "Шуурхай удирдлагын ажиллагааны хэлтэс" болгон өөрчлөх нь зүйтэй.

Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээлэл, шуурхай удирдлагын төв нь Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан 2010 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 42/123/246 дугаартай тушаалаар байгуулагдсан бөгөөд бүтэц, орон тоог уг тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан байна.

Тус төвийн чиг үүрэг, үйл ажиллагаа нь Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаатай давхардал үүссэн асуудал байхгүй бөгөөд харин цагдаагийн төв байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах үйл явцын хувьд мэдээлэл ижил төстэй, утга санаа нэг, давхардсан нөхцөл байдал тогтоогдсон.

Иймд Шуурхай удирдлагын штабын чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, үйлдэгдсэн талаарх мэдээллийг Мэдээлэл, шуурхай удирдлагын төв боловсруулж, цагдаагийн төв байгууллагын удирдлагад шууд танилцуулж, ажлын чиглэл авч байх нь мэдээллийн давхардлыг арилгах, удирдлагыг мэдээллээр шуурхай хангах давуу талтай байна.

Иргэдээс ирүүлж байгаа дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ хийх, удаа дараа, давтан ирүүлж байгаа шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлох, түүний мөрөөр хэрэгжүүлэх дотоод хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/169 дүгээр тушаалаар баталсан "Шуурхай удирдлагын үйл ажиллагаа /код 200/ журам"-ын 200.5.1 /е/ дэх хэсэгт заасны дагуу Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн хэргийн газрын үзлэгийн баг /жижүүрийн ахлах мөрдөгч 4, мэргэшсэн шинжээч 3, жижүүрийн цагдаа жолооч 4/-ийн 11 орон тоог Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд шилжүүлбэл аймаг, нийслэлийн хэмжээний онц хүнд, хүнд гэмт хэргийн дуудлага, мэдээлэлд шуурхай очиж, хэргийн газрын үзлэг хийх, нэгжийн алба хаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангаж, зөвлөгөө, зааварчилга өгөх, тэднийг мэргэшүүлэхэд чухал ач холбогдолтой байна.

Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтэс нь гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтэд хяналт тавих, зарлан мэдээлэх, эрэн сурвалжлах хойшлуулшгүй ажиллагааг зохион байгуулах, хүч хэрэгслийг оновчтой хуваарилах, энэ чиглэлээр үүрэг, чиглэл өгч, үр дүнг тооцож, шуурхай байдлыг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байгаа бөгөөд чиг үүргийн хувьд давхардал, хийдэл байхгүй боловч алба хаагчдын үйл ажиллагааны хувьд давхардал байна гэж үзэхээр байна.

Тус хэлтсийн жижүүрийн ахлах мөрдөгч, мэргэшсэн шинжээч нар 2021 онд 57 хэргийн газрын үзлэг, 65 цогцсын гадны үзлэг биечлэн явуулж, дүүргүүдэд 13 удаа

зааварчилсан, 2022 онд 46 хэргийн газрын үзлэг, 37 цогцсын гадны үзлэг биечлэн явуулж, дүүргүүдэд 50 удаа зааварчилсан байна.

Мөн жижүүрийн ахлах мөрдөгч /ГССҮТ-4/ нар 2021 онд 5550 дуудлага, мэдээлэл хүлээн авч, 919-ийг “102”-т мэдэгдэж, 51 хүнээс тайлбар авч, 77 хүнийг дүүргийн цагдаагийн хэлтэст шилжүүлсэн, 2022 онд 10678 дуудлага, мэдээлэл хүлээн авч, 2920-ийг “102”-т мэдэгдэж, 184 хүнээс тайлбар авч, 126 хүнийг дүүргийн цагдаагийн хэлтэст шилжүүлжээ.

Цахим зураглал, дүн шинжилгээ хариуцсан алба хаагчид цагдаагийн байгууллагын мэдээллийн санд тулгуурлан орчин цагийн дэвшилтэт программ хангамжийн тусламжтайгаар газарзүйн зурган болон тоон хэлбэрт хөрвүүлсэн танилцуулга, мэдээлэл бэлтгэн, дүн шинжилгээ, судалгааг “ARCMAP”, “ARCGIS PRO” программын тусламжтайгаар ерөнхий нутаг дэвсгэрээр 11, дүүргийн нутаг дэвсгэрээр 27 дүн шинжилгээ хийж, удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан байна.

Иймд гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа жижүүрийн ахлах мөрдөгч /хэргийн газрын үзлэг/-4, мэргэшсэн шинжээч-3, жижүүрийн цагдаа жолооч-4 нийт 11 орон тоог Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд, жижүүрийн ахлах мөрдөгч /ГССҮТ/-4 орон тоог Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газрын Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст, цагдаагийн байгууллагын мэдээллийн санд тулгуурлан орчин цагийн дэвшилтэт программ хангамжийн тусламжтайгаар газарзүйн зурган болон тоон хэлбэрт хөрвүүлсэн танилцуулга, мэдээлэл бэлтгэх, дүн шинжилгээ, судалгаа хийх, удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа ерөнхий жижүүр /цахим зураглал дүн шинжилгээ хариуцсан/-1, жижүүрийн ахлах офицер /цахим зураглал, дүн шинжилгээ хариуцсан/-3 нийт 4 орон тоог Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Дүн шинжилгээ, судалгааны хэлтэст тус тус шилжүүлж, үйл ажиллагааны давхардлыг арилгах нь зүйтэй.

#### Хоёр. Дүгнэлт:

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн цагдаагийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт, чиг үүргийн гүйцэтгэлийг оновчтой болгох, цагдаагийн алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, ажлын гүйцэтгэлийн хувиарлалт, арга зүйн хийдэл давхардлыг арилгах, үндсэн чиг үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг хүртээмжийг нэмэгдүүлэх, төвлөрсөн нэгдмэл удирдлагын зарчмыг үнэлэн тооцож дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

**Нэг.** Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтсийг Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргын эрхлэх асуудлын хүрээний шууд харилцах бие даасан нэгж болгож, нэршлийг Шуурхай удирдлагын штабын чиг үүрэгтэй уялдуулан “Шуурхай удирдлагын ажиллагааны хэлтэс” болгон өөрчлөх;

**Хоёр.** Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/169 дүгээр тушаалаар баталсан “Шуурхай удирдлагын үйл ажиллагаа /код 200/ журам”-ын 200.5.1 /е/ дэх хэсэгт заасны дагуу Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн хэргийн газрын үзлэгийн баг /жижүүрийн ахлах мөрдөгч 4, мэргэшсэн шинжээч 3, жижүүрийн цагдаа жолооч 4/-ийн 11 орон тоог Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд шилжүүлэх;

**Гурав.** Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд иргэдээс ирүүлж байгаа дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ тогтмол хийх, удаа дараа шаардаж байгаа, дахин давтан ирүүлж байгаа дуудлага, мэдээллийн шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлох, түүний мөрөөр хэрэгжүүлэх дотоод хяналтын тогтолцоог оновчтой зохион

байгуулах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдах асуудалд анхаарч ажиллах;

**Дөрөв.** Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн жижүүрийн ахлах мөрдөгч /ГССҮТ/ 4 орон тоог Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст шилжүүлэх;

**Тав.** Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн ерөнхий жижүүр /цахим зураглал дүн шинжилгээ хариуцсан/-1, жижүүрийн ахлах офицер /цахим зураглал, дүн шинжилгээ хариуцсан/-3 нийт 4 орон тоог Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Дүн шинжилгээ, судалгааны хэлтэст шилжүүлэх;

**Зургаа.** Шуурхай удирдлагын штабын чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, үйлдэгдсэн талаарх мэдээллийг Мэдээлэл, шуурхай удирдлагын төв боловсруулж, цагдаагийн төв байгууллагын удирдлагад шууд танилцуулж, ажлын чиглэл, үүрэг авч байх зэрэг болно.

Дотоод аудитын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга, Хүний нөөцийн хэлтэс, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын болон Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга нараас албан бичгээр “Удирдлагын тайлбар”-ыг авч, дотоод аудитын тайланд хавсаргаж дүгнэсэн болно.

#### Гурав. Санал, зөвлөмж:

3.1.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтсийг Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргын эрхлэх асуудлын хүрээний шууд харилцах бие даасан нэгж болгож, нэршлийг Шуурхай удирдлагын штабын чиг үүрэгтэй уялдуулан “Шуурхай удирдлагын ажиллагааны хэлтэс” болгон өөрчлөх /ЗУГ, ХНХ/;

3.2.Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/169 дүгээр тушаалаар баталсан “Шуурхай удирдлагын үйл ажиллагаа /код 200/ журам”-ын 200.5.1 /е/ дэх хэсэгт заасны дагуу Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн хэргийн газрын үзлэгийн баг /жижүүрийн ахлах мөрдөгч 4, мэргэшсэн шинжээч 3, жижүүрийн цагдаа жолооч 4/-ийн 11 орон тоог Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд шилжүүлэн албан тушаалын тодорхойлолтыг шинэчилэн боловсоруулах /ЗУГ, ХНХ/;

3.3.Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд иргэдээс ирүүлж байгаа дуудлага, мэдээллийн шийдвэрлэлтийн байдалд дүн шинжилгээ тогтмол хийх, удаа дараа шаардаж байгаа, дахин давтан ирүүлж байгаа дуудлага, мэдээллийн шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлох, түүний мөрөөр хэрэгжүүлэх дотоод хяналтын тогтолцоог оновчтой зохион байгуулах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг удирдах асуудалд анхаарч удирдлага, мэргэжил арга зүй, сургалт, соён гэгээрүүлэх зэрэг зохион байгуулалтаар ханган, шаардлагатай өгөгдөлд үүрэг гүйцэтгэх, хянан тооцож ажиллах талаар арга хэмжээ авч, дүнг тогтоосон хугацаанд ирүүлэх /МДШШУА, МШУТ/;

3.4.Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн жижүүрийн ахлах мөрдөгч /ГССҮТ/ 4 орон тоог Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Мөрдөн шалгах газрын Хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэст удирдлага, мэргэжил арга зүй, хянан тооцох зэрэг үүрэг гүйцэтгэлийг хариуцуулан ажиллуулахаар шилжүүлэх /ХНХ, НЦУГ/;

3.5.Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шуурхай удирдлагын хэлтсийн ерөнхий жижүүр /цахим зураглал дүн шинжилгээ хариуцсан/ 1, жижүүрийн ахлах офицер /цахим зураглал, дүн шинжилгээ хариуцсан/ 3 нийт 4 орон тоог Мэдээлэл, дүн

шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Дүн шинжилгээ, судалгааны хэлтэст шилжүүлэх /ХНХ, НЦУГ, МДШШУА/;

3.6.Шуурхай удирдлагын штабын чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг Онцгой нөхцөл байдлын шуурхай удирдлага, зохицуулалтын хэлтэс, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээр бэлтгэсэн, завдсан, үйлдэгдсэн талаарх мэдээллийг Мэдээлэл, шуурхай удирдлагын төв боловсруулж, цагдаагийн төв байгууллагын удирдлагад шууд танилцуулж, ажлын чиглэл авч байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх /МДШШУА, МШУТ, ОНБШУЗХ/;

3.7.Чиг үүргийн давхардлыг арилгах, орон тооны шилжилт хөдөлгөөн хийхдээ алба хаагчдын одоогийн албан тушаалын шатлал, зэрэглэл, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхад анхаарах /ЗУГ, ХНХ/;

3.8.Биелэлтийг заалт тус бүрээр гаргаж, 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлж, биелэлт, үр дүнг тооцуулж ажиллахыг холбогдох алба, нэгжийн дарга нарт тус тус даалгах саналтайг Танд илтгэн танилцуулъя.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

УДИРДЛАГЫН ШИЙДВЭР: .....

ЗӨВШӨӨРСӨН:  
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ

Ц.НЯМ-ОЧИР

ХЯНАСАН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

С.Д.МАНЛАЙБААТАР

МӨН ГАЗРЫН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

Ж.Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Улаанбаатар хот, 15160, Утас 70191087 Факс: (976) 70191087  
Цахим шуудан: info@police.gov.mn  
Цахим хуудас: www.police.gov.mn

2023.04.10 № 6/3282  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

「ЗУГ, ХНХ, НЦУГ, НХЖХОНАБХА-НЫ」  
ДАРГА НАР ТАНАА

「Дотоод аудитын тайлан хүргүүлэх тухай」

Цагдаагийн төв байгууллагын удирдлагын шийдвэрээр “Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шөнийн эргүүлийн хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлийн байдал”-д хийсэн дотоод аудитын тайланг хүргүүлж байна.

Удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлт, үр дүнг 2023 оны 05 дугаар сарын 05-ны дотор ирүүлж, хамтран ажиллана уу.

Холбогдох албан тушаалтан: Дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал /Утас: 70191048, 91999033/.

Хавсралт 6 хуудастай.



Цагдаагийн Ерөнхий Газар  
Цагдаагийн Ерөнхий Газар  
Дотоод Хяналт-Аюулгүй Байдлын Газрын Дарга  
Довдон Манлайбаатар  
2023.04.10 16:49



ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шөнийн эргүүлийн хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлийн байдалд дотоод аудит хийсэн талаар”

2023 оны 03 дугаар  
сарын 17-ны өдөр

№ 1/50

Улаанбаатар хот

Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд даргаас өгсөн үүргийн дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал би “Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шөнийн эргүүлийн хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлийн байдал”-д дотоод аудит хийлээ.

**Нэг. Өнөөгийн нөхцөл байдлын талаар:**

Эргүүлийн үйл ажиллагаа нь Цагдаагийн албаны тухай хууль, Эргүүл, харуулын дүрэм, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Эргүүлийн үүрэг гүйцэтгэх” /код-401/, “Авто эргүүл ажиллах” /код-402/, “Морьт эргүүл ажиллах” /код-403/ журмуудаар зохицуулагдаж байна.

Улсын хэмжээнд эргүүлийн офицер 363, эргүүлийн цагдаа жолооч 275, эргүүлийн цагдаа 310, нийт 948 батлагдсан орон тоотойгоос 116 орон тоо дутуу, одоогоор 832 алба хаагч эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Үүнээс нийслэлд эргүүлийн офицер 356, эргүүлийн цагдаа жолооч 275, эргүүлийн цагдаа 154, нийт 785 орон тоотойгоос 107 орон тоо дутуу бөгөөд 624 буюу 79.5 хувь нь авто эргүүлд, 161 буюу 20.5 хувь нь явган эргүүлээр ажиллаж байна.

Эргүүлийн үйл ажиллагааг бодлогын түвшинд Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Нийтийн хэв журам хамгаалах хэлтэс /Эргүүлийн үйл ажиллагаа хариуцсан 1 чиглэлийн ахлах байцаагч/, өдөр тутмын удирдлага, зохион байгуулалт, дотоод хяналтыг нийслэлд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газар /Шөнийн эргүүлийн хэлтэс, дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасаг/, орон нутагт аймгийн цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга нар хэрэгжүүлж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/318 дугаар тушаалаар Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шөнийн эргүүлийн хэлтсийг нийслэлд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох, гудамж талбай, олон нийтийн газарт нийтийн хэв журам сахиулах, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн эргүүлийн алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зорилгоор байгуулжээ.

Тус хэлтэс нь дарга 1, тасгийн дарга 2, ахлах байцаагч 2, эргүүлийн офицер 30, цагдаа 40, цагдаа жолооч 3 нийт 78 орон тоотойгоор явган, морьт, мотоцикл болон машинт, дугуйт, завьт, дронт, цахим гэсэн хэлбэрээр эргүүлийн үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Шөнийн эргүүлийн хэлтсийн алба хаагчид 2021-2022 онд 19 гэмт хэргийг халуун мөрөөр илрүүлэн, 32 гэмт хэргийг үйлдэл дээр нь таслан зогсоож, 11 удаагийн хэргийн газрын хамгаалалтад ажиллаж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 822, жолоодох эрхгүй 581, эрэн сурвалжлагдаж байсан 350 хүнийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгч, эрүүлжүүлэх, саатуулах байранд 260, ар гэрт нь 316 хүнийг тус тус хүлээлгэн өгч, нийт зөрчил гаргасан 10133 хүнийг 429.516.000 төгрөг /бэлэн болон бэлэн бусаар/-ийн торгууль оногдуулжээ.

Тус хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, Хууль зүй, дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Нийслэл болон дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс дараах санхүүжилтийг хийсэн байна. Үүнд;

№	Санхүүжилт олгосон газар	Д/д	Санхүүжилтийн үнийн дүн /төгрөг/	Зарцуулалт
1	Хууль зүй, дотоод хэргийн яам	1	500,000,000	Хэлтсийн байр, спорт заалны их засвар
		2	1,416,721,828	Албаны адууны жүчээний цогцолбор
		3	163,867,000	Газар тариалангийн тоног төхөөрөмж
		4	45,022,468	Тариалангийн талбайн хашаа
		5	16,000,000	Нохой болон морьт эргүүлийн адуу тээвэрлэх 2 ширхэг чиргүүл
		6	216,000,000	Морьт эргүүлийн адуун сүрэгт селекц хийх зорилгоор азарга, гүү, эмээлийн тоног хэрэгсэл худалдан авсан
<b>Дүн</b>			<b>2.357.611.296</b>	
2	Нийслэлийн ИТХ-ын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	1	300,000,000	Автомашин, тусгай хэрэгсэл, компьютер, принтер худалдан авах
		2	47,000,000	2021 оны Морьт эргүүлийн адууны урсгал зардал /өвс тэжээл/
		3	126,500,000	2022 оны Морьт эргүүлийн адууны урсгал зардал /өвс тэжээл/
<b>Дүн</b>			<b>347.000.000</b>	
3	Цагдаагийн ерөнхий газар	1	150,000,000	Авто эргүүлийн 4 ширхэг мотоцикл, хамгаалалтын хувцас хэрэгсэл /кросс./
<b>Дүн</b>			<b>150,000,000</b>	
4	Баянзүрх дүүргийн ИТХ-ын дэргэдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	1	10,000,000	4К бичлэг хийх иж бүрэн зургийн аппарат, дрон
<b>Дүн</b>			<b>10,000,000</b>	
<b>Нийт дүн</b>			<b>2.864.611.296</b>	

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор баталсан "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив"-аар тооцож үзэхэд, тус хэлтсийн одоогийн орон тоог 518 алба хаагчаар нэмэгдүүлэх судалгаа гарсан байна.

№	Нэгж	Хороо	Хүн ам	Хөдөлгөөнт чиглэл	Ажиллах алба хаагчийн тоо		Явган чиглэл	Ажиллах алба хаагчийн тоо		Хэрэгцээт орон тоо
					Оф	Цаг		Оф	Цаг	
1	ШЭХ	206	1499130	33	132	132	127	127	127	518

Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргаас өөрийн чиг үүргийн хүрээнд Шөнийн эргүүлийн хэлтсийн үйл ажиллагааг өргөжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг нэмэгдүүлэх зорилгоор эргүүлийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, эргүүлийн үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, программ хангамжийг хөгжүүлэх, ашиглалтыг сайжруулахад шаардагдах төсөв хөрөнгийг судалж, шийдвэрлүүлэх, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл, хамгаалалтын газраас 82 орон тоог Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шөнийн эргүүлийн хэлтэст шилжүүлж авах саналаа Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулсан байна.

Дээрх орон тоог шилжүүлж авснаар нийслэлийн хэмжээнд гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, эргүүлийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, олон улсын жишигт нийцсэн дэвшилтэт техник, технологи, хиймэл оюун ухаанд суурилсан цахим хяналтын тогтолцоог нэвтрүүлэхэд нийслэлийн төр, захиргааны байгууллагын зүгээс дэмжлэг, туслалцаа авах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх ач холбогдолтой гэж үзжээ.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2023 онд дараах санхүүжилтийг хийхээр төсөвт тусгасан байна. Үүнд;

№	Санхүүжилт олгох газар	Д/д	Төсөвт оруулсан үнийн дүн /төгрөг/	Зарцуулагдах ажил	Тайлбар
1	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэдэх Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл	1	1,000,000,000	Шөнийн авто эргүүлд ажиллах бүрэн цахилгаан автомашин худалдан авах	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны төсөвт суулгасан
		2	160,000,000	2023 оны Морьт эргүүлийн урсгал зардал /өвс тэжээл/	
		3	18,000,000	Цагдаагийн байгууллагын GPS.POLICE.GOV программын шинэчлэлт хийх	
		4	12,000,000	Шалгах төхөөрөмжийн 100 ширхэг Юнителийн дата эрхийг 1 жилээр сунгах	
Нийт дүн			1.190.000.000		

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл, хамгаалалтын газрын Эргүүл, тусгай хамгаалалтын хэлтэс нь Цагдаагийн албаны тухай хуулийн 12.1.1-т “Нийтийн эмх замбараагүй байдал үүссэн, террорист халдлага гарсан, онц болон дайны байдал зарласан үед дэг журам сахиулах...”, тараах ажиллагааг гүйцэтгэх”, 12.1.3-т “Гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон, аюул үүссэн үед хорио цээрийн дэглэмийг сахиулах...”, 12.1.5-т “...шаардлагатай

тохиолдолд ...гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объект, ачаа тээшийг түр хугацаагаар хамгаалах”, 12.1.7-д “Нийтийг хамарсан арга хэмжээ, жагсаал, цуглааны үеийн хамгаалалт хийх” заасан чиг үүргийг дарга 1, чиглэлийн ахлах байцаагч 5, эргүүл хамгаалалтын ахлах офицер 1, эргүүл, хамгаалалтын офицер 15, эргүүл, хамгаалалтын цагдаа 120 нийт 142 орон тоотойгоор хэрэгжүүлж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/246 дугаар тушаалаар баталсан “Цагдаагийн байгууллагын чиг үүрэг, эрх хэмжээг тодорхойлох /код 100/ журам”-ын хавсралт 100.23-ын “Дэд дарга”-ын чиг үүрэгт **“Цагдаагийн албаны тухай хуульд заасны дагуу нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, ... удирдлагын чиг үүргийг эрхлэх”**, мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/14 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын дарга”-ын албан тушаалтын тодорхойлолтын зорилгод **“Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж, .....мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.”**, мөн тодорхойлолтын 1 дүгээр зорилтын 1 дэх хэсэгт **“Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд албадыг удирдан зохион байгуулж, удирдлагыг мэдээллээр хангах”** гэж заасны дагуу “Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл, хамгаалалтын газрын Эргүүл, тусгай хамгаалалтын хэлтсээс 82 орон тоог Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шөнийн эргүүлийн хэлтэст шилжүүлэх асуудал нь чиг үүрэг, үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалтын хувьд давхардал, хийдэл үүсгэхгүй бөгөөд тухайн албан тушаалтны эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлүүлэх нь зүйтэй.

Цагдаагийн албаны тухай хуулийн 11.1.2-т “Гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт эргүүл хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих” гэсэн заалтын хэрэгжилтийг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Нийтийн хэв журам хамгаалах хэлтсийн эргүүлийн үйл ажиллагаа хариуцсан 1 чиглэлийн ахлах байцаагч улсын хэмжээнд хариуцаж байгаа нь нэг алба хаагчид ажлын ачаалал үүсгэж байгаа бөгөөд уг албан тушаалын тодорхойлолтод заасан эргүүлийн үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлэх, өдөр тутмын дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, аймаг, нийслэл, дүүргийн эргүүлийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, бодлогын түвшинд шийдвэрийн хувилбар боловсруулах, удирдлагыг бодит мэдээллээр хангах чиг үүргийн хэрэгжилтэд доголдол үүсэх эрсдэлтэй байна.

Иймд тус хэлтэст байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан цахим, эргүүлд хяналт тавих ажил хариуцсан чиглэлийн ахлах байцаагчийн орон тоог судалж, батлагдсан орон тоонд нийцүүлэн шийдвэрлүүлэх нь зүйтэй.

#### **Хоёр. Дүгнэлт:**

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн “Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Шөнийн эргүүлийн хэлтсийн чиг үүрэг, үйл ажиллагаа, үүрэг гүйцэтгэлийн байдал”-д дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж дүгнэсэн. Үүнд:

**Нэг.**Цагдаагийн ерөнхий газрын Дэд бөгөөд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргын санал, цугларсан мэдээллийн нотломжоор Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл, хамгаалалтын газрын Эргүүл, тусгай хамгаалалтын хэлтсээс 82 орон тоог Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын Шөнийн эргүүлийн хэлтэст шилжүүлэх;

**Хоёр.**Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын Шөнийн эргүүлийн хэлтсийн нэршлийг “Эргүүл хяналтын хэлтэс” гэж өөрчлөх;

**Гурав.**Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын Шөнийн эргүүлийн хэлтэс нь өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын хувьд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газарт шууд харьяалуулан бодлого зохицуулалт, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах асуудлыг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны дарга ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийн хүрээнд хариуцаж, ажлын үр дүн, дотоод хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэх;

**Дөрөв.**Цагдаагийн албаны тухай хуулийн 11.1.2-т “Гудамж, талбай болон нийтийн эзэмшлийн бусад газарт таслан зогсоох, урьдчилан сэргийлэх эргүүл хяналт хийх, байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан хяналт тавих” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах ажлыг эрчимжүүлэх, эргүүлийн үйл ажиллагааны үр дүнг бодитой үнэлэх, өдөр тутмын дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, аймаг, нийслэл, дүүргийн эргүүлийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, бодлогын түвшинд шийдвэрийн хувилбар боловсруулах, удирдлагыг бодит мэдээллээр хангах, чиг үүргийн хэрэгжилтэд доголдол үүсэх, алба, алба хаагчийн үүрэг гүйцэтгэлийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Нийтийн хэв журам хамгаалах хэлтэст байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан цахим, эргүүлд хяналт тавих ажил хариуцсан чиглэлийн ахлах байцаагчийн орон тоог судалж, шийдвэрлүүлэх;

**Тав.** Удирдлагын шийдвэрээр орон тооны шилжилт хөдөлгөөн хийхдээ алба хаагчдын одоогийн албан тушаалын шатлал, зэрэглэлийг бууруулахгүй, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхад анхаарч ажиллах.

### **Гурав. Санал:**

3.1. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Эргүүл, хамгаалалтын газрын Эргүүл, тусгай хамгаалалтын хэлтсээс 82 орон тоог Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын Шөнийн эргүүлийн хэлтэст шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ЗУГ, ХНХ, НЦУГ, НХЖХОНАБХА/;

3.2. Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын Шөнийн эргүүлийн хэлтсийн нэршлийг “Эргүүл хяналтын хэлтэс” гэж өөрчлөх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ХНХ, НЦУГ, НХЖХОНАБХА/;

3.3. Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газрын Шөнийн эргүүлийн хэлтэс нь өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын хувьд Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Нийтийн хэв журам хамгаалах газарт шууд харьяалуулан бодлого зохицуулалт, мэргэжил, арга


зүйн удирдлагаар хангах асуудлыг Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба хариуцаж, ажлын үр дүн, дотоод хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэдэг байх /НЦУГ, НХЖХОНАБХА/;

3.4. Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны Нийтийн хэв журам хамгаалах хэлтэст байнгын болон түр ажиллагаатай хянаж-нэвтрүүлэх цэг ажиллуулах дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, бусад арга, техник хэрэгсэл ашиглан цахим, эргүүлд хяналт тавих ажил хариуцсан чиглэлийн ахлах байцаагчийн орон тоог судалж, шийдвэрлүүлэх /ХНХ, НЦУГ, НХЖХОНАБХА/;

3.5. Удирдлагын шийдвэрээр орон тооны шилжилт хөдөлгөөн хийхдээ алба хаагчдын одоогийн албан тушаалын шатлал, зэрэглэлийг бууруулахгүй, эрх зүйн байдлыг дордуулахгүй байхад анхаарч ажиллах /ХНХ, НЦУГ, НХЖХОНАБХА/;

3.6. Зөвлөмжийн биелэлтийг заалт тус бүрээр гаргаж, 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлж, биелэлт, үр дүнг тооцуулах саналтайг Танд илтгэн танилцуулъя.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Ж.БОЛД

УДИРДЛАГЫН ШИЙДВЭР:.....  
.....  
.....

ТАНИЛЦСАН:  
ТЭРГҮҮН ДЭД ДАРГА,  
БРИГАДЫН ГЕНЕРАЛ




Ц.НЯМ-ОЧИР

ХЯНАСАН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА




П.ОРОСТОГОО

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



Д.МАНЛАЙБААТАР

МӨН ГАЗРЫН ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА



М.АЗЖАРГАЛ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны “Түр хяналтын цэг /пост/ байгуулж, алба хаагчдыг ажиллуулах тухай” А/93 дугаарын тушаалын хэрэгжилтэд дотоод аудит хийсэн талаар”

2023 оны 05 дугаар  
сарын 23-ны өдөр

№ 1/92

Улаанбаатар  
хот

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.3-т заасны дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав, Экологийн цагдаагийн албаны Дүн шинжилгээ, хяналт шалгалтын хэлтсийн хяналт шалгалт хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн дэд хурандаа Ц.Баасанхорол нар “Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны “Түр хяналтын цэг /пост/ байгуулж, алба хаагчдыг ажиллуулах тухай” А/93 дугаарын тушаалын хэрэгжилт”-д дотоод аудит хийлээ.

**Нэг. Өнөөгийн нөхцөл байдлын талаар:**

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5 дугаар хэсгийн 5.1.8, Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлал, Уул уурхай, хүнд үйлдвэр, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын “Нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” 169, А/698, А/336, А/242 дугаар хамтарсан тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/113 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, хууль бусаар ашигт малтмал олборлож байгаа иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, гэмт хэргийг илрүүлэх зорилгоор 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд 11 аймгийн 16 газарт түр ажиллагаатай хяналтын цэг /пост/ байгуулж, ажиллуулах тухай Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/93 дугаартай тушаалыг гаргасан байна.

Дээрх тушаалын хавсралтаар Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Төв, Өмнөговь, Завхан, Увс, Сэлэнгэ, Ховд аймгийн нутаг дэвсгэрт байрлах 16 цэг /пост/-ийн байршлыг тодорхой зааж өгчээ.

Хяналтын цэг /пост/-ийн байршил, цар хүрээнд тохируулан үүрэг гүйцэтгэх алба хаагчдын томилгоо, хуваарийг баталж, ажиллах нөхцөл, аюулгүй байдлыг ханган, өдөр тутам хяналт тавьж ажиллахыг дээрх аймгийн цагдаагийн газрын дарга нарт, мэргэжлийн удирдлагаар хангаж, явц байдлыг дүгнэж 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдөр танилцуулахыг Экологийн цагдаагийн албаны даргад үүрэг болгож, тушаалын хэрэгжилт хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд даргад даалгасан байна.

Экологийн цагдаагийн албанаас 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр түр ажиллагаатай хяналтын цэг /пост/-ийг байгуулах 11 аймгийн Засаг дарга нарт хяналтын пост ажиллуулах санхүүжилтийг шийдвэрлэх тухай албан бичиг, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газрын дарга нарт хяналтын цэг /пост/-т ажиллах

алба хаагчдын ажиллах нөхцөл, аюулгүй байдлыг ханган, өдөр тутам хяналт тавих үүрэг, ажлын чиглэлийг хүргүүлж орон нутгийн төсвөөс нийт 246.949.924 төгрөгийн зардлыг шийдвэрлүүлжээ.

Сэлэнгэ аймгийн цагдаагийн газраас Ерөө сумын “Ялбаг”, “Улаан гүүр”, “Өлөнт”, “35-ын ам” гэх газруудад байгуулсан түр ажиллагаатай хяналтын цэг /пост/-т үүрэг гүйцэтгэх алба хаагчдын байрлах байр, тээврийн хэрэгсэл, шатахуун, хоол хүнсний зардалд 100.000.000 төгрөгийг орон нутгийн төсвөөс, тус албанаас үүрэг гүйцэтгэсэн 34 албан хаагчийн хоолны зардалд 9.936.000 төгрөгийг аймгийн цагдаагийн газрын томилолтын зардлаас шийдвэрлүүлсэн байна.

Төв аймгийн цагдаагийн газрын Заамар сумын Сум дундын цагдаагийн хэлтэс, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газраас “Азийн сан” төрийн бус байгууллагатай хамтран Заамар сумын Хайлааст 3 дугаар багийн нутаг “Авдарбаян”, Ерөө сумын Бугант тосгоны “Улаан гүүр” хяналтын цэгт орох, гарах хөдөлгөөнийг хянах боломжтой 360 градус эргэх хүчин чадал бүхий 2 ширхэг хяналтын камерыг байршуулжээ.

Хяналтын цэгт цагдаагийн байгууллагаас 365, орон нутгийн төр захиргааны байгууллагаас 286, нийт 651 алба хаагч, 62 тээврийн хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэн ажилласнаар хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох, мод, ургамал бэлтгэх, ан агнах гэмт хэргийн 87, зөрчлийн 181 үйлдлийг илрүүлж, нийт 412.254.255 төгрөгийн үнэлгээтэй 174 техник хэрэгсэл, эд зүйлийг хураан авч битүүмжилжээ.

Түр ажиллагаатай хяналтын цэг /пост/-ийг байгуулж ажилласнаар Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дархан-Уул, Дорноговь, Завхан, Өмнөговь, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд аймгуудын нутаг дэвсгэрт хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 295 бүртгэгдсэн нь өмнө оны мөн үетэй харьцуулахад 55 нэгжээр буюу 16.0 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна.

Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутаг дэвсгэрт байршуулсан түр ажиллагаатай хяналтын цэг /пост/-т үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчид бичил уурхайгаар ашигт малтмал олборлож байгаа нөхөрлөлүүдэд хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, Засгийн газрын 2022 оны 296 тогтоолоор баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ийн 3.2.12-т “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээ байгуулахын өмнө Бичил уурхайн нөхөн сэргээлтийн аргачлалын дагуу боловсруулсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах барьцаа хөрөнгийг тухайн сумын нөхөн сэргээлтийн дундын дансанд байршуулах” гэсэн заалтыг зөрчсөн Баян-Овоо, Бөмбөгөр, Бууцагаан, Заг сумдын Засаг дарга нарын үйлдлийг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт харьяаллын дагуу шилжүүлжээ.

■ Түр ажиллагаатай хяналтын цэг /пост/ байгуулсан 11 аймгийн 16 газрын хамгаалалтын бүсэд ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн болон нөхөн сэргээлт хийх гэрээ байгуулсан талбайд давхардсан тоогоор нийт 346 механизм-тоног төхөөрөмж, 50.048 тээврийн хэрэгсэл, 143.232 иргэнийг тус тус нэвтрүүлж, хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг үйлдэхээр бэлтгэсэн экскаватор 42, ковш 25, ачааны машин 37, бульдозер 18, алт угаах төхөөрөмж 31, цахилгаан үүсгүүр 28, бусад 32 нийт 213 техник, хэрэгслийг татан гаргажээ.

Цаашид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалт, хяналтын цэг /пост/-ийг



ажиллуулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1-т “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах”, 4-т “нутаг дэвсгэрийнхээ аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх үйл ажиллагаанд харьяалал харгалзахгүйгээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, шаардлагатай бол тухайн аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчинд хортой нөлөөлж буй үйл ажиллагааг өөрөө түдгэлзүүлэн зогсоох буюу уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх”, 10-т “байгалийн нөөцийг төрийн нэрийн өмнөөс хамгаалан, халдашгүй байдлыг нь хангах үүргийг тухайн нутаг дэвсгэртээ хариуцах” гэсэн заалтын хэрэгжилтийг хангах ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэхийн тулд Засаг даргаас шийдвэр гаргуулж, уг үйл ажиллагааг тогтмолжуулах, алба хаагчдын томилолтын зардал, хоолны мөнгө, үүрэг гүйцэтгэх хяналтын цэгийн аюулгүй байдал, орчин нөхцөлийг сайжруулахад шаардагдах төсөв, хөрөнгийг орон нутгийн төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлж байх нь зүйтэй.

Дотоод аудитын хүрээнд Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны А/93 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулсан түр ажиллагаатай хяналтын цэг /пост/-ийн үйл ажиллагаа, алба хаагчдын ажиллах орчин, аюулгүй байдалд учирч болзошгүй дараах эрсдэлүүд /Хавсралтаас үзнэ үү/ байна гэж үзлээ. Үүнд:

- Говь-Алтай аймгийн “Чойгийн ус”, Ховд аймгийн Булган сумын “Цагаан толгой”, Увс аймгийн “Бор хавцал”, Дархан-Уул аймгийн “Цэхэр цөөрөм”, “Бичигт хад”, Сэлэнгэ аймгийн “Улаан гүүр”, “Ялбаг”, “35-ын ам” гэсэн постуудад хүрэх зам бартаа саад ихтэйгээс шалтгаалан хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэл учирсан тохиолдолд шаардлагатай туслалцаа, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхэд хугацаа алдаж очих;

- Бартаа, саад ихтэй зам туулж хүрдэг түр хяналтын постуудад үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг ээлж хүлээлцэхэд албаны тээврийн хэрэгсэл очих боломжгүйгээс алба хаагчид өөрсдийн хувийн тээврийн хэрэгслээр болон тухайн нутаг дэвсгэрт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын тээврийн хэрэгслээр хүргүүлж байгаа нь алба хаагчид ашиг сонирхлын зөрчилд өртөх эрсдэлийг үүсгэх;

- Зарим аймгууд хяналтын постод ажиллах алба хаагчдын хоол, хүнсний зардлыг шийдвэрлээгүй, томилолтын зардал олгодоггүйгээс алба хаагчдад санхүүгийн хүндрэл үүсэх, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх;

- Түр ажиллагаатай ихэнх хяналтын постуудын байр ариун цэвэр, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангахгүй байгаагаас алба хаагчдын эрүүл мэндэд хохирол учрах;

- Зарим алба хаагчдыг ойр ойрхон хугацаанд, олон хоногоор хяналтын постод үүрэг гүйцэтгүүлж байгаагаас алба хаагчдын ар гэр, ахуй амьдрал хаягдах, гэр бүлийн таагүй харилцаа үүсэх, алба хаагчид сэтгэлзүйн дарамтад орох;

- Хяналтын пост байрлаж буй газарт тог цахилгаан, цахим сүлжээ, холбоо мэдээллийн хэрэгсэл байхгүйгээс хоол хүнс муудах, гар утас, холбооны болон

тусгай хэрэгсэл цэнэглэх, үүрэг гүйцэтгэлт, нөхцөл байдлаа удирдлагад танилцуулахад хүндрэл үүсэх;

- Ундны усаа зөөх, төвтэй холбоо барих, эргүүл хийх зэргээр түр хяналтын постоос багагүй зайд явах үед алба хаагч зэрлэг амьтдын дайралтад өртөх, төөрөх тохиолдол гарах;

- Хяналтын постод үүрэг гүйцэтгэхэд дуран, дрон, туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл, холбоо мэдээллийн хэрэгслүүд дутагдалтай байгаагаас алба хаагчдын аюулгүй байдалд эрсдэл үүсэх;

- Алба хаагчид төрийн болон бусад байгууллагын ажилтан, алба хаагчидтай хамтран цөөн тоогоор үүрэг гүйцэтгэдгээс шалтгаалан хууль бусаар ашигт малтмал олборлодог иргэд шөнийн цагаар халдах, хяналтын пост руу дайрч орох, алба хаагчдын тавьсан шаардлагыг эсэргүүцэх зэрэг эрсдэлүүд үүсэхээр байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 7-д "...байгаль орчныг хамгаалах, түүний баялгийн нөөцийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх талаар төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагад аргачилсан туслалцаа, санхүүгийн дэмжлэг үзүүлэх", 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 4, 10 дахь заалтын хэрэгжилтийг хангах, алба хаагчдад учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн Засаг даргаас хяналтын цэгт ажиллах алба хаагчдын томилолтын зардал, хоолны мөнгө, үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай машин техник, түр амьдрах байр, орон сууц /пост/-ны асуудлыг шийдвэрлэсэн тохиолдолд алба хаагчдаар үүрэг гүйцэтгүүлж байхад анхаарч ажиллах шаардлагатай байна.

#### **Хоёр. Дүгнэлт:**

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны "Түр хяналтын цэг /пост/ байгуулж, алба хаагчдыг ажиллуулах тухай" А/93 дугаарын тушаалын хэрэгжилтийг "Хангалттай" гэж үнэлж дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

**Нэг.** Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 7, 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 4, 10 дахь заалтын хэрэгжилтийг хангах, алба хаагчдад учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн Засаг даргаас хяналтын цэгт ажиллах алба хаагчдын томилолтын зардал, хоолны мөнгө, үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай машин техник, түр амьдрах байр, орон сууц /пост/-ны асуудлыг шийдвэрлэх боломжийг судалсны үндсэн дээр эрх зүйн акт /тушаал/-ыг гаргуулж байх нь хэрэгжилт хангагдах үндсэн нөхцөл болохыг анхаарах;

**Хоёр.** Хяналтын цэг /пост/-ийн байршилд үүрэг гүйцэтгэх алба хаагчдын ажиллах нөхцөл, аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулах нь тухайн аймгийн цагдаагийн газрын даргын "албан тушаалын тодорхойлолт"-д заасан үндсэн чиг үүрэг гэдгийг ойлгон ухамсарлаж ажиллах;

**Гурав.** Цаашид байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, байгалийн нөөцийг зохистой ашиглах, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын цэг /пост/-ийг ажиллуулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргуулж, уг үйл ажиллагааг тогтмолжуулах, шаардлагатай төсөв, хөрөнгийг Байгаль орчны асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх асуудлыг цагдаагийн байгууллагын хэмжээнд Экологийн цагдаагийн алба хариуцан хэрэгжүүлж, мэргэжил, арга зүйгээр хангах, биелэлт, үр дүнг тооцдог байх.

**Гурав. Санал, зөвлөмж:**

3.1. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн Засаг даргаас хяналтын цэгт ажиллах алба хаагчдын томилолтын зардал, хоолны мөнгө, үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай машин техник, түр амьдрах байр, орон сууц /пост/-ны асуудлыг шийдвэрлэх боломжийг судалсны үндсэн дээр эрх зүйн акт /тушаал/-ыг гаргуулж байхад анхаарах /ЭкоЦА, НДХЦБ/;

3.2. Хяналтын цэг /пост/-ийн байршилд үүрэг гүйцэтгэх алба хаагчдын ажиллах нөхцөл, аюулгүй байдлыг хангах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг үр дүнтэй зохион байгуулах нь тухайн аймгийн цагдаагийн газрын даргын “албан тушаалын тодорхойлолт”-д заасан үндсэн чиг үүрэг гэдгийг ойлгон ухамсарлаж ажиллах /ЭкоЦА, НДХЦБ/;

3.3. Хяналтын цэг /пост/-ийг ажиллуулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргуулж, уг үйл ажиллагааг тогтмолжуулах, шаардлагатай төсөв, хөрөнгийг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн төрийн захиргааны байгууллагаар шийдвэрлүүлэх асуудлыг цагдаагийн байгууллагын хэмжээнд Экологийн цагдаагийн алба хариуцан хэрэгжүүлж, мэргэжил, арга зүйгээр хангах, биелэлт, үр дүнг тооцохыг Экологийн цагдаагийн албаны дарга /цагдаагийн хурандаа М.Батсайхан/-д даалгах саналтайг Танд илтгэн танилцуулъя.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

УДИРДЛАГЫН ШИЙДВЭР:.....  
.....  
.....

ХЯНАСАН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН  
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР**

**ТАНИЛЦУУЛГА**

Өмнөговь аймгийн цагдаагийн газрын “Гэрээт цагдаагийн хэлтсийн даргын албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийн байдалд” дотоод аудит хийсэн талаар

2023 оны 04 дүгээр  
сарын 26-ны өдөр

№ 1/73

Улаанбаатар  
хот

Дотоод хяналт, аюулгүй байдлын газрын ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав би Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн өгсөн үүргийн дагуу Өмнөговь аймгийн цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаанд 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс 18-ны өдрийн хооронд явуулсан хэсэгчилсэн шалгалтын танилцуулга, Өмнөговь аймгийн цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Н.Мишигдоржийн энэ оны 04 дүгээр сарын 14-ны өдөр гаргасан танилцуулга, тайлбар, 2022 оны 04 дүгээр сард “Гэрээт цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаанд хийгдсэн дотоод аудитын тайлан зэргийг үндэслэн Өмнөговь аймгийн цагдаагийн газрын “Гэрээт цагдаагийн хэлтсийн даргын албан тушаалын зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийн байдалд” дотоод аудит хийлээ.

**Нэг: Орон нутгийн нөхцөл байдлын талаар:** Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Хайрхан баг” нь Улаанбаатар хотоос 820 км, аймгийн төвөөс 340 км, Ханбогд сумаас 133 км, Гашуунсухайт боомтоос 9 км зайтай оршдог.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан баг Цагаан хад суурьшлын бүсэд байнгын оршин суух бүртгэлтэй 128 өрхийн 440 хүн, түр оршин суух бүртгэлтэй 417 өрхийн 1031 хүн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний дэлгүүр 17, барааны дэлгүүр 5, бөөний дэлгүүр 4, үсчин 5, буудал 5, нийтийн халуун ус 2, цайны газар 39, авто сэлбэгийн дэлгүүр 4, валют арилжааны цэг 4, ахуйн газ худалдан борлуулдаг 1, найман нэр болон зургаан нэрийн барааны дэлгүүр 32, нийт 118 аж ахуйн нэгж байгууллагууд худалдаа үйлчилгээ явуулж, төрийн байгууллагын 150 орчим алба хаагчид ажиллаж, амьдарч байна. Мөн тавантолгой бүлэг ордоос Гашуунсухайт хүртэлх зам дагуу байрлалтай, нүүрс тээврийн 13000 орчим жолооч зорчигч, иргэдэд үйлчилгээ үзүүлэх 150 гаруй үйлчилгээний цэг, 160 гаруй тээврийн компани, Нүүрс ачиж буулгах /НАБТ/ 35 талбай үйл ажиллагаа явуулж байна.

Ханбогд сумын хайрхан баг Цагаан хад суурьшлын бүсэд богинын тээвэрлэлт хийх зөвшөөрөлтэй 225 аж ахуйн 5446 жолооч нэгжийн Цогтцэций сум Тавантолойн бүлэг ордоос Цагаан хад хүртэл дундын тээвэрлэлтэд 153 аж ахуйн нэгжийн 5344 жолооч бүртгэлтэй байна. Тавантолгойн бүлэг ордоос Гашуунсухайтын боомт хүртэлх дундын нүүрс тээвэрлэлт өдөрт 1800-2000 дунджаар тээвэрлэлт хийж байна.

Гашуунсухайт хилийн боомтоор Монгол улсын уул уурхай бүтээгдэхүүний экспортын багагүй хувь нь гарч үүнийг дагаад хүн ам, тээврийн хэрэгслийн тоо эрс нэмэгдэж Тавантолгой бүлэг ордоос Гашуунсухайт хилийн боомт хүртэлх 239 километр хатуу хучилттай авто замаар өдөрт дунджаар 3500-5000 тээврийн хэрэгсэл зорчиж байна.

Цагаанхад суурьшлын бүсэд одоогийн байдлаар нийт 20000 орчим иргэн ажиллаж, амьдарч байна.

**Хоёр: Өмнөговь аймгийн цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтэс нь:** Өмнөговь аймгийн Цогтцэций сумын цагдаагийн тасгийн харьяанд “Хайрхан” сумын нутаг дэвсгэрт байрлах “Цагаан хад” суурьшлын бүсэд “Нүүрсний зам” ХХК-ийн “Гэрээт замын цагдаагийн хэсэг” нэршилтэйгээр анх 2010 онд байгуулагдан замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан чиглэлээр ажиллаж байгаад Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 211 дүгээр тогтоолоор Цагдаагийн ерөнхий газар, “Эрдэнэс Монгол” компани, “Гашуун сухайт авто зам” компани гурвалсан

гэрээ байгуулж, Цагаан хад дахь гэрээт цагдаагийн тасаг, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/38 дугаар тушаалаар Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газрын “Гэрээт цагдаагийн тасаг”, мөн даргын 2019 оны А/258 дугаар тушаалаар “Гэрээт цагдаагийн хэлтэс” болон өргөжсөн байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар тус хэлтсийг Өмнөговь аймаг дахь цагдаагийн газрын харьяанд шилжүүлсэн байна.

Гэрээт цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа О.Чинзориг нь Цагдаагийн байгууллагад 20 жил, 10 сар, тухайн албан тушаалд 1 жил 7 сар ажиллаж байна.

Өнөөдрийн байдлаар хэлтсийн дарга 1, Чиглэлийн ахлах зохицуулагч 1, Ахлах зохицуулагч 1, Зохицуулагч 28, Цагдаа зохицуулагч 4 нийт 35 орон тоотойгоор Өмнөговь аймгийн “Цогтцэций”, “Ханбогд” сумаас “Гашуунсухайт” хилийн боомт хүртэлх хүнд даацын хатуу хучилттай нүүрс тээврийн авто зам дагуу болон Ханбогд сумын Хайрхан багийн Цагаан хад суурьшлын бүс орчимд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлын хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, зам тээврийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан чиглэлээр үүрэг гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар тус хэлтэст 6 зохицуулагчийн орон тоо дутуу байна.

Тус гэрээт цагдаагийн хэлтсийн 29 алба хаагчдаас 22 алба хаагч буюу 75,8.% нь Улаанбаатар хотод, 7 буюу 24,2% нь хөдөө орон нутагт оршин суух хаягтай, гэр бүлийн гишүүдийн 5 буюу 17,2% нь тодорхой эрхэлсэн ажилтай, 24 буюу 82,8 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 8 алба хаагч 0-5 насны хүүхэдтэй, 13 алба хаагч нь 5 дээш насны хүүхэдтэй, 8 алба хаагч хүүхэдгүй, гэр бүл зохиож тусдаа гараагүй байна.

Нийт алба хаагчдын 18 буюу 62.6 хувийг 25-40, 11 буюу 38 хувийг 40-өөс дээш насны алба хаагчид байна.

#### Алба хаагчийн товч мэдээлэл:

Д/д	Цол	Нэр	Ажилласан жил		Боловсрол, мэргэжил	Гэрийн хаяг
			Цагдаагийн байгууллагад	Тус албан тушаалд		
1	Цагдаагийн хурандаа	Оросоо Чинзориг	Нийт 20 жил 10 сар	1 жил 7 сар	Дээд эрх зүйч	Архангай аймаг Эрдэнэбулган сум 2-р баг 29-11 тоот
2	Цагдаагийн хошууч	Өлзийбаяр Алтантөгс	Нийт 17 жил	10 сар	Дээд эрх зүйч	Улаанбаатар Хан-Уул дүүрэг 4-р хороо 101-06 тоот
3	Цагдаагийн ахмад	Моломжамц Бат-Эрдэнэ	Нийт 16 жил	2 жил	Дээд эрх зүйч	Улаанбаатар Баянгол дүүрэг 11-р хороо 33-30 тоот
4	Цагдаагийн ахмад	Мягмарсүрэн Төмөрчөдөр	Нийт 20 жил	3 жил 8 сар	Дээд эрх зүйч	УБ, БЗД 1-р хороо 556-1106
5	Цагдаагийн ахмад	Цоодол Дарханбаатар	Нийт 17 жил	3 жил	Дээд эрх зүйч	УБ, НД 7-р хороо Шинэ налайх хороолол 12-39 тоот
6	Цагдаагийн ахлах дэслэгч	Бат-Очир Энхсанаа	Нийт 12 жил	4 жил 2 сар	Дээд эрх зүйч	ХУД 4 хороо 104-46 тоот
7	Цагдаагийн ахлах дэслэгч	Шинэдэнчил Одбаатар	Нийт 12 жил	4 жил 7 сар	Дээд эрх зүйч	УБ, ХУД 16-р хороо 712-50 тоот
8	Цагдаагийн ахлах дэслэгч	Ганзоригийн Анхсайхан	Нийт 5 жил	2 жил	Дээд эрх зүйч	ХУД-ийн 16-р хороо Бу-4-184 тоот
9	Цагдаагийн ахлах дэслэгч	Дэмбэрэлдаш Отгонбат	Нийт 15 жил	4 жил 2 сар	Дээд эрх зүйч	УБ, БЗД 25-р хороо 60-17 тоот

10	Цагдаагийн ахлах дэслэгч	Энжаргал Батбаатар	Нийт 10 жил	4 жил 2 сар	Дээд Инженер	БЗД-ийн 40-р хороо 16 хороолол 19-6 тоот
11	Цагдаагийн ахлах дэслэгч	Бямбаа Жажинсүрэн	Нийт 12 жил	4 жил 1 сар	Дээд эрх зүйч	ХУД 2 хороо 19 хороолол 10-91 тоот
12	Цагдаагийн ахлах дэслэгч	Сүрэнхор Батзориг	Нийт 20 жил	1 жил 3 сар	Дээд эрх зүйч	БЗД 37-Р хороо жанжны 20-561 тоот
13	Цагдаагийн ахлах дэслэгч	Отгонбаяр Баттүшиг	Нийт 9 жил	6 сар	Дээд эрх зүйч	БЗД 4-р хороо 118-51 тоот
14	Цагдаагийн дэслэгч	Нямаадорж Давагдорж	Нийт 9 жил	10 сар	Дээд эрх зүйч	ЧД-ийн 7-р хороо ХГ13-247
15	Цагдаагийн дэслэгч	Мөнхтөр Оюунбат	Нийт 9 сар	9 сар	Дээд эрх зүйч	Завхан аймаг Жаргалант баг нефт 1-5
16	Цагдаагийн дэслэгч	Бат-эрдэнэ Отгонбат	Нийт 9 сар	9 сар	Дээд эрх зүйч	СБД 15-р хороо ар хустайн зуслан 26-05 тоот
17	Цагдаагийн дэслэгч	Мөнхтөр Тэгшжаргал	Нийт 1 жил	11 сар	Дээд эрх зүйч	ӨМА Даланзадгад 7-р баг оюут 7-28 тоот
18	Цагдаагийн дэслэгч	Эрдэнэчулуун Энхдөл	Нийт 9 сар	9 сар	Дээд эрх зүйч	Дорноговь аймаг замын-үүд 1-р баг 14651 тоот
19	Цагдаагийн дэслэгч	Эрдэнэсүрэн Эрдэнэтогтох	Нийт 9 сар	9 сар	Дээд эрх зүйч	ЧД 16-р хороо согоот 77-1056 тоот
20	Цагдаагийн дэслэгч	Нэргүй Анхбаяр	Нийт 12 сар	11 сар	Дээд эрх зүйч	СХД-ийн 20-р хороо 7-21 тоот
21	Цагдаагийн дэслэгч	Дүгэрсүрэн Балдандорж	Нийт 9 сар	9 сар	Дээд эрх зүйч	Завхан аймаг отгон сум 5-р баг
22	Цагдаагийн дэслэгч	Батжаргал Ёндонтүвшин	Нийт 9 сар	9 сар	Дээд эрх зүйч	Баянхонгор аймаг Баянхонгор сум 3-р баг 2-12тоот
23	Цагдаагийн дэслэгч	Батсайхан Төмөрбат	Нийт 9 сар	9 сар	Дээд эрх зүйч	СХД6-р хороо тоосгоны 24а-4 тоот
24	Цагдаагийн дэслэгч	Намжилмаа Ганбат	Нийт 16 жил	10 сар	Дээд эрх зүйч	Өмнөговь аймаг Даланзадгад сум 8-р баг 43-12 тоот
25	Цагдаагийн дэслэгч	Эрдэнэчимэг Мөнх-Амгалан	Нийт 16 жил	2 сар	Дээд эрх зүйч	БЗД 14-р хороо мандах нар хороолол 1236-117 тоот
26	Цагдаагийн ахлагч	Энэбиш Баярмөнх	Нийт 2 жил	1 сар	Дээд эрх зүйч	СХД-ийн 21-р хороо Содон 121-14-199тоот
27	Цагдаагийн дэд ахлагч	Эрдэнэтуяа Мөнхбаяр	Нийт 8 жил	1 сар	Бүрэн бунд	ХУД 14-р хороо өлзийт хороолол 6-тоот
28	Цагдаагийн дэд ахлагч	Гүржав Азжаргал	Нийт 19 жил	1 сар	Дээд эрх зүйч	СХД-ийн 43-р хороо алтайн 6-595 тоот
29	Цагдаагийн дэд ахлагч	Ванчинсүрэн Батбаяр	Нийт 5 жил	10 өдөр	Бүрэн дунд	ЧД 12- р хороо булгийн 17-765

**Гурав:** Өмнөговь аймгийн цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтсийн даргын удирдлагын болон мэргэжлийн ур чадвар, манлайллын түвшин, хамт олны дунд оршиж буй нөхцөл байдлыг тодруулан дүгнэхээр алба хаагчдын дунд санал асуулгын хуудсаар санал сэтгэгдлийг нээлттэй болон хаалттай асуулгаар авсан.

Судалгаанд нийт 24 алба хаагч хамрагдсанаас 54.2 хувь нь эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжтай, 41.7 хувь сэтгэл ханамж дунд зэрэг байгаагаа илэрхийлсэн.

Тус хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа О.Чинзоригийн удирдлагын үйл ажиллагаанд судалгаанд өгөгдсөн үзүүлэлтүүдийн дунджаар 68.3 хувиар сайн буюу "D" үнэлсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулж байгаа ажил, арга хэмжээнд 53.6 хувиар хангалтгүй буюу “F” үнэлгээтэйгээр үнэлэгдсэн байна. /Санал асуулгын нэгдсэн дүнг хавсаргав/

**Дөрөв:** Тус хэлтэс нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 18 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулсан боловч Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн байгууллагын ажлыг төлөвлөх, тайлагнах /код-108/ журам”-ын 108.2.1, 2.7, 2.8-д заасан шаардлага хангаагүй, 18 заалтаас 11-ийг Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнөөс хуулбарлан тавьсан, Гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө боловсруулахдаа хэлтсийн үйл ажиллагааны болон орон нутгийн онцлог, Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар болон Цагдаагийн газар, Замын цагдаагийн тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулаагүй;

Нэгжийн даргын гүйцэтгэлийн төлөвлөгөө нь тухайн зохион байгуулалтын нэгжийн төлөвлөгөө болон мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ гэсэн 2 хэсгээс бүрдэнэ гэж заасны дагуу үзэхэд мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр төлөвлөсөн ажил байхгүй, /нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хавсралтаар хавсаргаагүй/ байна.

Тус хэлтсийн 28 алба хаагчаас 12 алба хаагчийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан хэдий ч Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 6 дугаар хавсралт, загварын дагуу боловсруулаагүй байгаа нь удирдлагаас тавих дотоод хяналт, сурган дадлагажуулах, мэргэшүүлэх чиглэлээр зохион байгуулсан албаны сургалт чанаргүй, хангалтгүй гэж үзэхээр байна.

**Тав:** Өмнөговь аймгийн цагдаагийн газраас ЦЕГ-ын дарга, дотоодын цэргийн командлагч, Тэргүүн дэд дарга, дэд дарга болон албадаас ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл, албан даалгавар, зөвлөмж, 2023 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт үр дүн тооцох баримт бичгийн жагсаалт зэргийг тус газрын даргын тушаалаар эзэнжүүлж, Гэрээт цагдаагийн хэлтсийн даргын outlook, earchive.police.gov болон [gereettsagdaa1@gmail.com](mailto:gereettsagdaa1@gmail.com) зэрэг хаягуудаар хүргүүлж, өглөө бүрийн нэгдсэн рапорт дээр /Гэрээт цагдаагийн хэлтэс рапортод цахимаар оролцдог/ нийт алба хаагчдад уншиж танилцуулдаг байна.

2022 оны байдлаар тус цагдаагийн газрын даргаас Гэрээт цагдаагийн хэлтсийн даргын нэр дээр 17 удаа үүрэг, ажлын чиглэл өгснөөс хугацаандаа ирүүлсэн 8, хугацаа хоцорч, ирүүлээгүй 9, 2023 оны 04 дүгээр сарын байдлаар тус цагдаагийн газрын даргаас Гэрээт цагдаагийн хэлтсийн даргын нэр дээр 7 удаа үүрэг, ажлын чиглэл өгсөн ба үүнээс хугацаандаа ирүүлсэн 2, хугацаа нь болоогүй 2, хугацаандаа ирүүлээгүй 3 байна.

2023 онд Цагдаагийн төв байгууллагын удирдлагаас өгсөн 12 үүрэг, ажлын чиглэл, мэдээллүүдийг хүлээн авсан боловч хариутай үүрэг, ажлын чиглэлийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын биелэлт, танилцуулгыг гаргаж албажуулж хүргүүлсэн нотломжууд байхгүй.

Тус хэлтсийн ахлах зохицуулагч, цагдаагийн хошууч Ө.Алтантөгс 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр 23 алба хаагчаас сахилга, ёс зүйн зөрчил гаргахгүй байх талаар 12 заалттай баталгаа авсан, мөн 02 дугаар 22-ны өдөр 14 алба хаагчид 11 заалттай зааварчилгаа танилцуулж, 03 дугаар сарын 10-ны өдөр зааварчилгааны хэрэгжилтийг Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Тэмдэглэл, илтгэх хуудас үйлдэх /код-245/ журам”-ын дагуу авах хугацаатай боловч, илтгэх хуудсуудыг алба хаагчдаас авч хавсаргаагүй, мөн 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хэлтсийн хурал зохион байгуулсан тэмдэглэл байгаа боловч үүнээс хойш хэлтсийн хурал зохион байгуулж, алба хаагчдад үүрэг, чиглэл, зааварчилга өгсөн тэмдэглэл, нотломж байхгүй, алба хаагчдын хийж гүйцэтгэсэн ажлыг үнэлж дүгнэж, шагнал, урамшуулалд тодорхойлоогүй байна.

- 2022 онд Дотоод хэргийн их сургууль төгссөн 9, бусад 5 нийт 14 алба хаагч шинээр томилогдоход Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам-ын дагуу холбогдох гэрээг байгуулж албаны үйл ажиллагаанд дасан зохицох, сурган дадлагажуулах чиглэлээр ажлыг зохион байгуулсан ажил, арга хэмжээ байхгүй.

2023 онд 2 алба хаагч шинээр томилогдсон бөгөөд багш шавийн гэрээ байгуулаагүй, шинээр томилогдсон зохицуулагч, цагдаагийн дэслэгч Ц.Сугаррагчаа энэ оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс хойш ажилдаа ирээгүй /тасалсан/ шалтгааныг тогтоохоор албаны шалгалт хийгдэж байна.

- Хэлтсийн дарга, ахлахуудаас алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сулаас шалтгаалан тус хэлтсийн цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлах

ахлагч н.Содномцоодол ажлын болон ажлын бус цагаар архидан согтуурсан, цагдаа зохицуулагч, цагдаагийн дэслэгч Ц.Сугаррагчаа нь шалтгаангүй ажил тасалсан, ахлах зохицуулагч, цагдаагийн ахмад М.Бат-Эрдэнэ нь тус хэлтэст зохицуулагчаар ажиллаж байсан цагдаагийн ахлах дэслэгч Б.Нямдаваатай цуг архидан согтуурч байх үедээ маргалдаж, хөлийн шөрмөсийг тасалж гэмтэл учруулсан, зохицуулагч, цагдаагийн ахлах дэслэгч Б.Энхсанаа, цагдаа зохицуулагч, цагдаагийн ахлагч Э.Баярмөнх нар зөрчилд арга хэмжээ тооцоогүй дарагдуулсан зөрчилд холбогдсон байна.

**Зургаа:** 2023 оны 03 дугаар сарын байдлаар 59 зөрчил бүртгэснээс 16 материалыг шийдвэрлэж шивсэн дугаар бичигдээгүй, хэрхэн шийдсэн нь тодорхой бус, мөн хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1, 5-д заасан 21 зөрчлийг бүртгэснээс 3 зөрчлийг шийдвэрлэж шивсэн бүртгэлийн дугаар тавиагүй, мөн хуулийн 14.7 дугаар зүйлийн 1-д заасан 13 зөрчлийг бүртгэснээс 1 зөрчлийг шийдвэрлэж шивсэн бүртгэлийн дугаар тавигдаагүй, бусад зөрчлийн бүртгэлийн дэвтэрт урсгал сөрсөн 9, албан мэдэгдлийн хариу ирүүлээгүй 11, хуурамч улсын дугаартай хөдөлгөөнд оролцсон 12, хурд хэтрүүлсэн 7 зэрэг нийт 39 зөрчлийг бүртгэж шалгаж шийдвэрлээд бүртгэлийн дугаарыг авсан байна.

Дээр дурдсан 4 төрлийн зөрчлийн бүртгэлийн дэвтэр, зөрчлийн шийдвэрлэлттэй хэлтсийн дарга танилцсан хэдий ч 20 зөрчлийн материалыг шийдвэрлэж, санд бүртгэсэн дугаар тавиагүй байхад танилцаж гарын үсэг зурсан нь учир дутагдалтай байна.

-Эрх бүхий алба хаагчдын шалгасан захиргааны зөрчлийн материалын тоо, өсөлт бууралт, дундаж ачааллыг харьцуулсан бүртгэл судалгаа байхгүй, зөрчлийн материалыг 4 алба хаагч ээлжилж шийдвэрлэж байгаа нь ажлын ачааллын хувьд тэнцвэргүй байна.

-2022 онд гэмт хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэр байрлан үйл ажиллагаа явуулдаг 31 аж ахуйн нэгжид албан мэдэгдэл хүргүүлсэн ба 12 мэдэгдлийн хариуг авсан, 2023 онд 18 аж ахуйн нэгжид албан мэдэгдэл хүргүүлсэн боловч мэдэгдлийн хариуг аваагүй байна.

-2023 оны эхний 3 сарын байдлаар нүүрс тээврийн замд гарсан ослын судалгаатай, 2023 он гарснаас хойш ослын улмаас хүн гэмтсэн тохиолдол 3, эд материалын хохиролтой осол 57 тус тус бүртгэгдсэн байна.

Түүнчлэн 2023 онд гарсан 2 хэргийн танилцуулга байгаа боловч шалтгаан нөхцөлийг судалж, урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ байхгүй байна.

### **Гурав: Дүгнэлт**

3.1. Өмнөговь аймгийн цагдаагийн газрын Гэрээт цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа О.Чинзориг нь Булган аймгийн цагдаагийн газарт 2000 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2010 оны 03 дугаар сарын 18-ны өдрийг хүртэл замын цагдаагийн байцаагч, ахлах байцаагч, тасгийн даргаар, Архангай аймгийн цагдаагийн газарт 2010 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл Замын цагдаагийн тасгийн даргаар, Дундговь аймгийн цагдаагийн газарт 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдөр хүртэл ахлах зохицуулагч, тасгийн даргаар, Өмнөговь аймгийн цагдаагийн газарт 2018 оны 12 дугаар сарын 13-ны өдрөөс 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийг хүртэлх хугацаанд Замын цагдаагийн тасгийн даргаар, замын цагдаагийн чиглэлээр 19 жил ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн Б/864 дугаар тушаалаар тус албан тушаалд томилогдон ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны Б/169 тушаалаар хуулиар харьяалуулсан хэрэг зөрчлийг шалгаж шийдвэрлэх ажиллагааны явцад мэргэжлийн удирдлагаар хангах, хяналт тавих үүргээ үл биелүүлж, албан үүрэгтээ хайнга хандаж, ажлын хариуцлага алдсан зөрчилд Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2 дахь хэсэгт зааснаар "Сарын үндсэн цалинг 3 сар 20 хүртэл хувиар хасах,

Мөн даргын 2023 оны Б/13 дугаар тушаалаар Эрх зүйн зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах чиг үүргээ хангалтгүй биелүүлж ажлын хариуцлага алдсан зөрчилд Цагдаагийн албаны тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4.2 дахь хэсэгт зааснаар "Сарын үндсэн цалинг 3 сар 20 хүртэл хувиар хасах сахилгын арга хэмжээ тооцогдсон байна.



3.2. Гэрээт цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа О.Чинзориг нь албан үүрэг гүйцэтгэлийн удирдлагын хяналт, зохион байгуулалт, бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийн хэрэгжилтийг зохион байгуулах, хэрэгжүүлэх, тооцон үнэлэх, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварын түвшинг дээшлүүлэх, алба хаагчдын сахилга, ёс зүйн байдалд хяналт тавих, албан тушаалын тодорхойлолтоор заагдсан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилт, алба хаагчдыг төрөл албадын чиглэлээр дадлагажуулах, мэргэжил арга зүйгээр хангах үүргээ хангалтгүй хэрэгжүүлж байна гэж үзэхээр байна.

3.3 Төрийн болон албаны бодлого зохицуулалтын баримт бичгийн гүйцэтгэлийн хэрэгжилтийн байдал, алба хаагчдын үүрэг гүйцэтгэл, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тус хэлтсийн даргаас гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ үнэлгээг тогтмол хийхгүй байгаа нь хэрэгжилтийг дүгнэх, цаашдын ажил, арга хэмжээг бодитой төлөвлөн тооцоход эрсдэл үүсгэхээр байна.

#### **Дөрөв: Санал**

4.1. Цагдаагийн албаны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасан нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх, албан тушаалын тодорхойлолтод заасан шалгуур шаардлагыг хангах, бие даан шийдвэр гаргах, хамт олныг удирдан зохион байгуулах, төрөл мэргэжлийн албадын мэдлэг дадлага эзэмшсэн, ур чадвартай алба хаагчийг судалж, томилоход анхаарч ажиллах шаардлагатайг Хүний нөөцийн хэлтэс /цагдаагийн хурандаа Б.Мөнх-Эрдэнэ/-д ;

4.2. Цагдаагийн Ерөнхий газрын хуулийн хэлтсээс ирүүлсэн 122 дугаартай танилцуулга, Тээврийн цагдаагийн албаны даргын 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 14/1506 дугаартай үүрэг, ажлын чиглэлийн хүрээнд тус хэлтсийн алба хаагчдыг сэлгэн амраах, ээлж /ростер/-д оруулан 21x7 хоногоор ээлжлүүлэн амраахад хэлтсийн дарга, ахлах зохицуулагч нар хамрагдаж байгаа нь алба хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангах, хэлтсийн хэвийн үйл ажиллагаа алдагдах эрсдэл үүсэхээр байгаа тул тус хэлтсийн дарга, чиглэлийн болон ахлах зохицуулагч нарыг /ростер/-т оруулахгүйгээр үүрэг гүйцэтгүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр нутаг дэвсгэрийн цагдаагийн газрын даргатай хамтарч судлан, ажиллахыг Санхүү аж ахуйн алба /цагдаагийн хурандаа Д.Батчулуун/, Тээврийн цагдаагийн алба /цагдаагийн хурандаа Ц.Ариунболд/; бусад алба хаагчдыг 21x7 гэсэн ээлжээр амрах /ростер/-ыг үргэлжлүүлэн, тогтмол бодлого зохицуулалтын хэрэгжилтийг хангаж тооцон, хяналт тавьж ажиллахыг Өмнөговь аймаг дахь цагдаагийн газар /цагдаагийн хурандаа М.Мишигдорж/-нарт даалгах саналтайг Танд илтгэн танилцуулъя.

**ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР**

## ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2023 оны 05 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

**Аудитын нэр:** “Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны “Сүүж-уул сэргээн засах амралт, сувиллын үйл ажиллагаанд хийх дотоод аудит”

**Аудитын төрөл, код:** Үйл ажиллагааны аудит, ЦЕГ- ДХАБГ/ҮА-2023/06

**Аудитын хугацаа:** 2023.05.01- 2023.05.12

**Аудитын багийн ахлагч:** Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал.

**Аудитын багийн гишүүн:** Ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав, Хөдөлмөрийн аюулгүй байдлын байцаагч, их эмч, цагдаагийн дэслэгч Б.Бямбацогт.

### НЭГ.ТАНИЛЦУУЛГА

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Сүүж-уул сэргээн засах амралт, сувилал” нь Нийгмийн аюулаас хамгаалах яамны сайдын 1981 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 596 тоот тушаалаар яамны амралт байгуулах тухай шийдвэр гарч, анхны даргаар нь хурандаа М.Лхамсүрэн томилогдож, 1981 оны 6 дугаар сарын 29-ны өдөр амралт өөрийн туслах аж ахуйтай болсон байна.

Нийгмийг аюулаас хамгаалах яамны сайдын 1982 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 439 дүгээр тушаалаар Нийгмийг аюулаас хамгаалах яамны амралтыг “Сүүжийн амралт” гэж нэрлэж, 07 дугаар сарын 05-ны өдөр анхны амрагчдаа хүлээн авснаар үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Тухайн үед 26.000.000 /хорин зургаан сая/ төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2009 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дүгээр тушаалаар “Сэргээн засах сувилал” үүсгэн байгуулах шийдвэр гарч, 3 эмч, 3 сувилагч, үйлчилгээний 15 ажилтны орон тоотой болжээ.

Уг амралт, сувилал нь Сонгинохайрхан дүүргийн 21 хороо “Шар хад” нэртэй газар байрлах бөгөөд Улаанбаатар хотын төвөөс 70 км-ын алслагдсан, **Хууль зүй, дотоод хэргийн яамны нэр дээр /маш нууц/ зэрэглэлтэй “Улсын тусгай хэрэглээний газрын 000000003 дугаарын гэрчилгээтэй, 797.74 мкв** газар дээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Цагдаа, дотоодын цэргийн, анги байгууллагын алба хаагч, ажилтан, ахмад ажилтан болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эмчилгээ үйлчилгээ үзүүлэх, ая тухтай амраах үндсэн чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

### **Сүүж-Уул” амралт, сувиллын нэрийн өөрчлөлт**

Д/д	Дээд газрын шийдвэр, тогтоол	Нэрийн өөрчлөлт
1.	Нийгмийг аюулаас хамгаалах сайдын 1982 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 439 дугаартай тушаал.	“Сүүжийн амралт”
2.	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2004 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 53 дугаартай тушаал.	Цагдаа, Дотоодын цэргийн 810 дугаар тусгай салбар
3.	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 285 дугаартай тушаал.	Цагдаагийн алба хаагчдын “Сүүж-Уул” сэргээн засах сувилал
4.	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/88 дугаартай тушаал.	“Сүүж-Уул” амралт, сэргээн засах сувилал
5.	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/50 дугаартай тушаал.	“Сүүж-Уул” амралт, сэргээн засах сувилал
6.	Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/131 дугаартай тушаал.	“Сүүж-Уул” амралт, сувилал

### 1.2. Бүтэц, орон тоо

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/50, мөн даргын 2022 оны А/131 дугаар тушаалаар “Сүүж-Уул амралт, сувилал”-ыг удирдлага, үйлчилгээ, сувиллын хэсэг гэсэн бүтэцтэй, офицер 15, ахлагч 18, энгийн 24 нийт 57 орон тоотой батлагдсан байна.

Одоогоор сувиллын хэсгийн дарга, хүний их эмч 1, уламжлалтын их эмч 1, сэргээн заслын их эмч 1, хөдөлгөөн засалч 1, бариа заслын сувилагч 3, нярав 1, үйлчлэгч 1, зөөгч-

бэлтгэгч 1, ариутгагч 1, слесарь 1, нийт 12 орон тоо дутуу, 45 алба хаагч, ажилтан ажиллаж байна.

Тус амралт сувилал нь 45 алба хаагчдаас 28 алба хаагч, ажилтан буюу 62.3% нь Улаанбаатар хотод, 17 буюу 37.7%-нь хөдөө орон нутагт оршин суух хаягтай, 11 гэр бүл буюу 22 алба хаагч, ажилтан буюу 46.8%-нь гэр бүлийн хамт ажилладаг, гэр бүлийн гишүүдийн 39 буюу 86.6% нь тодорхой эрхэлсэн ажилтай, 6 буюу 13.4 хувь нь тодорхой эрхэлсэн ажилгүй, 14 алба хаагч, ажилтан 0-5 насны хүүхэдтэй, 29 алба хаагч, ажилтан нь 5 дээш насны хүүхэдтэй, 2 ажилтан хүүхэдгүй, гэр бүл зохиож тусдаа гараагүй байна.

Нийт алба хаагчдын 6 буюу 13.3 хувийг 18-30, 19 буюу 42.3 хувийг 31-45, 18 буюу 40 хувийг 46-60, 2 буюу 4.4 хувийг 61-ээс дээш насны алба хаагч, ажилтан байна.

“Сүүж-Уул” амралт, сувиллын дарга, цагдаагийн хурандаа Р.Төмөрбаатар нь Цагдаагийн байгууллагад 27 жил, 10 сар, тухайн албан тушаалд 2 жил, 9 сар ажиллаж байна.

### 1.3. Үйл ажиллагаа эрхлэх талаар

Нийслэлийн эрүүл мэндийн газраас “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-ийг 2018 онд 5 жилийн хугацаатай авч, 2023-2028 он хүртэл 5 жилээр сунгуулсан.

Эрүүл мэндийн яамны “Магадлан итгэмжлэгдсэн байгууллага”-аар 2013, 2015, 2017, 2020, 2022 онуудад 5 удаа шалгарсан.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 02 дугаартай “Журам шинэчлэн батлан тухай” тушаалаар эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журам гарсантай холбогдуулан сувиллын сэргээн засах тусламж үйлчилгээ, уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ гэх 2 төрлөөр сонгон шалгаруулалтад оролцож “Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ” үзүүлэх эрх авч Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2022-2025 он хүртэл 3 жил хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна.

Нийслэлийн аялал жуулчлалын газраас 2021 онд амралтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл анх удаа авч, 2023 онд зөвшөөрлийг хугацаагүй сунгуулсан.

Стандартчилал, хэмжил зүйн газраас амралтын үйл ажиллагаа эрхлэх албан ёсны зөвшөөрөл болох “Тохирлын гэрчилгээ”-г 2021 онд анх удаа авч, 2023-2025 он хүртэл 2 жилээр сунгуулсан байна.

Тус нэгж нь 4.100.000.000 /дөрвөн тэрбум нэг зуун сая/ төгрөгийн хөрөнгөтэй үүнээс үндсэн хөрөнгө 3.400.000.000 /гурван тэрбум дөрвөн зуун сая/ төгрөг, эргэлтийн хөрөнгө 528.500.000 /таван зуун хорин найман сая таван зуун мянга/ төгрөг.

Тус амралт, сувилал нь 4 төрлийн 537 толгой 42.200.000/ дөчин хоёр сая хоёр зуун мянга/ төгрөгийн балансын үнэтэй мал сүрэгтэй. Үүнд: Адуу 17, үхэр 12, хонь 309, ямаа 199 толгой байна.

### 1.4. Барилга байгууламжийн талаар:

1. Сувиллын барилга “А” блок: 1981 оны 05 дугаар сарын 21-ны өдөр ашиглалтад орсон. Улсын барилга, зургийн төв институтийн 3663/72 шифртэй зургийн дагуу тэнхлэгээрээ 36,9\*22,8м хэмжээтэй, төмөр бетон шугаман суурьтай, даацын тоосгон ханатай, хавтан хучилт, шувуу нуруу бүхий төмөр дээвэртэй зоорьтой 2 давхар, 850 м2 талбайтай, барилгын дотор зохион байгуулалтын хувьд зоорийн давхарт аж ахуйн агуулах 1, узелийн өрөө 1, нэгдүгээр давхарт үүдний хүлээлгийн танхим 1, эмчилгээний өрөө 3, сувиллын гал тогоо 1, үйлчлүүлэгчийн хоолны танхим 1, угаалга 1, ахлах тогоочийн өрөө 1, ариун цэврийн өрөө 1, хоёрдугаар давхарт бясалгалын өрөө 1, сувилуулагчийн амралтын 18 өрөө, ариутгалын өрөө 1 тус тус байх бөгөөд амрагч сувилуулагчдын ая тухтай амрах орчин нөхцөл бүрдсэн байна.

2. Сувиллын барилгын “Б” блок өргөтгөлийн хэсэг: “А” блоктой хүзүүвчээр холбогдсон төмөр бетон шугаман суурь, даацын тоосгон хана, хавтан хучилт, хар цаасан хавтгай дээвэртэй, 750 м2 талбайтай, дотоод зохион байгуулалтын хувьд нэгдүгээр давхарт угаалгын хатаалга, индүүлгийн өрөө 1, биеийн тамирын танхим 1, теннис, дартсын өрөө 1, тусгаарлах өрөө 1, хүнсний агуулах 2, махны агуулах 1, ариун цэврийн өрөө 1, санхүүгийн өрөө 1, архивын өрөө 1, хоёрдугаар давхарт хөдөлгөөн засал эмчилгээний өрөө 1, татлага эмчилгээний өрөө 1, бариа засал, бумба эмчилгээний өрөө 1, зүү эмчилгээний өрөө 1, физик

эмчилгээний өрөө 1, туяа эмчилгээний өрөө 1, эмчийн өрөө 1, сувиллын даргын өрөө 1, бичиг хэрэг, кассын өрөө 1 нийт 19 өрөөтэй.

Сувилуулагчдад хийгдэх эмчилгээний нэр төрөл олшруулж, эмчилгээ хийх өрөөний нөхцөлийг сайжруулж, алба хаагч, ажилчдын ажил, үүргээ хэвийн гүйцэтгэх, амрагч, сувилуулагч, алба хаагч, ажилчид чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3. Зочид буудлын барилга: 1984 онд ашиглалтад орсон, төмөр бетон шугаман суурьтай, даацын тоосгон ханатай, хавтан хучилт, шувуу нуруу бүхий төмөр дээвэртэй 2 давхар 1490 м<sup>2</sup> талбайтай барилга. Дотоод зохион байгуулалтын хувьд нэгдүгээр давхарт зочны хүлээлгийн танхим, гал тогоо, амрагчдын хоолны танхим, ариун цэврийн өрөө 1, караоке 1, амрагчийн энгийн өрөө 6, хагас люкс өрөө 2, хоёрдугаар давхарт хурлын танхим 1, үйлчлэгчийн хувцас солих өрөө 1, агуулах 1, албан контор 1, амрагчийн энгийн өрөө 2, хагас люкс өрөө 2, бүтэн люкс өрөө 2, амралтын нийтийн талбай 1, нийт 14 өрөөтэй 28 үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадалтай.

4. 3 тасалгаат өвлийн сууц: 2015 онд ашиглалтад орсон бетон суурь, цутгамал шалтай, модон ханатай, шувуу нуруу бүхий төмөр дээвэртэй 1 давхар нам даралтын зуух галлаж халдаг 58,5 м<sup>2</sup> талбайтай байшин. Дотоод зохион байгуулалтын хувьд үүдний хэсэгт галлагааны хэсэгтэй 2 талдаа амралтын өрөөтэй. Өрөө тус бүр 5-6 хүн хүлээн авах хүчин чадалтай. Жилийн 4 улиралд амрагч хүлээн авдаг байна.

5. Модон гэр 2ш: 2018 онд ашиглалтад орсон бетон суурь, цутгамал шалтай, модны тайрдсан ханатай, модон нуруун дээвэртэй хар цаасан хучилттай модоор хийсэн галлагаатай гэрүүд юм. Гэр тус бүр 7 хүн хүлээн авах ортой жилийн 4 улиралд амрагч хүлээн авдаг.

6. Амрагчдын модон байр 6ш: 1982 онд ашиглалтад орсон бетон суурьтай модон шалтай, банз модон ханатай, рек модон доторлогоотой, босоо нуруутай төмөр дээвэртэй галлагаагүй 144 м<sup>2</sup> талбайтай зуны нийтийн байр. Нэгдүгээр байр 7 өрөө 20 хүн, 2,3, 4, 6 дугаар байрууд 8 өрөөтэй тус бүр 32 хүн, 5 дугаар байр 7 өрөөтэй, 26 амрагч зуны улиралд хүлээн авах боломжтой.

7. Амрагчийн 2 ортой байр 9ш: 1986 онд ашиглалтад орсон модон суурь, шалтай, зах модон ханатай, гипс болон паниаран доторлогоотой, босоо нуруутай, төмөр дээвэртэй галлагаагүй 18 м<sup>2</sup> талбайтай зуны байшин. Тус бүр 3-4 амрагч зуны улиралд хүлээн авах зориулалтай.

8. Зуны зоогийн танхим: 1984 онд ашиглалтад орсон бетон суурь, цутгамал шалтай, модон ханатай, налуу нуруу бүхий төмөр дээвэртэй 1 давхар зуны амрагчдад зориулсан гал тогоо, хоолны танхим бүхий 700 м<sup>2</sup> талбайтай байр, нэг ээлжиндээ 150-180 хүн хүлээн авах боломжтой.

9. Аж ахуйн агуулах: 1982 онд ашиглалтад орсон төмөр бетон шугаман суурь, даацын тоосгон хана, хавтан хучилт, хар цаасан хавтгай дээвэртэй, 160 м<sup>2</sup> талбайтай барилга. Сууринд суулт өгч, хананд хагарал үүссэн, дээврийн хар цаас хуурч дээврээс, ус нэвчиж гоождог байсныг 2020 онд модоор шувуу нуруу хийж төмрөөр дээвэрлэж 6-7 сарын хугацаанд хатааж дотор байсан эд хөрөнгийг цэгцэлж ангилан хураасан байна. Барилга нь байгалийн хүчин зүйлээс хамаарч үндсэн хийц бүтцэд хэвийн хэмжээнээс илүү ан цав үүссэн байна.

10. Тоосгон өндөр скалад: 1982 онд ашиглалтад орсон төмөр бетон шугаман суурь, даацын тоосгон хана, хавтан хучилт, хар цаасан хавтгай дээвэртэй, 280 м<sup>2</sup> талбайтай баригдсан барилга. Олон жилийн эдэлгээний явцад элэгдэж сууринд суулт өгсөн, ханад хагарал үүссэн, эвдрэл гэмтэл ихтэй, цонх торон хаалттай, хаалга сольсон тул өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сайжруулсан түлш авч хэрэглэж байгаа тул сайжруулсан түлшний агуулах болгон ашиглаж байна.

Барилга нь байгалийн хүчин зүйлээс хамаарч үндсэн хийц бүтцэд хэвийн хэмжээнээс илүү ан цав үүссэн байна.

11. Мөслөгтэй зоорь: 1982 онд ашиглалтад орсон төмөр бетон шугаман суурь, даацын тоосгон хана, хавтан хучилт, хар цаасан хавтгай дээвэртэй, 280 м<sup>2</sup> талбайтай зоорьтой 1 давхар барилга. Олон жилийн эдэлгээний явцад элэгдэж сууринд суулт өгсөн, ханад хагарал үүссэн, дээврийн хар цаас хуурч дээврээс ус нэвчиж гоождог болсон. Өнөөдрийн байдлаар үүдний хэсгийн ус нэвчдэггүй хэсэгт байгууллагын нөөц шатахууны агуулах хэлбэрээр ашиглаж байна.

12. Хүнсний агуулах :1982 онд ашиглалтад орсон төмөр бетон шугаман суурь, даацын тоосгон хана, модон нуруу бүхий дранк шавран тааз, шувуу нуруу бүхий төмөр дээвэртэй, 160 м2 талбайтай 1 давхар баригдсан барилга. Олон жилийн эдэлгээний явцад элэгдэж сууринд суулт өгсөн, хананд хагарал үүссэн, цонх хагархай, таазны шавар байнга унадаг, өнгө үзэмж байхгүй, дотор нь хүн ажиллахад эрсдэл маш өндөр болсон тул их засвар яаралтай хийх шаардлагатай. 2008 оноос эхлэн мужаан цех ажиллуулж 1 өрөөнд нь амрагчдын хорхог, боодог хийж ашиглаж байна. Барилга нь байгалийн хүчин зүйлээс хамаарч үндсэн хийц бүтцэд хэвийн хэмжээнээс илүү ан цав үүссэн байна.

13. Ажилчдын 4 айлын орон сууц 4ш: 1981 онд ашиглалтад орсон бетон суурь, төмөр замын шпол модон хана, модон нуруу бүхий дранк шавран тааз, босоо нуруутай төмөр дээвэртэй 128 м2 талбайтай 1 давхар барилга. Ажилчдын 4 айлын барилга нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөг байхгүй, хана тааз нурсан, зуух нурсан их засвар хийх шаардлагатай, өндөр эрсдэлтэй байшин.

14. Ажилчдын дэлгүүртэй сууц 1ш: 1984 онд ашиглалтад орсон бетон суурь, төмөр замын шпол модон хана, модон нуруу бүхий дранк шавран тааз, босоо нуруутай, төмөр дээвэртэй, 71,78 м2 талбайтай 1 давхар барилга. Өмнө хүнсний дэлгүүр, ажилчдын байр байсан. Одоо 3 айлын орон сууцны зориулалтаар ашиглаж байна хана, тааз нурсан их засвар хийх шаардлагатай, зарим байшингийн зуух нурсан солих шаардлагатай эрсдэл өндөр байшин. Барилга нь байгалийн хүчин зүйлээс хамаарч үндсэн хийц бүтцэд хэвийн хэмжээнээс илүү гэмтэл, ан цав үүссэн байна.

15. Цагдаагийн хэсгийн барилга 1ш: 2011 оны 12 дугаар сард ашиглалтад орсон бетон суурь, даацын тоосгон хана, вакум цонх, бүргэд хаалга, босоо нуруутай, төмөр дээвэртэй, галлагаатай 4 айлын 136 м2 талбайтай орон сууц. Байгалын эрс тэс үзэгдлээс шалтгаалж байшингийн арын хэсгээс шал дагаж ус нэвчиж ажилчдын тав тухыг удаа дараа алдагдуулж байна. Засварлах шаардлагатай.

16. Ажилчдын 8 айлын байр 1ш: 2014 онд ашиглалтад орсон бетон суурь, даацын тоосгон хана, вакум цонх, модон хаалгатай, босоо нуруутай, төмөр дээвэртэй, 416 м2 талбайтай нэг айл 52 м2 талбайтай галлагаатай, сувиллын удирдлагын хэсгийн алба хаагч, болон гэр бүлээрэй ажилладаг алба хаагч, ажилчид амьдардаг орон сууц. Энэхүү барилгын шатны хэсэг газарт шигдэж суусан, бетон сууринд өөрчлөлт орж ан цав үүссэн, шаланд хөдөлгөөн орж энд тэнд овойж хөдөлгөөн орсон, дэврээс ус алдаж гоождог болсныг 2021 онд дээврийн төмрийг бүрэн шинэчилсэн байна.

17. Цэцэрлэгийн байр 1ш :1981 онд ашиглалтад орсон бетон суурь, модон хана, модон нуруу бүхий дранк шавран тааз, босоо нуруутай, төмөр дээвэртэй нийт 128 м2 талбайтай 1 давхар барилга. Цэцэрлэгийн барилга нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, үлдэх өртөг байхгүй, их засвар хийх шаардлагатай.

Улсын 196 дугаар цэцэрлэгийн харьяа сувиллын дэргэдэх “Агуу үйлстэн”-н цэцэрлэгт тус амралт, сувиллын алба хаагч, ажилтны 2-5 насны 14 хүүхэд, орон нутгийн 3-5 насны 5 хүүхэд суралцаж байна.

Орон нутгийн 3 айлын 4 алба хаагч, малчин, сахиул орон тоон дээр ажиллаж буй ажилчид гэрээсээ ажилдаа явдаг ба байгууллагын дарга гэр бүлийн хамтаар зочид буудлын 1 өрөөнд амьдарч байна.

Ажилчдын орон сууцны 80% нь чанар байдал муудсан ашиглалтын шаардлага хангахгүй гал түлж, гаднаас ус зөөвөрлөн гадаа бие засах нөхцөлтэй байгаа нь тусгай мэргэжлийн алба хаагч, ажилтан очиж ажиллах сонирхолгүй байдаг байна.

#### 1.5. Амралтын үйл ажиллагааны талаар

Тус байгууллагын амралтын хэсэг нь Стандартчилал, хэмжил зүйн газраас олгосон амралтын үйл ажиллагаа эрхлэх “Тохирлын гэрчилгээ”, Нийслэлийн аялал жуулчлалын газраас олгосон үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй.

Үйлчилгээ, аж ахуйн хэсэг нь амралтын үйл ажиллагааг хариуцдаг бөгөөд хэсгийн дарга 1, ахлах тогооч 1, тогооч 4, зөөгч бэлтгэгч 3, жижүүр 4, захиалга хүлээн авагч 1, маркетинг олон нийт хариуцсан ажилтан 1, үйлчлэгч 3, цагаан хэрэгсэл угаагч 1, цахилгаанчин 1, мужаан 1, слесарь 3, малчин 1, сахиул 1, нярав 2, цагдаа-жолооч 1, түргэн тусламжийн жолооч зэрэг 30 орон тоотойгоос хэсгийн дарга, ахлах тогооч нар офицер албан тушаалтай, тогооч, бичиг хэрэг хөтлөгч, архивч, цагдаа-жолооч, нярав нар ахлагч цолтой бусад алба хаагчид энгийн орон тоон дээр ажилладаг байна.

Өнөөдрийн байдлаар нярав 1, үйлчлэгч 1, слесарь 1, зөөгч-бэлтгэгч 1, нийт 4 орон тоо дутуу ажиллаж байна.

Зуны улиралд зуны байр, Хөвсгөл аймаг дахь салбар амралтын үйл ажиллагаа эхлэх үед 2021 оноос өмнө Санхүү, аж ахуйн албанаас түр ажилтан авч ажиллуулах зөвшөөрөл авч, тухайн жилийн цалингийн санд багтаан 4-6 иргэнийг нэмэлтээр авч ажиллуулдаг байсан боловч 2022 оноос цалин бодох программ хүний нөөцийн программтай холбогдсон тул түр ажилтан авч ажиллуулах боломжгүй болсон.

Үүнтэй холбоотойгоор зуны гал тогоонд зөөгч, зуны байранд үйлчлэгч нэмэлтээр ажиллуулах боломжгүй болсон нь үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлж амрагч, сувилуулагч нараас гомдол цөөнгүй гарах болсон байна.

Үйлчлэгчийн цэвэрлэх талбай 1 үйлчлэгчид 300 м<sup>2</sup> байх нормативтай бол өнөөдрийн байдлаар нэг үйлчлэгч бүрэн орон тоогоор ажилласан ч 500 м<sup>2</sup> талбай цэвэрлэж байгаа нь ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

### Сүүлийн 3 жил амралтад амарсан амрагчдын судалгаа:

№	Харьяалал	2020 он	2021 он	2022 он	2023 оны 04 сар
1	Алба хаагч	129	140	315	78
2	Цагдаагийн гэр бүл	151	96	28	25
3	Ахмад ажилтан	81	86	24	26
4	Энгийн иргэд	1673	1088	1520	205
5	Хүүхэд	784	592	577	235
<b>Нийт</b>		<b>2818</b>	<b>2002</b>	<b>2464</b>	<b>569</b>

### 1.6. Сувиллын үйл ажиллагааны талаар

Сувиллын хэсэг нь Нийслэлийн эрүүл мэндийн газраас олгосон 50 орон дээр “Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл”-тэй бөгөөд өнөөдрийн байдлаар “Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээ”-г сувиллаар үзүүлэх албан ёсны зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж байна.

Сувилал нь нэг ээлжийндээ 50 хүн, сард 150-200, жилдээ 1500-1800 хүн хүлээн авах хүчин чадалтай.

Сувилал нь уламжлал бариа засал, зүү төөнүүр, бумба, элсэн жин, халуун лаа тавих, тангийн эмчилгээг үзүүлэхийн зэрэгцээ, сэргээн засахын физик эмчилгээ, хөдөлгөөн засал эмчилгээг хослуулан хийж гүйцэтгэдэг.

Эмчилгээнд физик эмчилгээний 11 тоног төхөөрөмж, хөдөлгөөн заслын 5 тоног төхөөрөмжтэй бөгөөд ашиглалтын хугацаа дуусаж байгаа орчин үеийн шинэ техник тоног төхөөрөмжөөр шинэчлэх шаардлагатай.

Сувилал нь цагдаа, дотоодын цэргийн алба хаагч ахмад ажилтан, тэдгээрийн гэр бүлийнхэнд хөнгөлөлттэй үнээр үйлчилгээ үзүүлэн эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилтийг гүйцэтгэлээр авах гэрээтэй ажиллаж байна.

Тус сувилал нь сувиллын хэсгийн дарга 1, сэргээн засахын эмч 1, зүү эмчилгээний эмч 1, уламжлалтын мэргэшсэн эмч 1, сэргээн заслын их эмч 1, яаралтай тусламжийн эмч 1, хүлээн авах, даатгал хариуцсан эмч 1, хөдөлгөөн засалч эмч 1, эрүүл ахуйч, халдвар судлаач эмч 1 нийт 9 эмч, ахлах сувилагч 1, ээлжийн сувилагч 4, бариа заслын сувилагч 4, сэргээн засахын физик эмчилгээний сувилагч 1 нийт 10 сувилагч, ариутгагч 1, үйлчлэгч 2, нийт энгийн 3 ажилтан, цагдаагийн цолтой 19 бүгд 22 орон тоотой боловч сувиллын хэсгийн дарга, хөдөлгөөн засалч эмч нар хүүхэд асрах чөлөөтэй, сэргээн заслын их эмч, уламжлалтын их эмч, бариа заслын сувилагч 3, ариутгагч 1 нийт 8 орон тоо дутуу ажиллаж байна.

Энэ онд дутуу орон тоон дээр 3 сувилагч судалснаас 1 сувилагч ахлагчийн дамжаа төгсөж томилогдож, одоо 2 сувилагч ахлагчийн дамжаанд суралцаж байна.

### Сүүлийн 3 жил сувилалд сувилуулсан иргэдийн судалгаа:

№	Харьяалал	2020 он	2021 он	2022 он	2023 оны 04 сар
1	Алба хаагч	260	662	634	222

2	Цагдаагийн гэр бүл	358	299	401	129
3	Ахмад ажилтан	185	96	184	49
4	Энгийн иргэд	172	108	132	72
5	Халамжийн хөнгөлөлттэй үнээр сувилуулсан ахмад настан	371	Сувиллын хэсгийн ачааллыг нэмэгдүүлж энгийн ахмадууд ирээд байсан тул дахин шалгаруулалтад оролцоогүй.		
<b>Дүн</b>		<b>1346</b>	<b>1165</b>	<b>1351</b>	<b>442</b>

## ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 2.1 Аудитын зорилго

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны “Сүүж-уул сэргээн засах амралт, сувиллын үйл ажиллагаанд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

### 2.2 Аудитын цар хүрээ

“Сүүж-уул сэргээн засах амралт, сувиллын алба хаагч, ажилчдын ажлын ачаалал, зохион байгуулалт, үйл ажиллагаа, барилга байгууламжийг дотоод аудитын объектод хамруулсан.

### 2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад танилцуулж, “Сүүж-уул сэргээн засах амралт, сувиллын алба хаагч, ажилчидтай уулзалт, ярилцлага хийж, санал асуулга авч, ажлын ачаалал, ажиллаж байгаа нөхцөл байдалтай газар дээр нь очиж танилцсан.

Түүнчлэн аудитын нотлох баримтыг цуглуулах зорилгоор холбогдох нэгжийн алба хаагчдаас ирүүлсэн материалтай танилцаж, авагдсан нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

## ГУРАВ. АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

**3.1.** 2023 онд тус нэгж нь Улсын төсвийн санхүүжилт **839,140,500** / найман зуун гучин ес сая, нэг зуун дөчин мянга, таван зуу / төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт **252,495,000** /хоёр зуун тавин хоёр сая, дөрвөн зуун ерэн таван мянга / төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого **279,113,100** / хоёр зуун далан есөн сая, нэг зуун арван гурван мянга, нэг зуун / төгрөг нийт **1,370,748,600** /нэг тэрбум, гурван зуун далан сая, долоон зуун дөчин найман мянга, зургаан зуу/ төгрөгөөр батлагдсан.

2023 оны 04 сарын 30-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн даатгалаас авах санхүүжилт **105,367,200** / нэг зуун таван сая, гурван зуун жаран долоон мянга, хоёр зуу / төгрөг буюу 125 хувиар илүү биелсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого **98,176,070** / ерэн найман сая, нэг зуун далан зургаан мянга, далан / төгрөг буюу **106** хувиар орлогын төлөвлөгөө давж нийт **543,898,270** / таван зуун дөчин гурван сая, найман зуун ерэн найман мянга, хоёр зуун далан / төгрөгийн орлогын эх үүсвэртэй ажиллаж байна.

**3.2.**Тус амралт, сувилал нь өөрийн эзэмшлийн газрын гэрчилгээгүй, бүртгэлгүй, Хууль зүй, дотоод хэргийн яамны нэр дээр /маш нууц/ зэрэглэлтэй “Улсын тусгай хэрэглээний газрын 000000003 дугаартай гэрчилгээтэй, 797.74 мкв газар дээр үйл ажиллагаа явуулж байна.

Шалтгааныг тодруулахад:Тус амралт, сувилал нь 2004 оноос 2014 он хүртэл дотоодын цэргийн 810 дугаар салбар анги гэх нэршилтэй байсан тул газрын тухай хуулийн 16 дугаар зүйл “Тусгай хэрэгцээний газар”-т хамааруулан 16.1.3 дахь хэсэгт “Улсыг батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалтаар олгосон газар” гэж заасныг баримтлан тусгай хэрэгцээт газрын гэрчилгээг Хууль зүй, дотоод хэргийн яамны нэр дээр олгосон байна.

**3.3.** Одоогоор сувиллын хэсгийн дарга, хүний их эмч 1, уламжлалтын их эмч 1, сэргээн заслын их эмч 1, хөдөлгөөн засалч 1, **офицер 4**, бариа заслын сувилагч 3, нярав 1,

**ахлагч 4, үйлчлэгч 1, зөөгч-бэлтгэгч 1, ариутгагч 1, слесарь 1 нийт энгийн орон тоо 4, нийт 12 орон тоо дутуу ажиллаж байна.**

**3.4.** Тус амралт, сувиллын ажилчдын 7 байранд 29 айл амьдрах бөгөөд одоогоор 9 айлын 18 алба хаагч гэр бүлээрээ амьдарч байгаа хэдий ч уг байрууд нь 1981, 1984, 2011, 2014 онд баригдсан, зарим байрны хана, тааз, нурсан, ус нэвчсэн, бетон сууринд өөрчлөлт орж ан цав үүссэн, шаланд хөдөлгөөн орж энд тэнд овойж хөдөлгөөн орсон, дээврээс ус алдаж гоождог нь хүн амьдрахад хүндрэлтэй, эрсдэл үүсэхээр болсон байна.

**3.5.** Сэргээн засах, хөдөлгөөн заслын эмч нар нь нарийн мэргэжил шаарддаг тул ажлын санал тавихад цалин, хангамж, амьдрах орчин нөхцөлтэй танилцаад татгалзсан хариу өгдөг байна.

Уламжлалтын эмч, сувилагч нарыг шинээр авч ажиллуулах боломжтой байгаа боловч байр орон сууцаар хангах боломжгүй нөхцөл байдал нь хүндрэл учруулж байна.

**3.6.** Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт “Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээний нэгж тохиолдлыг тооцох, тохиолдлыг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх журам”-д “Уламжлалт анагаах ухааны хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд эмчилгээний хугацааны туршид хэрэглэгдэх, эм, тан, эмчилгээний хэрэгсэл, оношилгоо, шинжилгээ, эмчийн үзлэг, зөвлөгөө, бариа засал, сэргээн засах болон сувилахуйн тусламж үйлчилгээний зардал, хоолны зардал болон бусад холбогдох бүх зардал хамаарна” гэж заасан.

Тус сувилалд эмчлэгддэг өвчний оношинд 277 нэр төрлийн тан шаардлагатай байгаагаас одоогоор 22 нэр төрлийн танг хэрэглэж байгаа нь хангалтгүй бөгөөд эмчилгээ бүрэн гүйцэт хийгдээгүй шалтгаанаар санхүүжилтийг хасах эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхээр байна.

Энэ онд эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардалд нийт 4.000.000 /дөрвөн сая/ төгрөгийн төсөв батлагдсанаас нэгдүгээр улирлын байдлаар 1.000.000 /нэг сая/ төгрөгийг зарцуулсан.

**3.7.** Ээлжийн сувилагч нь Сувилалд сувилуулахаар ирсэн иргэдийг хүлээн авч, эмнэлгийн анхан шатны баримт материалыг бүрдүүлэн, яаралтай түргэн тусламжийн үед хэрэглэгдэх эм тариа, боох материал, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган, элсэн жин, Парафин, хүчилтөрөгчийн коктейль эмчилгээг эмчийн заалтаар стандарт удирдамжийн дагуу үйлчлүүлэгчдэд тухай бүр хийж үйлчлэхээс гадна, сувилуулагчдын аюулгүй байдлыг хангаж, өрөө бүрт хяналт тавих, эмчийн зөвшөөрлөөр сувилуулагч болон иргэдэд эмийн болон тариа эмчилгээ хийж, Wings программд /санд/ сувилуулагчид нэг бүрийн амин үзүүлэлтийг тусгаж 24 цагаар ажилладаг байна.

**3.8.** Нийслэлийн цагдаагийн удирдах газрын бүртгэлтэй 2014 оны УАЗ 220693 маркийн /пургон/ 5040 УБТ улсын дугаартай /гүйлт норм дууссан/ автомашинаар амралт, сувиллын /барилгын материал, хүнсний бараа татах, нүүрс түлээ тээвэрлэх/ зэрэг бүх төрлийн ажил үйлчилгээнд ашигладаг автомашиныг холбогдох нэгжид танилцуулж, шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.

Хүнсний эрүүл ахуйн аюулгүй байдлыг хангах зорилгоор битүү ачаатай, хөргүүртэй зориулалтын тээврийн хэрэгсэл байхгүйгээс зориулалтын бус автомашинаар хүнсний бараа материалыг тээвэрлэж байгаа нь хүнсний эрүүл ахуйн шаардлага хангахгүй, нөхцөл байдал үүсэхээр байна.

**3.9.** Алба хаагчдын дунд санал асуулгын хуудсаар, санал сэтгэгдлийг асуулгаар авахад 42 алба хаагч хамрагдсанаас 65 хувь нь эрхэлж буй ажилдаа сэтгэл ханамжтай, 33 хувь нь сэтгэл ханамж дунд зэрэг, 2 хувь нь сэтгэл хангалуун бус байгаагаа илэрхийлсэн.

Амрах нөхцөл, өрөө тасалгаа, амралтын цагт 38 хувь нь сэтгэл ханамжтай, 62 хувь нь сэтгэл ханамж дунд зэрэг байгаагаа илэрхийлсэн бол 78 хувь ажил үүргээ гүйцэтгэхэд ямар нэгэн дарамт шахалт байдаггүй, 17 хувь нь зарим тохиолдолд, 5 хувь нь дарамт шахалт байдаг гэж хариулсан байна.

Алба хаагчдаас санал асуулгын хуудсаар авсан байгууллагын үйл ажиллагаа, удирдлага, ажлын орчин болон амралтын нөхцөлийн талаарх сэтгэл ханамжийн судалгаанд дунджаар 59,1 хувь сэтгэл ханамжтай, 34,8 хувь сэтгэл ханамж дунд, 6,1 хувь сэтгэл ханамжтай бус гэсэн дүн гарсан. /Санал асуулгын нэгдсэн дүнг хавсаргав/



## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Сүүж-уул сэргээн засах амралт, сувиллын үйл ажиллагааг жигдрүүлэх, алба хаагч, ажилчдын амьдрах, ажиллах нөхцөл бололцоогоор хангах, дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор аудитын багаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

**Нэг.** “Сүүж-Уул” сэргээн засах амралт, сувиллын үйл ажиллагаа явуулж байгаа газар нь Хууль зүй дотоод хэргийн яамны нэр дээр Улсын тусгай хэрэгцээт газарт бүртгэлтэй учраас уг газарт барилга, байгууламж барих өргөтгөл хийх талаар зураг төсөл боловсруулан батлуулах боломжгүй нөхцөл байдал үүссэн байна.

**Хоёр.** Тус амралт, сувилалд батлагдсан 57 орон тооноос сувиллын хэсгийн дарга, хүний их эмч 1, уламжлалтын их эмч 1, сэргээн заслын их эмч 1, хөдөлгөөн засалч 1, бариа заслын сувилагч 3, нярав 1, үйлчлэгч 1, зөөгч-бэлтгэгч 1, ариутгагч 1, слесарь 1 нийт 12 орон тооны нөхөн хангалтыг шийдвэрлэснээр алба хаагчдын ажлын ачаалал буурч, үйл ажиллагаа хэвийн явагдахад эерэг нөлөө үзүүлэхээр байна.

**Гурав.** Тус амралт, сувиллын ажилчдын амьдарч байгаа байруудын элэгдэл хорогдол, одоогийн нөхцөл байдал, учирч болох эрсдэлийг тодорхойлох зорилгоор Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс болон холбогдох мэргэжлийн байгууллагуудад хандаж, үзлэг, шалгалт хийлгэн дүгнэлт гаргуулж, хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээ авч, үйл ажиллагаандаа мөрдөх нь зүйтэй байна.

**Дөрөв.** Тус амралт, сувилалд 24 цагаар үүрэг гүйцэтгэж, ээлжинд гарч байгаа нь сувилагч нарыг “Хүнсний хангалтын тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/114 дугаартай тушаалаар батлагдсан “шөнийн ээлжид эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын тоо, албан тушаалын жагсаалт”-д тухайн нэгжийн ээлжийн сувилагчийн орон тоог тусгаж, хоолны мөнгийг олгуулах асуудлыг холбогдох нэгжид танилцуулж, шийдвэрлүүлэхээр байна.

**Тав.** Тус амралт сувиллын үйлчилгээнд ашигладаг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын бүртгэлтэй 2014 оны УА3220693 маркийн /пургон/ 5040 УБТ улсын дугаартай /гүйлт норм дууссан/ автомашиныг холбогдох нэгжид танилцуулж, шийдвэрлэх шаардлагатай.

**Зургаа.** Хүнсний эрүүл ахуйн аюулгүй шаардлагыг хангах зорилгоор хүнсний бүтээгдэхүүн зөөвөрлөх, тээвэрлэх битүү ачаатай, хөргүүртэй зориулалтын тээврийн хэрэгслийг үйлчилгээнд ашиглах нь зүйтэй гэж үзэхээр байна.

**Долоо.** Тус сувилалд эмчлэгддэг өвчний оношинд 277 нэр төрлийн тан шаардлагатай байгаагаас одоогоор 22 нэр төрлийн танг хэрэглэж байгаа нь хангалтгүй бөгөөд эмчилгээ бүрэн гүйцэт хийгдээгүй шалтгаанаар Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас санхүүжилтийг хасах эрсдэлтэй нөхцөл байдал үүсэхээр байна.

Шаардлагатай танг бүтэн жилийн хэрэгцээгээр худалдан авахад 40.000.000 /дөчин сая/ төгрөг зарцуулагдах тооцоо, судалгаа гаргасан байх тул эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлын эрхийг нэмэгдүүлэх шаардлага үүсэхээр байна.

### ТАВ. ЗӨВЛӨМЖ

**5.1.** Тус амралт, сувиллын үйл ажиллагаа явуулж байгаа газар нь нууцын зэрэглэлд хамаардаг гэх шалтгаанаар газрын гэрчилгээний эх хувь, кадастрын зураг байхгүй байгаа тул холбогдох байгууллагад нь хандаж, зохих журмын дагуу гаргуулан авах. /СААА, Сүүж уул сэргээн засах амралт сувилал /;

**5.2.** Тус амралт, сувиллын батлагдсан орон тооноос дутуу байгаа 12 орон тооны нөхөн хангалтыг шуурхай шийдвэрлүүлж, үйл ажиллагааг жигдрүүлэх. /ХНХ, ДХАБГ-ын Эрүүл мэнд, сэтгэл зүйн тасаг, Сүүж уул сэргээн засах амралт сувилал/;

**5.3.** Тус амралт, сувиллын ажилчдын амьдарч байгаа байруудын элэгдэл хорогдол, одоогийн нөхцөл байдал, учирч болох эрсдэлийг тодорхойлох зорилгоор Хот байгуулалт, хөгжлийн газрын Барилгын чанар, аюулгүй байдлын хэлтэс болон холбогдох мэргэжлийн байгууллагуудад хандаж, үзлэг, шалгалт хийлгэн дүгнэлт гаргуулж, хэрэгжилтийг хангах чиглэлээр арга хэмжээ авч, үйл ажиллагаандаа мөрдөх. /Сүүж уул сэргээн засах амралт сувилал /;

**5.4.** Амралт, сувиллын газрын үндсэн хөрөнгөнд тооллого хийж, газар хөдлөлт, цэвдгээс шалтгаалан цууралт, эвдрэл үүссэн барилга байгууламж, бороо усанд норж, дахин

ашиглах боломжгүй болсон эд зүйлсийн элэгдэл, хорогдлыг тооцож, үндсэн хөрөнгөнөөс хасах, алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах, амьдрах нөхцөл бололцоог хангах, тусгай мэдлэг, мэргэжил шаардах ажлын байранд алба хаагчийг томилон ажиллуулахад ая тухтай байдлыг бий болгох зорилгоор зөөврийн, угсардаг сууцаар үе шаттайгаар хангах асуудлыг судалж, шийдвэрлэх. /CAAA/;

5.5. Тус сувилалд сувилуулж байгаа иргэдэд шаардлагатай танг жилийн хэрэгцээнд худалдан авалт хийхэд 40.000.000 /дөчин сая/ төгрөг зарцуулагдах тооцоо, судалгаа гаргасан байх тул эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах зардлын эрхийг нэмэгдүүлэх талаар холбогдох газарт уламжлан шийдвэрлүүлэх. /CAAA, Сүүж уул сэргээн засах амралт сувилал /;

5.6. “Хүнсний хангалтын тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/114 дугаартай тушаалаар батлагдсан “Шөнийн ээлжид эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэдэг алба хаагчдын тоо, албан тушаалын жагсаалт”-д ээлжийн сувилагч ажлын байрны нэршлийг оруулж, хоолны мөнгийг олгуулах асуудлыг судлаж шийдвэрлүүлэх. /CAAA, Хуулийн хэлтэс, Сүүж уул сэргээн засах амралт сувилал /;

5.7. Тус амралт сувиллын үйлчилгээнд ашигладаг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын бүртгэлтэй 2014 оны УА3220693 маркийн /пургон/ 5040 УБТ улсын дугаартай автомашиныг холбогдох нэгжид танилцуулж, актлах./Авто бааз, Сүүж уул сэргээн засах амралт сувилал /;

5.8. Хүнсний эрүүл ахуйн аюулгүй шаардлагыг хангах зорилгоор хүнсний бүтээгдэхүүн зөөвөрлөх, тээвэрлэх битүү ачаатай, хөргүүртэй зориулалтын тээврийн хэрэгслээр хангах асуудлыг судлаж шийдвэрлэх. /CAAA, Сүүж уул сэргээн засах амралт сувилал /;

Зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

## ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Самбуугийн гудамж 18, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо,  
Улаанбаатар хот, 14201, Утас: 7019-1087, Факс: 7019-1087,

Цахим шуудан: info@police.gov.mn,

Цахим хуудас: www.police.gov.mn

2023.08.30 № 03/254

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА П.ХАДБААТАР ТАНАА

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын  
2022 оны санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар  
өгөгдсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн  
биелэлтийн байдалд хийсэн төлөвлөгөөт бус дотоод  
аудитын тайланг хүргүүлэв.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 7 хуудастай.

ДЭД ДАРГА, ЦАГДААГИЙН  
ХУРАНДАА

П.ОРОСТОГОО



1522 07 3666

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

2023 оны 08 дугаар  
сарын 15-ны өдөр

Улаанбаатар  
хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн байдалд хийсэн дотоод аудит.

Аудит хийгдсэн нэгж: Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллага /2022 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж авсан байгууллагууд/

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар хамруулав.

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ-ДХАБГ/НА-2023/12

Аудитын хугацаа: 2023.08.07-2023.08.14

Аудитын багийн ахлагч: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар, чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал.

Аудитын багийн гишүүн: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит /санхүүгийн/ хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул.

1. ТАНИЛЦУУЛГА

Манай аудитын баг хөндлөнгийн аудитаас Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан, нэгтгэсэн санхүүгийн тайлан тэнцэлд хийсэн хөндлөнгийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн байдалд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

1.1. Үндэсний аудитын газраас 2022 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн талаар:

Үндэсний аудитын газар болон орон нутгийн аудитын газарт Цагдаа, дотоодын цэргийн 55 байгууллага /нууцын зэрэглэлтэй 1 байгууллага/ 2022 оны санхүүгийн тайланг гаргаж хүргүүлж, түүвэрт хамрагдан 18, нийт 36 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийгдэж, "Өөрчлөлтгүй" санал дүгнэлттэй шалгагдсан байна.

Аудитаар нийт 2.698.047,7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 5 асуудлаар 4.148,9 мянган төгрөгийн төлбөрийн акт тавигдаж, 25 асуудлаар 589.528,1 мянган төгрөгийн албан шаардлага, 87 асуудлаар 1.367.175,7 мянган төгрөгийн зөрчил арилгуулах зөвлөмжийг ирүүлж, 737.194,4 мянган төгрөгийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд залруулга хийгдсэн.

Санхүүгийн аудитаар нийт 117 асуудлаар 1.960.852,7 мянган төгрөг, нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 17 асуудлаар 2.636.965,2 мянган төгрөгийн зөрчил заагдсан. / Хүснэгт 1. мян. төг/

Аудитын төрөл	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт зөрчил		Эзлэх хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Санхүүгийн	5	4.148,9	25	589.528,1	87	1.367.175,7	117	1.960.852,7	87.3
Нийцлийн	-	-	2	94.163,3	15	2.542.801,9	17	2.636.965,2	12.7
Нийт	5	4.148,9	27	683.691,4	102	3.909.977,6	134	4.597.817,9	100

Санхүүгийн аудитаар:

Бүлэг хооронд зөвшөөрөлгүй зарцуулсан, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй, авлага, өглөгийн тооцоо хийж ажиллаагүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй, ээлжийн амралт ажилласан хоногтой давхцуулан олгосон, анхан шатны баримтын бүрдэл дутуу, төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, худалдан авалт болон ажил үйлчилгээний төлбөрийг и-баримтгүй шилжүүлсэн ... зэрэг Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Засгийн газрын 127 дугаар тогтоол, Сангийн сайдын 190, 276, 347, 388 дугаар тушаал, бусад холбогдох журам, эрхзүйн актуудыг зөрчиж, санхүүгийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж авчээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар:

Төсөв өмч хөрөнгөтэй холбоотой /гэрээ/ шийдвэр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гэрээг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон, жилийн эцэст бөөн дүнгээр мэдээлсэн зэрэг Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөнөөс албан шаардлага, зөвлөмж авсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр зөрчил заагдаж, нийт 2.636.965,2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 15 зөвлөмж зөрчлийг Эрүүгийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба, Сүлд чуулга, Тээврийн цагдаагийн албаны Төмөр замын цагдаагийн газар, Дотоодын цэргийн 05, 805 дугаар анги, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн цагдаагийн газар, Баян-Өлгий, Дархан-Уул, Хөвсгөл, Өмнөговь, Сүхбаатар аймгийн цагдаагийн газар, Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс зэрэг 17 нэгж авчээ.

Мөн ЦЕГ-ын харьяа байгууллагуудын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд дээрх 17 байгууллага 2.636.965,2 мянган төгрөгийн мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй 46 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн тул хэрэгжилтэд хяналт тавиагүй, зөрчлийг давтан гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох талаар албан шаардлага өгсөн байна.

1.2.Хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас 2022 он, 2023 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжүүлсэн ажлын талаар:

1.Цагдаагийн байгууллагын дотоод аудитын 2022, 2023 оны төлөвлөгөөнд заасны дагуу "Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн байдал", "Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хөрөнгө, оруулалт, худалдан авах ажиллагаанд" төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус дотоод аудит хийж, нийт 13 асуудалд 13 төрлийн зөвлөмжийг, түүнчлэн Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны 2022 оны

04, 11 дүгээр сарын мөнгөн хөрөнгийн орлого, зарлага эрх зүйн актын дагуу хөтлөгдөж байгаа эсэхийг хянаж, 38, 1/310 дугаар танилцуулгаар Цагдаагийн ерөнхий газрын удирдлагад танилцуулж, гарсан шийдвэр, 4 зөвлөмжийг тус тус холбогдох нэгжид албан бичгээр хүргэсэн.

2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах, түүнтэй холбоотой гарч буй алдаа, зөрчлийг арилгах, сайжруулах зорилгоор "Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2021, 2022 оны дотоод аудитын төлөвлөгөө"-ний 2.14, 2.4-т заасны дагуу энэ оны 1 дүгээр сард 2021 оны жилийн эцсийн болон 2022 оны эхний хагас жилийн байдлаар 11 дүгээр сард Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, байцаагч /санхүүгийн/ нарын аудитын баг дотоод аудит хийж, тайлангаас үндэслэн нийт 10-н төрлийн үүрэг, зөвлөмжийг цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын удирдлагад хүргүүлэн биелэлтийг тооцсон. Мөн 2023 оны эхний хагас жилийн байдлаар энэ хуулийн хэрэгжилтийн байдлаар дотоод аудит хийгдэж байна.

3. Дотоод аудитын төлөвлөгөөнд тусгагдсан "Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтийг ХЗДХЯ, Үндэсний аудитын газарт тайлагнах" ажлын хүрээнд Цагдаа, дотоодын цэргийн 54 анги, байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2021 оны жилийн эцсийн болон 2022 он, 2023 оны 1-2 дугаар улирлын мэдээг /55 нэгж болж нэмэгдсэн/ нэгтгэн гаргаж, хуулийн хэрэгжилтийг хангах талаар цагдаагийн байгууллагаас хийсэн ажлын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт ХЗДХЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт цахим болон бичгээр хуулийн хугацаанд хүргэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яаманд хуулийн хугацаанд тайлагнасан мэдээллийг товчлон хүргэхэд дараах байдалтай.

Шилэн дансны тухай хуулийн 3.1 дүгээр зүйлд заасны дагуу 2023 оны эхний хагас жилийн байдлаар цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын шилэн дансны мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан тушаалтнаас нэгдсэн системд /нэг нэгж/ 15 төрлийн 4,125 мэдээллийг 100 хувь олон нийтэд тайлагнасан байна.

Мөн байршуулсан мэдээллийг хугацааны хувьд авч үзвэл 4,125 мэдээллээс хугацаандаа 4,075, хугацаа хоцроож 50 мэдээг байршуулж, хуулийн хэрэгжилтийн хүрээнд мэдээллийг 98.8 хувийн гүйцэтгэлтэй мэдээлжээ. /Хүснэгт 2/

Хүснэгт 2

д/д	Мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Хугацаандаа	Хугацаа хоцорсон	Хэрэгжилт
	Сар бүр мэдээлэх	1.705	1.678	27	98.4
	Бүтэн жилээр мэдээлэх	165	164	1	99.4
	Тухай бүр мэдээлэх	2.255	2.233	22	99.0
	Нийт	4.125	4.075	50	98.8

4. Үндэсний аудитын газраас санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар заагдсан зөрчил, дутагдлыг арилгуулах, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулах зорилгоор цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын удирдлагад Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 3а/5082 дугаар 7 заалт бүхий ажлын үүрэг, чиглэл мөн оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 3б/2284 дугаар албан бичгээр Дархан-Уул аймаг дахь цагдаагийн газарт үйл ажиллагаандаа хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмжийг боловсруулан хүргэсэн.

Мөн Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг өөрийн байгууллагын болон нэгдсэн цахим хуудсанд шилэн дансны зарчмыг баримтлан үнэн зөв, бүрэн мэдээлж, улирлын тайланг хуулийн хугацаанд илгээх талаар болон улирлын тайлан илгээгүй, дутуу илгээсэн, шинээр төсөв хуваарилагдсан нэгжийн холбогдох алба хаагчидтай утсаар холбогдон энэ талаар цахимаар зөвлөмж, зааварчилга өгсөн.

Шинэчилсэн Шилэн дансны нэгдсэн систем 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нэвтрүүлэхтэй холбогдуулан энэ оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэ системд цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагад бүртгүүлэх ажлын чиглэл хүргэж, 100 хувь хамруулсан.

## 2.АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 2.1 Аудитын зорилго

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан тэнцэлд хөндлөнгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд төлөвлөгөөт бус дотоод аудит хийж, удирдлагыг мэдээллээр хангах, аудитын объектыг боловсронгуй болгох, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан хүргүүлж, үр дүнг тооцох нь энэхүү аудитын зорилго юм.

### 2.2 Аудитын цар хүрээ

Үндэсний аудитын газраас цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн шалгалтын мөрөөр өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт, түүнд холбогдох бусад үйл ажиллагааг хамруулсан.

### 2.3 Аудитын зохион байгуулалт

Аудитыг хэрэгжүүлэхдээ холбогдох алба хаагчидтай ярилцлага хийх, асуулга, тайлбар, нэмэлт мэдээлэл цуглуулах, нотлох аргыг боловсруулан Санхүү, аж ахуйн албанаас ирүүлсэн материалаас түүвэр хийж, тулган баталгаажуулахад ашиглалаа.

## 3.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Аудитын хүрээнд цугларсан мэдээлэл, баримт материал үндэслэн энэхүү тайланд тусгаж, удирдлагад танилцуулан, шийдвэрлүүлбэл зохих дараах асуудлууд байна. Үүнд:

### Санхүүгийн аудитаар:

#### 3.1.Хөрөнгө материалын бүртгэл хөтлөлтэй холбоотой асуудлын талаар:

-Багахангай, Багануур дүүрэг, Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс нь ашиглалтын хугацаа дууссан, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны өртгөө нөхсөн, үлдэгдэл өртөггүй ашиглаж байгаа нийт 130 нэр төрлийн 561 ширхэг 711.022,6 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг дахин үнэлээгүй;

-Сүлд чуулга, Архангай аймгийн цагдаагийн газарт үндсэн хөрөнгийн шинж агуулаагүй элэгдэл байгуулахад тохиромжгүй тоног төхөөрөмж, тавилга, аж ахуйн эд хогшлын дансанд бүртгэлтэй, нийт 4.795,6 мянган төгрөгийн хөрөнгийг, Дорноговь аймгийн цагдаагийн газарт худалдан авсан материалыг тохирох материалын дансны ангилалд бүртгээгүй зэрэг асуудалд холбогдох газарт хүргүүлэн шийдвэрлүүлэн үнэлж, данс бүртгэлд бүртгэх зөвлөмж өгчээ.

Тус цагдаагийн нэгжүүдээс "2023 оны эхний хагас жилийн тооллогоор дахин үнэлгээ хийх, актлагдах саналыг шийдвэрлэх талаар хэлтсийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүдэд танилцуулан нийслэлийн болон аймгийн орон нутгийн өмчийн харилцааны газарт саналаа шийдвэрлүүлэхээр бэлтгэсэн, мөн хүргүүлсэн" талаар биелэлт ирүүлснийг үзэхэд зөвлөмжийн хэрэгжилт Сүлд чуулга, Багахангай, Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс 50.0 хувь буюу "хангалтгүй", Архангай, Дорноговь аймгийн цагдаагийн газар, Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс 70.0 хувь буюу "хангалттай" үнэлгээтэй байна.

3.2. Цалин хөлс, өглөг, авлагын тооцоотой холбоотой асуудлын талаар:

-Сэлэнгэ аймгийн Мандал сумын цагдаагийн хэлтэст ээлжийн амралтын цалингийн бодолтод өмнөх оны ээлжийн амралтын тооцоонд орсон цалинг оруулж, 5 алба хаагчид нийт 3.075.6 мянган төгрөгийг илүү олгосон зөрчилд өгсөн илүү олгосон цалинг нөхөж суутгах албан шаардлагын хэрэгжилт 50.0 хувь буюу "хангалтгүй";

-Ховд аймгийн цагдаагийн газарт бэлтгэн нийлүүлэгчийн хоорондын тооцоо зөрүүтэй тооцоо нийлж баталгаажуулаагүй, шатахууны хөнгөлөлт дутуу тооцсон, малын ашиг шимийн тооцоо хийгээгүй асуудалд өгсөн гэрээний үүргийн биелэлтийг тооцож, хөрөнгө орлогод авах зөвлөмжийн хэрэгжилт 70.0 хувь буюу "хангалттай" үнэлгээтэй байна.

Нийцлийн аудитаар:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр зөрчил заагдаж, нийт 2.636.965,2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 15 зөвлөмж зөрчлийг Эрүүгийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба, Сүлд чуулга, Тээврийн цагдаагийн албаны Төмөр замын цагдаагийн газар, Дотоодын цэргийн 05, 805 дугаар анги, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн цагдаагийн газар, Баян-Өлгий, Дархан-Уул, Хөвсгөл, Өмнөговь, Сүхбаатар аймгийн цагдаагийн газар, Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс зэрэг 17 нэгж авчээ.

3.3. Үүнээс Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн болон Баян-Өлгий, Өмнөговь, Хөвсгөл аймгийн цагдаагийн газар, Сэлэнгэ аймгийн Мандал, Сайхан сумын сум дундын цагдаагийн хэлтэс, Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс, Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс зэрэг 11 нэгж нь Шилэн дансны тухай хуульд заасан зарчмыг баримтлаагүй, хугацаа хоцроож байршуулсан, мэдээлэл дутуу болон бөөн дүнгээр мэдээлсэн зэрэг өмнөх онд илэрсэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой алдаа, зөрчлийг давтан гаргасан.

3.4. Дотоод аудит нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн хараат бус, бие даасан бодитойгоор баталгаажуулах, зөвлөх, үйл ажиллагаа юм.

Энэ нь системтэй, оновчтой арга хандлагаар байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж, сайжруулахад туслах үүрэгтэй бөгөөд санхүүгийн дотоод аудит хариуцсан ахлах байцаагчид нь албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажил үүргийн дагуу дотоод аудит хийж, удирдлагад танилцуулан, аудитаар илэрсэн асуудлыг сайжруулах чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох нэгжүүдэд хүргэж, үр дүнг тооцож ажиллажээ.

Гэвч дээрх 17 нэгжийн төсөв, хөрөнгийг захиран зарцуулах эрх, үүрэг бүхий төсөв захирагч нар хугацаа хоцроож мэдээлсэн тул хяналт тавиагүй, давтан зөрчил гаргасан асуудлаар Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйл "Хуулийн үйлчлэх хүрээ" 3.1 "Доор дурдсан байгууллага, түүний эд хөрөнгө захиран зарцуулах эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн үйлчлэлд хамаарна; 3.1.1 "төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд; гэж заасан тухайн үйлчлэлд хамаарахгүй албан тушаалтанд хариуцлага тооцох талаар албан шаардлага өгсөн байна.

3.5. Нийслэлийн цагдаагийн удирдах газар нь нийцлийн аудитаар цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын нийт 1.6 тэрбум төгрөгийн мөнгөн гүйлгээний 2 мэдээлэл хугацаа хоцроосон асуудалд зөвлөмж авч, хэрэгжилт 100.0 хувьтай байна.

Дээрх мөнгөн гүйлгээний хавсралт болох Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын даргын 2020 оны А/19 дүгээр тушаалын үндэслэлд холбогдох эрх зүйн акт болон Тагнуулын ерөнхий газрын 2020 оны 113 дугаар албан бичгийг дурдсанаас үзэхэд Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад дурдагдсан маш нууц ангилалд хамрагдахаар гэж үзэхээр байхад шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаа хоцроон



нийтэд мэдээлсэн, мөн Нийслэлийн аудитын газраас /Нийслэлийн аудитын газраас утсаар байршуулах чиглэл өгсөн гэх/ энэ мэдээлэлд зөвлөмж өгчээ.

#### 4. ДҮГНЭЛТ

Манай дотоод аудитын багаас 2023 оны эхний хагас жилийн байдлаар хэрэгжилтийг санхүүгийн аудитаар өгсөн төлбөрийн акт 100.0, албан шаардлага 96.0, зөвлөмж 95.0 хувийн хэрэгжилттэй буюу " маш сайн", нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн албан шаардлага 100.0, зөвлөмж 99.5 буюу "маш сайн" гэж дүгнэлээ.

Гэвч аудитын явцад цугларсан мэдээллээс үзэхэд төрийн аудитаас цагдаа, дотоодын цэргийн 2022 оны санхүүгийн тайлангийн гүйцэтгэлд "өөрчлөлтгүй" санал дүгнэлт авсан хэдий ч батлагдсан төсвийг хэмнэлтгүй, зардлын бүлэг хооронд зөвшөөрөлгүй, болон зориулалт бусаар зарцуулсан, ээлжийн амралт, цалин хөлс давхардуулан олгосон, анхан шатны баримтын бүрдэл дутуу, алба хаагчдын цалинг тушаал шийдвэргүй нэмэгдүүлсэн, и баримт хавсаргаагүй, өглөг авлагын тооцоо хийгээгүй, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангаагүй зэрэг нийтлэг, материаллаг бус алдаа, зөрчил давтан заагдсан хэвээр байна.

Дээрх хөндлөнгийн аудитаар илэрсэн зөрчлийг асуудлын тоогоор нягтлахад нийт зөрчлийн 87.3 хувь нь санхүүгийн аудит, 12.7 хувь нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал илэрчээ.

Энэ нь төсөв захирагч байгууллагын удирдлага болон ахлах нягтлан бодогчоос бүртгэлээр тавих хяналт сул, санхүү, хөрөнгөтэй холбоотой асуудлыг шуурхай зохион байгуулаагүй, холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилт болон Дотоод хяналт-аюулгүй байдлын газраас сайжруулах чиглэлээр хүргүүлсэн аудитын зөвлөмж, ажлын чиглэл, үүргийн биелэлтийг чанаргүй хэрэгжүүлснээс шалтгаалсан гэж үзэж байна.

Иймд хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хангах болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг дээшлүүлэх чиглэлээр Санхүү, аж ахуйн албанаас нэгжүүдэд тодорхой үүрэг, ажлын чиглэл хүргүүлж, тулгарч буй асуудлыг засаж, сайжруулахад дэмжлэг үзүүлэх, сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, шинээр томилогдсон алба хаагчийг шуурхай дадлагажуулах, цаашид алдаа зөрчил давтагдахгүй байхад анхаарч ажиллах шаардлагатай гэж дүгнэлээ.

Түүнчлэн хөндлөнгийн аудитаар өгч буй дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхдөө хууль тогтоомж, бусад журамтай нийцэж байгаа эсэхэд Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар, Хуулийн хэлтэстэй хамтран ажиллах нь зөрчлийг бууруулахад тодорхой хэмжээнд нөлөөлнө гэж үзлээ.

#### 5. ЗӨВЛӨМЖ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгжид хүргүүлэх саналтай. Үүнд:

5.1. Хөндлөнгийн аудитаар давтан зөрчил гаргасан, төсөв захирагч, ахлах нягтлан бодогч, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах үүрэг бүхий алба хаагчид хариуцлага тооцож, дүнг ирүүлэх /CAAA/;

5.2. Хөндлөнгийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлэх талаар үүрэг, чиглэлийг нэгжүүдэд хүргэж, дүнг тооцож ирүүлэх /CAAA, НЦУГ/;

5.3. Шинээр томилогдсон санхүүгийн алба хаагчид мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, дадлагажуулах ажлыг үр дүнтэй зохион байгуулж, сайжруулах, гарын авлагыг боловсруулан бэлтгэх /CAAA/;

5.4.Цаашид хөндлөнгийн аудитаар өгч буй дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхдөө хууль тогтоомж, бусад журамтай нийцэж байгаа эсэхэд Цагдаагийн ерөнхий газрын Дотоод хяналт-аюулгүй байдлын газар, Хуулийн хэлтэстэй хамтран ажиллах; /CAAA, НЦУГ, Орон нутгийн цагдаагийн газар, хэлтэс/;

5.5. Дотоод аудитаар илэрсэн асуудлыг цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах /ЦДЦАБ/;

Дотоод аудитаар илэрсэн асуудлыг сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг гарган 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

Удирдлагын шийдвэр: .....

ЗӨВШӨӨРСӨН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

ХЯНАСАН:  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

МӨН ГАЗРЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН  
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:  
АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Ё.МӨНХЗУЛ

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА

**ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН**

2023 оны 08 дугаар сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

**Аудитын нэр:** Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад ашиглагдаж байгаа автомашины /аймаг, дүүргээс түүвэрлэн/ шатахуун, шатах тослох материалын зарцуулалтын байдалд хийх дотоод аудит.

**Аудит хийгдсэн нэгж:** Баянзүрх дүүргийн цагдаагийн газар, Орхон аймгийн цагдаагийн газар.

**Аудитын объект:** Аймаг, дүүргээс түүвэрлэн Баянзүрх дүүргийн цагдаагийн газар, орхон аймгийн цагдаагийн газар ашиглагдаж буй албаны автомашины зарцуулалттай холбоотой үйл ажиллагааг /2022 он, 2023 оны 1-5 сарын/ хамруулсан.

**Аудитын төрөл, код:** Санхүүгийн аудит, ЦЕГ-ДХАБГ/СА-2023/11

**Аудитын хугацаа:** 2023.06.30-2023.08.02

**Аудитын багийн ахлагч:** Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар.

**Аудитын багийн гишүүн:** Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит /санхүүгийн/ хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул, Автобаазын Санхүү, аж ахуйн хэлтсийн нягтлан бодогч, цагдаагийн ахлах дэслэгч А.Номин-Эрдэнэ.

**1.ТАНИЛЦУУЛГА**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын албаны автомашинд шатахуун зарцуулалттай холбоотой харилцаа Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоол, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “ Жишиг норм батлах тухай” 390, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны “Шатахуун зарцуулалт, сэлбэг материалын ашиглалтын норм батлах тухай” 99 дүгээр тушаал, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “код 809”, Цагдаагийн ерөнхий газрын даргын “Автомашины тоо, хоногийн гүйлтийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 2021 оны А/38, 2023 оны А/54, А/117 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтын 4 дүгээр “Бараа материалын бүртгэл” бүлэг зэрэг эрхзүйн актаар зохицуулагдаж байна.

**1.1. Баянзүрх дүүргийн цагдаагийн газрын үйл ажиллагаанд ашиглагддаг автомашин болон шатахууны орлого, зарцуулалтын талаар:**

Баянзүрх дүүргийн цагдаагийн газар нь хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлэхэд албаны болон тусгай зориулалтын 13 маркийн 45 автомашиныг өдөр тутмын үйл ажиллагаандаа ашигладаг.

Тус цагдаагийн газар нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2022-2023 оны төсвийн төсөлд шатахууны зардлыг гүйцэтгэлд үндэслэж, нормоор тооцоолон нэг сард 42.1-48.5 сая төгрөгөөр тусгуулах саналыг боловсруулан дээд шатны төсөв захирагчид хүргүүлж, сард 2022 онд 17.3, 2023 онд 28.8 сая, жилд 207.6-345.6 сая төгрөгөөр батлагдсан байна.

Шатахууны орлогын бүртгэлийн талаар: Аудитад явцад ирүүлсэн шатахууны орлогын бүртгэл хөтлөлтийг үзэхэд төсвийн хөрөнгөөр шатахуун худалдан авснаас гадна нэмэлтээр дээд шатны төсөв захирагч болон бусад байгууллагаас шилжүүлэн авч, 2022 онд 438.5, 2023 оны 1-5 сарын байдлаар 170.2 сая төгрөгийн шатахууны орлогоор бүртгэж, данс бүртгэлд тусгажээ. /хүснэгт 1/

Хүснэгт 1 /сая.төгрөгөөр/

Он	Төсвийн хөрөнгөөр авсан шатахуун	Нэмэлтээр:				Нийт дүн	
		Үнэ төлбөргүй авсан	Шилжүүлэн авсан				Нэмэлтээр авсан дүн
			СААА, ТЦА-с	НЦУГ-с	Автобааз -с		
2022	349.6	13.9	44.7	30.3	0.03	88.9	438.5
2023 оны 1-5 сар	169.3	-	0.3	0.5	0.07	0.87	170.2

Шатахуун зарцуулалтын талаар: Баянзүрх дүүргийн цагдаагийн газар нь Цагдаагийн ерөнхий газрын даргын “Автомашин тоо, хоногийн гүйлтийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 2021 оны А/38, 2023 оны А/54, А/117 дугаар тушаалыг үндэслэн өөрийн батлагдсан нөөц бололцоонд тулгуурлан сар бүр хуваарь гарган батлан, олгож хэвшсэн байна.

Дээрх хуваарийн дагуу олгосон тээвэр шатахууны зардлыг гүйцэтгэлээр авч үзэхэд 2022 онд 434.2, 2023 оны эхний 5 сарын байдлаар 165.9 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

## **1.2. Орхон аймгийн цагдаагийн газрын данс бүртгэлтэй автомашин болон шатахууны орлого, зарцуулалтын талаар:**

Орхон аймгийн цагдаагийн газар нь үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй 21 маркийн 40 автомашин, 6 мотоцикльтой хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлдэг.

2022 оны төсвийн төсөлд түлш, шатахууны зардлыг жилийн 164.5 сая төгрөгөөр тооцоолон санал хүргүүлснээр 109.9 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор төсвийн хэмнэлттэй холбоотойгоор 108.7 сая төгрөг болгон өөрчлөлт оруулсан байна.

Шатахуун орлого бүртгэлийг шалгахад улсын төсвийн урсгал санхүүжилтээр 108.7, орон нутгийн санхүүжилтээр 24.3, галт зэвсгийн сургалтын 0.7, Шүүхийн шийдвэрээр 0.5, харилцагч байгууллагаас үнэ төлбөргүй олгосон урамшуулал 4.3, нийт 138.5 сая төгрөгийн шатахууныг орлогод авч, данс бүртгэлд тусгасан байна.

Тээвэр шатахуун зардлыг олгохдоо жишиг нормативын дагуу өдөр бүр хуваарь гарган баталж, олгосноос гадна нэмэлт шатахууныг баталсан төлөвлөгөө, маршрутыг үндэслэн, нийт 139.4 сая төгрөгийн шатахуун зарцуулжээ.

Мөн данс бүртгэлтэй автомашин тус бүрт нормын дагуу шатах тослох материалыг тооцоолон өвөл, зуны хуваарийг гарган баталгаажуулан олгосон байна.

## **2. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

### **2.1 Аудитын зорилго**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад ашиглагдаж байгаа автомашины /аймаг, дүүргээс түүвэрлэн/ шатахуун, шатах тослох материалын зарцуулалтын байдалд дотоод аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлж, үр дүнг тооцох, аудитын объектын үйл ажиллагааг сайжруулан, боловсронгуй болгоход оршино.

### **2.2 Аудитын цар хүрээ**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас түүвэрлэн Баянзүрх дүүргийн цагдаагийн газарт ашиглагддаг автомашины 2022 он, 2023 оны 1-5 дугаар сар, Орхон аймгийн цагдаагийн газарт ашиглагдаж байгаа автомашины 2022 оны байдлаар шатахуун, шатах тослох материалын зарцуулалт, мөрдөгдөж буй норм, мэдээлэл түүнд холбогдох бусад үйл ажиллагааг аудитын объектод хамруулсан.

### **2.3 Аудитын зохион байгуулалт**

Аудитын удирдамж, төлөвлөгөөг холбогдох нэгжийн удирдлага, болон холбогдох алба хаагчдад албан бичгээр хүргүүлэн танилцуулж, Баянзүрх дүүрэг болон Орхон аймгийн цагдаагийн газрын шатахууны бүртгэл хөтлөлттэй холбоотой тайлан, тооцоолол бүхий бусад баримт бичгийг гаргуулан авч, ажилласан.

Түүнчлэн аудитын явцад цуглуулсан мэдээлэлд үндэслэн тулган баталгаажуулах, дахин тооцоолох, нэгтгэн дүгнэх, аргыг ашиглан дүгнэлт гарган, нотлох баримтад тулгуурлан аудитын тайланг боловсруулсан.

### 3.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ

Аудитын хүрээнд цугларсан мэдээлэл, баримт материал үндэслэн энэхүү тайланд тусгаж, удирдлагад танилцуулан, шийдвэрлүүлвэл зохих дараах асуудлууд байна. Үүнд:

3.1.Баянзүрх дүүргийн цагдаагийн газар ашиглагдаж буй нийт 13 маркийн 46 автомашинд шатахууны нормыг жишиг нормоос зөрүүтэй, үндсэн норм тогтоолгүй 2022 онд илүү 13.6, дутуу, 9.4, 2023 онд илүү 5.7, дутуу 4.3 сая төгрөгийн, мөн Орхон аймгийн цагдаагийн газар илүү 4.5, дутуу 13.7 сая төгрөгийн шатахуун тус тус олгосон нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Жишиг норм батлах тухай” 390, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны “Шатахуун зарцуулалт, сэлбэг материалын ашиглалтын норм батлах тухай” А/99 дүгээр тушаалыг зөрчсөн байна. /хүснэгт 2/

Хүснэгт 2 /мян. төгрөгөөр/

Байгууллагын нэр	Огноо	Илүү олгосон шатахуун		Дутуу олгосон шатахуун	
		литр	мөнгөн дүн	литр	мөнгөн дүн
БЗДЦГ	2022	5.761	13.557.491	3.918	9.453.645
	2023 оны 01-05 сар	2.347	5.655.430	1.784	4.283.622
Орхон ЦГ	2022	1.797	4.534.395	5.521	13.715.131

3.2.Баянзүрх дүүргийн шатахуун зарцуулалтын байдлыг үзэхэд 2022 онд 434.2 сая, 2023 онд 165.9 сая төгрөгийн шатахуун зарцуулжээ.

Үүнээс нэмэлтээр 2022 онд 6.5 сая төгрөгний шатахуун олгосноос шуурхай албаны болон дуудлагын нийт 14 автомашинд олгосон 3.3 сая төгрөгийн 1.369 литр шатахууныг анхан шатны баримтын бүрдэл дутуу, зөвхөн цохолтоор тооцож олгосон. /төлөвлөгөө, маршрут гаргаж батлуулаагүй...гэх мэт/

Түүнчлэн Киа спортеж маркийн 02-19УАТ улсын дугаартай автомашины жолооч 2022 онд 3.1 сая төгрөгийн 1,329.3 литр, киа рио маркийн 16-07УАТ улсын дугаартай автомашины жолооч 1.0 сая төгрөгийн 422.9 литр шатахуун авч, жолоочийн тооцооны замын хуудас хөтлөөгүй, автомашин хэрэглэсэн албан тушаалтан явсан зам /км/ хянаж зураагүй, ренаулт дастер маркийн 13-92 УАМ автомашины жолооч 242.8 литр шатахууны тооцоог замын хуудсанд дутуу тайлагнасан, шатахууны тооцоог нягтлан бодогч тооцоо хийж түлш шатахууны хэтрэлт, хэмнэлтийг гаргаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Энэ нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Цагдаагийн албанд ашиглагдах тээврийн хэрэгсэлд хяналт тавих /код-809/ журам”-ын 809.5.2.Автомашиныг хэрэглэгчид очсон цагаас эхлэн замын хуудсанд тэмдэглэл хийж, буулгах хүртэлх хугацаанд жолоочийн сахилга хариуцлага, автомашины ашиглалтын байдлыг автомашин хэрэглэгч байгууллага, албан тушаалтан хариуцна”, 809.5.3 дахь хэсэгт “Автомашин хэрэглэгч байгууллага, албан тушаалтан автомашиныг зориулалтын дагуу ажиллуулж жолоочийн замын болон дагалдах хуудсанд ажилд ирсэн, буцсан цаг, явсан километрийг үнэн зөв бичиж баталгаажуулах, автомашиныг зөвшөөрөлгүйгээр граж, паркаас гадуур тавихыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

3.4.Орхон аймгийн цагдаагийн газрын даргын 2022 онд “Цагдаагийн газрын тээврийн хэрэгслүүдийн тос тосолгооны материал олгосон жагсаалт”-д нийт 25 автомашинд 3.3 сая төгрөгийн тос тосолгооны материал олгохоор баталжээ.

Дээрх батлагдсан жагсаалтын дагуу 10 автомашинд 1.4 сая төгрөгийн тос тосолгооны материал олгож, 15 автомашинд 1.9 сая төгрөгийн тос тосолгооны материал олгосон эсэх тодорхойгүй анхан шатны баримт бүрдээгүй /зарцуулалтын тайлан гаргаагүй/ байхад бөөн дүнгээр материалыг зардалд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Сангийн сайдын 2012 оны 294 дүгээр “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам”-ын 4 дүгээр хэсгийн 4.1.7 “... өдөр тутмын гүйлгээг бүрдэл болсон баримтаар цаг хугацаанд нь бүртгэж тайлан, тооцооны ажлыг боловсронгуй, хөнгөн шуурхай болгох” гэж заасныг зөрчсөн байна.

#### **4. ДҮГНЭЛТ**

Аудитад түүвэрлэгдэн хамрагдсан Баянзүрх дүүргийн болон Орхон аймгийн цагдаагийн газрын удирдлагын дотоод хяналт сул, нягтлан бодогчийн бүртгэлээр тавих хяналт хангалтгүй мөн нягтлан бодох бүртгэлийн холбогдох эрх зүйн актыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлээгүйгээс шатахуунтай холбоотой алдаа зөрчил илэрсэн гэж үзлээ.

Тухайлбал: Шатахууны нормыг зөрүүтэй /илүү, дутуу/ тооцоолсон, жолоочийн замын хуудсыг тухай бүр хөтөлдөггүй, автомашиныг авч ажил ажилласан албан тушаалтан замын хуудсанд явсан замыг хянаж, гарын үсгээр баталгаажуулаагүй, нягтлан бодогч өмнөх сарын тооцоо хийгээгүй автомашинд шатахуун нэмж олгосон, анхан шатны баримтын бүрдэлгүй баримтаар шатах тослох материалыг зарлагадсан байна.

Иймд аудитын багаас дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичиг үндэслэн цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад ашиглагдаж байгаа автомашины /аймаг, дүүргээс түүвэрлэн/ шатахуун, шатах тослох материалын зарцуулалт, түүнд холбогдох үйл ажиллагаагаар илэрсэн асуудал нь цаашид давтагдахаар гэж үзэн “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэж байна.

#### **5. ЗӨВЛӨМЖ**

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгжид хүргүүлэх саналтай. Үүнд:

5.1.Аудитаар илэрсэн автомашины 100 км-д зарцуулах шатахууны нормыг зөрүүтэй тооцож олгосон 2022 онд илүү 13.6, дутуу, 9.4, 2023 онд илүү 5.7, дутуу 4.3 сая төгрөгийн зөрчил болон нэмэлтээр шуурхай албаны болон дуудлагын нийт 14 автомашинд шатахууны анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй олгосон 3.3 сая төгрөгийн зөрчлийг арилгах /БЗДЦГ/;

5.2. Жолоочийн замын хуудас хөтлөөгүй, шатахууны зарцуулалтын тайлан дутуу бүрдүүлсэн алба хаагчид хариуцлага тооцож, зөрчлийг арилгах /нөхөн бүрдүүлэх/ ажлыг зохион байгуулах /БЗДЦГ/;

5.3.Анхан шатны баримтын бүрдэлгүй зарлагадсан 1.9 сая төгрөг, мөн автомашины 100 км-д зарцуулах шатахууны нормыг зөрүүтэй тооцож олгосон илүү 4.5, дутуу 13.7 сая төгрөгийн зөрчлийг арилгаж, цаашид тос тосолгооны материалыг автомашин тус бүрээр зарлага болгож хэвших /Орхон аймгийн цагдаагийн газар/;

5.4.Албаны автомашины ашиглалтын болон шатахуун зарцуулалтын байдалд хяналт тавих зорилгоор автомашины гүйлтийг тулган баталгаажуулж, спидометрийн заалтыг жолоочийн замын хуудас дахь заалттай тохирч байгаа эсэхэд хяналт, шалгалтыг зохион байгуулах. /БЗДЦГ, Орхон аймгийн цагдаагийн газар/;

5.5.Шатахууны лимитийг сар бүр холбогдох эрхзүйн баримтыг үндэслэн батлуулан олгож, шатахуун зарцуулалтыг спидометрийн заалттай тулган хэтрэлт хэмнэлтийг тооцсоны дараа шатахуун олгох. /БЗДЦГ, Орхон аймгийн цагдаагийн газар/;

Дотоод аудитаар илэрсэн асуудлыг сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, дүнг 2023 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх.

## **6. УДИРДЛАГЫН ТАЙЛБАР**

Дотоод аудитын урьдчилсан тайланг холбогдох нэгжид хүргүүлсний дагуу Баянзүрх дүүргийн цагдаагийн газар энэ оны 08 дугаар сарын 04-ны өдрийн 28ж/1886, Орхон аймгийн цагдаагийн газар мөн өдрийн 40/02-5694 дүгээр албан бичгээр “Удирдлагын тайлбар”-ыг ирүүлсэн нь тайланд дурдсан болон илэрсэн асуудалд тусгуулах саналгүй, илэрсэн зөрчлийг арилгаж, үйл ажиллагаандаа холбогдох эрхзүйн актыг баримталж ажиллах талаар ирүүлсэн байна.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Цагдаагийн алба хаагчдын нормын хувцас,  
хэрэглэлийн эдэлгээний хугацаа, чанар, ашиглалтын байдалд  
дотоод аудит хийсэн талаар”

2023 оны 09 дүгээр  
сарын 26-ны өдөр

№ 1/151

Улаанбаатар  
хот

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.5-т заасны дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав, цагдаагийн хошууч Э.Анхчимэг, Б.Наранбаяр, ахлах сэтгэл зүйч, цагдаагийн хошууч О.Оюунбилэг нар “Цагдаагийн алба хаагчдын нормын хувцас, хэрэглэлийн эдэлгээний хугацаа, чанар, ашиглалтын байдал”-д дотоод аудит хийлээ.

**Нэг. Санал асуулгын дүнгийн талаар:**

Аудитын ажлын хүрээнд цагдаагийн алба хаагчдын нормын хувцас, хэрэглэлийн эдэлгээний хугацаа, чанар, ашиглалтын байдлын талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн түвшинг тодруулах, шаардлагатай шинэчлэлт, өөрчлөлтийн талаар саналыг удирдлагад уламжлах зорилгоор асуумж боловсруулан алба хаагчдаас санал асуулга авсан.

Санал асуулгыг 2023 оны 09 дүгээр сарын 04-ний өдрөөс 19-ний өдрийн хооронд “googleform” ашиглан цахимд байршуулан 3259 алба хаагчийг хамруулан явуулж, боловсруулалтыг хийлээ.

Судалгааны асуумжийн үзүүлэлтээр авч үзвэл:

**Үйл ажиллагааны чиглэлийн хувьд:** Захиргааны удирдлагын чиг үүргийн 393 алба хаагч буюу нийт оролцогчдын 12,1 хувь, эрүүгийн цагдаагийн албаны чиг үүргийн 391 алба хаагч буюу 12 хувь, мөрдөн байцаах албаны чиг үүргийн 174 алба хаагч буюу 5,3 хувь, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийн 1216 алба хаагч буюу 37,3 хувь, замын цагдаагийн чиг үүргийн 389 алба хаагч буюу 11,9 хувь, санхүү, аж ахуйн чиг үүргийн 129 алба хаагч буюу 4 хувь, мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны чиг үүргийн 374 алба хаагч буюу 11,5 хувь, экологийн цагдаагийн албаны чиг үүргийн 51 алба хаагч буюу 1,6 хувь, бусад чиг үүргийн буюу чиглэлээ сонгоогүй 180 алба хаагч буюу 5,5 хувийг тус тус эзэлж байна.

**Албан тушаалын байдлаар:** Офицер 1711 алба хаагч буюу 52,5 хувь, ахлагч 1548 алба хаагч буюу 47,5 хувь хамрагдсан байна.

**Ажилласан жилийн хувьд:** Нэг хүртэл жил ажилласан гэж 378 алба хаагч буюу 11,6 хувь, 1-5 жил ажилласан гэж 1058 алба хаагч буюу 32,5 хувь, 6-10 жил ажилласан гэж 635 алба хаагч буюу 19,5 хувь, 11-15 жил ажилласан гэж 583 алба хаагч буюу 17,9 хувь, 6-20 жил ажилласан гэж 499 алба хаагч буюу 15,3 хувь, 21-ээс дээш жилээр ажилласан гэж 106 алба хаагч буюу 3,3 хувийг эзэлж байна.



Анкетын хэсгээс авч үзэхэд дээрх судалгаанд офицер албан тушаалд ажилладаг алба хаагчид түлхүү хамрагдсан, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албаны алба хаагчдын санал бодол түлхүү тусгагдсан гэж үзэж болохоор байна.

Аудитын үйл ажиллагааны үндсэн асуумжаар албаны дүрэмт хувцас, хэрэглэлийн ашиглалт, эдэлгээний талаарх алба хаагчдын сэтгэл ханамжийн саналд:

1. Та Санхүү, аж ахуйн албаны Хангалт, үйлчилгээний төвөөс хувцас, хэрэглэлээ хугацаанд нь бүрэн авч чаддаг уу? гэсэн асуултад:

- Тийм, тухай бүр байгууллагаараа эсвэл өөрөө очоод авдаг гэж 520 алба хаагч буюу 16 хувь,

- Хэсэгчлэн авдаг. Очих үед эсвэл байгууллагаас өгснийг нь аваад үлдээдэг гэж 1183 алба хаагч буюу 36,3 хувь нь,

- Үгүй, үргэлж хугацаанаасаа хойш хожимдож авдаг гэж 1011 алба хаагч буюу 31 хувь нь,


- Үгүй, үргэлж хувцас, хэрэглэл дутагдалтай бусдаас худалдан авдаг гэж 847 алба хаагч буюу 26,8 хувь нь хариулснаас харахад Хангалт, үйлчилгээний төвд ихэвчлэн хувцас, хэрэглэлийн хангалт дутуу, алба хаагчид сэтгэл ханамж доогуур байгааг харж болохоор байна.

2. Хангалт, үйлчилгээний төвөөс танд өгсөн хувцас танд таардаг уу? гэсэн асуултад

- Тийм, үргэлж өөрийн размераар хувцас авлаг гэж 280 алба хаагч буюу 8,6 хувь нь,

- Заримдаа, хувцсыг хасуулах, солилцох зэргээр зохицуулдаг гэж 2093 алба хаагч буюу 64,2 хувь нь,

- Ихэнхдээ үгүй. Үргэлж хасуулах, хувиараа оёулах шаардлага гардаг гэж 993 алба хаагч буюу 30,5 хувь нь хариулсан байна.



3. Албанаас олгож буй хувцас, хэрэгсэл таны бодлоор эрүүл ахуйн болон бусад шаардлагыг хангадаг уу? гэсэн асуултад:

- Тийм, сайн хувцас, хэрэглэлтэй гэж нийт судалгаанд оролцогчдын 919 нь буюу 28,2 хувь нь,

- Хэсэгчилсэн. Зарим хувцас бие үрэх, харшил өгөх гээд байдаг гэж 1888 алба хаагч буюу 57,9 хувь нь,

- Үгүй, ижил төрлийн материалаар өөрөө хувцас хийлгэж өмсдөг гэж 590 алба хаагч буюу 18,1 хувь нь хариулсан бол ямар хувцас хэрэглэл эрүүл ахуйн болон бусад шаардлагыг хангадаггүй вэ гэсэн асуултад:

- Хээрийн хагас түрийт, ботинк, өвлийн гутал чийг татаж, хөлөргөдөг, доороос хайрдаг гэх зэрэг хариултыг 1950 удаа,

- Индүүдлэг авдаггүй, арчилгааны хувьд төвөгтэй, бөөсөрдөг ноосон цамц, поло подволк гэж 792 удаа,

- Хээрийн хувцас амьсгалдаггүй, хурдан ганддаг, хөдөлгөөнд саад учруулдаг зэргээр 2468 удаа,

- Борооны цув нэвтэрдэг, жиндүүлдэг зэргээр 364 удаа,

- Материал ширүүн, бие үрдэг гэж 453 удаа,

- Бүх хувцас гэж 570 удаа,

- Цагаан, цэнхэр цамц өнгөө хурдан алдаж, сэмэрдэг гэж 456 удаагийн хариулт өгсөн нь дээрх хувцасны материалд анхаарал хандуулах шаардлагатайг харуулж байна.

3. Таны хувьд албанаас олгож буй хувцасны чанар хэр байдаг гэж дүгнэж байна вэ? гэсэн асуултад:

- Хангалттай сайн гэж 115 алба хаагч буюу 3,5 хувь,

- Сайн гэж 765 алба хаагч буюу 23,5 хувь,

- Дунд зэрэг гэж 1510 алба хаагч буюу 46,3 хувь,

- Тааруу гэж 664 алба хаагч буюу 20,4 хувь,

- Муу гэж 311 алба хаагч буюу 9,5 хувь нь үзсэн бол ямар төрлийн хувцас болохыг тодруулсан асуултад:

- Бүх төрлийн гутал гэж 1254 алба хаагч,

- Хээрийн хувцас амьсгалдаггүй, хурдан ганддаг, хөдөлгөөнд саад учруулдаг зэргээр 2468 удаа,

- Борооны цув нэвтэрдэг, жиндүүлдэг зэргээр 364 удаа,

- Материал ширүүн, бие үрдэг гэж 453 удаа,

- Бүх хувцас гэж 570 удаа,

- Цагаан, цэнхэр цамц өнгөө хурдан алдаж, сэмэрдэг гэж 236 удаа,

- 5.11 шиг чанартай, эдэлгээ сайтай хувцас хэрэглэлтэй болмоор байна гэж 214 удаа,

- Өнгөө алдаж, агшиж сунах зэргээр эдэлгээ даадаггүй хувцас олон байна гэж 879 удаа тус тус хариулсан байна.

4. Та албанаас олгож буй хувцасны эдэлгээ, ашиглалтын байдлыг хэрхэн үнэлж байна вэ? гэсэн асуултад

- Маш сайн гэж 80 алба хаагч буюу 2,5 хувь нь,

- Сайн гэж 798 алба хаагч буюу 24,7 хувь нь,

- Дунд гэж 1560 алба хаагч буюу 48,3 хувь нь,

- Тааруу гэж 619 буюу 19,2 хувь нь,

- Муу гэж 285 буюу 8,8 хувь нь тус тус үзсэн бол дунд, тааруу гэж үзсэн алба хаагчдаас ямар төрлийн хувцас болохыг тодруулахад:

- Хээрийн хувцас гэж 1226 алба хаагч,

- Өвлийн хувцас гэж 547 алба хаагч,

- Бүгд гэж 745 алба хаагч,

- Сорочкан цамцнууд гэж 789 алба хаагч гэх зэргээр өмнөх хариултууд давтагдсан байна.

5. Таны эрхэлж буй төрөл мэргэжлийн хувьд аль хувцсыг түлхүү өмсөж хэрэглэдэг вэ? гэсэн олон сонголтот асуултад

- Хээрийн хувцас гэж 1937 алба хаагч буюу 59,4 хувь нь,
- Өдөр тутмын хувцас гэж 388 алба хаагч буюу 11,9 хувь нь,
- Парад буюу ёслол амралтын хувцас гэж 259 алба хаагч буюу 7,9 хувь нь,
- Цагаан цамц гэж 179 алба хаагч буюу 5,5 хувь нь,
- Цэнхэр цамц гэж 91 алба хаагч буюу 2,8 хувь нь,
- Поло футболк гэж 97 алба хаагч буюу 3 хувь нь
- Бусад төрлийн хувцас хамгийн багаар хэрэглэгддэг гэсэн сонголтуудыг хийсэн байна.

6. Таны төрөл мэргэжлээс хамаарсан хувцас, хэрэглэлийн элэгдэл нь хувцас олгож буй хугацаатай тохирдог уу? гэсэн асуултад

- Тийм гэж 358 алба хаагч буюу 11 хувь,
- Зарим хувцас элэгдэж амждаггүй ч, зарим нь маш хурдан элэгддэг гэж 1737 алба хаагч буюу 53,3 хувь,
- Үгүй, ихэнх хувцас хугацаанаасаа өмнө үргэлж элэгддэг, хувиасаа авах, хийлгэх шаардлагатай байдаг гэж 1260 алба хаагч буюу 38,7 хувь нь үзсэн байна. Иймд хувцас хэрэглэлийг албаны чиг үүрэгт тохируулан ялгамжтай хугацаагаар олгодог болох нь зүйтэй байна.

7. Таны бодлоор эдэлгээний хугацааг богиносгох шаардлагатай хувцас, хэрэглэлийг бичнэ үү гэсэн нээлттэй асуултад:

- Хээрийн хувцас гэж 1547 удаа,
- Бүх хувцас гэж 588 удаа,
- Цагаан, цэнхэр цамц гэж 985 удаа,
- Бүх төрлийн гутал гэж 1216 удаа,
- Савхи гэж 256 удаа,
- Парад китель гэж 156 удаа,
- Борооны цув, ноосон цамц гэж 548 удаа
- Бүх хувцас хугацаандаа тохирдог гэж 1320 удаа тус тус хариулсан байна.

8. Таны эрхэлж буй төрөл мэргэжлийн хувьд ямар хувцас, хэрэглэл бага хэрэглээтэй байна вэ гэсэн нээлттэй асуултад:

- Парад китель гэж 986 удаа,
- Өдөр тутам гэж 145 удаа,
- Хээр гэж 422 удаа,
- Тийм хувцас байхгүй гэж 1568 удаа,
- Цув гэж 985 удаа,
- Өвлийн гутал гэж 546 удаа тус тус хариулсан байна.

9. Таны хувьд биед тухгүй, өмсөхөд төвөгтэй, арчилгаа, цэвэрлэгээний хувьд хүндрэлтэй хувцас аль нь вэ гэсэн нээлттэй асуултад:

- Ноосон цамц гэж 855 удаа,
- Өвлийн хүрэм гэж 1125 удаа,
- Парад китель гэж 458 удаа,
- Өдөр тутам гэж 877 удаа,

- Тийм хувцас байхгүй гэж 706 удаа тус тус хариулсан байна.
- 10. Таны бодлоор ямар төрлийн хувцас, хэрэглэлийн загвар, өнгө үзэмжийг өөрчлөх хэрэгцээ шаардлагатай вэ? гэсэн асуултад:
  - Хээр гэж 1788 алба хаагч,
  - Өдөр тутам гэж 546 алба хаагч,
  - Борооны цув гэж 1204 алба хаагч,
  - Өвлийн өмд, хүрэм гэж 258 алба хаагч,
  - Ноосон цамц гэж 245 алба хаагч,
  - Акселвант, бүс нэг ч удаа авч байгаагүй, гэтэл цэнхэр акселвант бүсийг улаантайгаар сольчихсон байна.
  - Хээрийн хувцсан дотор болон дангаар өмсөх зориулалттай хар өнгийн ханцуйтай, захгүй цамц,
  - Ер нь бүх хувцасны материалын чанарыг сайжруулж, хугацааг богиносгох хэрэгтэй,
  - Өвлийн шинэ загварын гутал чийг маш их татдаг хөл хайрдаг тийм учир хуучин загвараар нь хийж олгох, борооны цув хуучин хэвэнд аваачих өмсдөг биш, зуны шар хантаазыг зангуутайг өөрчилж урдаа цахилгаантай болгох,
  - Хээрийн хувцас, агсамжийг хантааз хэлбэрт оруулбал зохимжтой. Хантаазан агсамжинд энгэрийн камер гар станц, гав, дандагч гэх мэт тусгай хэрэгсэл зүүж хэрэглэх боломжтой байвал харагдах байдал сүрлэг, эд хэрэгсэл эвдрэл авах магадлал бага байх болов уу,
  - Цувны загвар, хийцийг сайжруулах, нэвтэрч, жиндүүлдэг тул өөрчлөх, хуучин загвар нь сайн,
  - Төрлийг нь цөөрүүлж, хангалтаа нэмэх,
  - Бүх хувцсыг биед эвтэйхэн байдлаар шийдэж материалын чанарт анхаарах,
  - хээр, парад бүгдийг нь нэг үйлдвэрээр оёулмаар байна үйлдвэр болгон өөр өөр хэмжээстэй байна,
  - Нарийн мэргэжлийн алба хаагч нарт хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлтэй болгомоор байна,
  - Хагас түрийтэй гутал, шар хантааз, тусгай хэрэгслийн иж бүрдэл, сүүлд тавьж өгсөн өвлийн гутал өмсөхөд хэцүү дулаанаа барьдаггүй, гүйж харайхад тохиромжгүй, данхар том байна зэрэг саналуудыг ирүүлсэн байна.

### **Хоёр. Өнөөгийн нөхцөл байдлын талаар**

Цагдаагийн албаны тухай хуулийн 88 дугаар зүйлийн 88.3 дахь хэсэгт "...цагдаагийн бусад алба хаагчийн дүрэмт хувцасны загвар, түүний эдэлгээний хугацаа, цагдаагийн алба хаагчид дүрэмт хувцасны мөнгөн хангамж олгох журмыг Засгийн газар ... батална." гэж зааснаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолоор дүрэмт хувцасны загвар, түүний эдэлгээний хугацаа, дүрэмт хувцасны мөнгөн хангамж олгох журмыг баталсан.

Дээрх тогтоолыг мөрдөж эхэлснээс хойших хугацаанд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 431, 2021 оны 17, 2022 оны 96 дугаар тогтоолоор тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан байна.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас тухайн төсвийн жилд дүрэмт хувцасны хангалтад хуваарилсан төсөвт багтаан худалдан авах ажиллагааг тухай бүрт зохион байгуулж, худалдан авах ажиллагааг явуулсан байна.

Санхүү, аж ахуйн албанаас дээрх сэдвийн хүрээнд ажлын хэсэг байгуулан судалгаа хийж, дүгнэлт гарган, цагдаагийн албаны чиг үүрэг, ажлын байрны онцлог, байгаль цаг уур, техник, технологийн хөгжил дэвшил, бусад орны цагдаагийн алба хаагчийн хэрэглэж буй дүрэмт хувцасны загварын чиг хандлага болон алба хаагчид (хэрэглэгч)-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл, албаны бэлэн байдал, гаргасан санал, хүсэлтэд нийцүүлэн зарим нэр төрлийн дүрэмт хувцасны загвар, эдэлгээний хугацаанд нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналыг боловсруулан Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчийн энэ оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/366 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн байна. Тус саналд:

Нэг. Зарим нэр, төрлийн дүрэмт хувцасны загварыг өөрчлөх талаар.

1.1.“Өдөр тутмын хүрэм” (загвар 2-05, 2-07) нь эргэсэн зах бартаатай, далд товчлоостой байсныг гадаадын зарим орны болон Монгол Улсын төрийн тусгай чиг үүргийн алба хаагчийн өмсөж буй албаны хүрэмний загварт нийцүүлэн өмсөхөд хялбар болгон энгэрийг уулзсан цахилгаан товчлоостой болгон загварыг шинэчлэх;

1.2.“Борооны хүрэм, өмд” (загвар 2-25, 2-26) нь шаардлагатай үед зориулалтын дагуу дүрэмт хувцасны гадуур өмсөхөд тохиромжгүй байсныг сул хэлбэртэй, урт хормойтой цувны шийдэлтэй болгон загварыг шинэчлэн, нэршлийг “Борооны цув” болгох;

1.3.“Гэрэл ойлгогчтой хантааз” (зуны, өвлийн, загвар 2-27, 2-28)-ыг байгууллагын соёлч, жагсаалч байдал, гадаад өнгө үзэмжийг сайжруулах, байгаль цаг уур, улирлын байдал, алба хаагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, албаны бэлэн байдал (нуруунд өгч буй 4152 грамм жинтэй механик ачааллыг бууруулж, тэнцвэржүүлэх)-ыг хангах зорилгоор тоногтой суран бүсний станцын гэр, гар чийдэнгийн гэр, хийн бортогоны гэр, дохиур модны гэр, хийн сумны гэр, шалгах төхөөрөмжийн гэр, баримт бичгийн цүнх зэрэг 7 иж бүрдлийг хантаазны энгэрийн гадна болон дотор талын халаас, нэмэлт үүрэнд байршуулах, мөн гадаадын бусад орны цагдаагийн алба хаагчийн хэрэглэж буй хантаазны загвартай дүйцүүлэн хар, саарал өнгөний хосолсон шийдэлтэйгээр шинэчилж, нэршлийг “Гэрэлтүүлэгчтэй зуны хантааз” болгон өөрчлөх;

1.4.Тоногтой суран бүсний иж бүрдэл нь (загвар 5-01-11, 5-14) нь үхрийн ширэн материалтай, (гар бууны гэр, станцын гэр, бороохойны гэр, гар чийдэнгийн гэр, хийн бортогоны гэр, бугуйн гавны гэр, дохиур модны гэр, шалгах төхөөрөмжийн гэр, хэвлэх төхөөрөмжийн гэр, хийн бууны сумны гэр, баримт бичгийн цүнх) гэсэн 11 иж бүрдэлтэй байгаа нь гудамж, талбайд үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нь хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг иж бүрдлийн гэрэнд хийж, хэрэглэхэд дунджаар “4152 грамм”-ын жинтэй механик ачааллыг нуруундаа үүрдэг болгох;

Хоёр. Загварын шинэчлэлтэй уялдуулан эдэлгээний хугацааг өөрчлөх талаар.

2.1.“Гэрэл ойлгогчтой хантааз (зуны, өвлийн)”-ны эдэлгээний хугацааг албаны чиг үүрэг, ажлын байрны онцлогтой уялдуулан “Цагдаагийн хурандаа цолтой болон бусад чиг үүрэг гүйцэтгэх алба хаагч”-ийн ангилалд “2 жил” гэснийг “4 жил”, “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах шууд чиг үүрэг гүйцэтгэх алба хаагч”-ийн ангилалд “1 жил” гэснийг “3 жил” гэж өөрчилж, хугацааг 2 жилээр уртасгах;

2.2.“Тоногтой суран бүсний иж бүрдэл”-ийн эдэлгээний хугацаа “Цагдаагийн хурандаа цолтой болон бусад чиг үүрэг гүйцэтгэх алба хаагч”-ийн ангилалд “8 жил” гэснийг “6 жил”, “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах шууд чиг үүрэг гүйцэтгэх алба хаагч”-ийн ангилалд “4 жил” гэснийг “3 жил” гэж өөрчилж, хугацааг 1-2 жилээр богиносгох;

2.3. Нийслэлийн цагдаагийн удирдах газрын “Эрүүлжүүлэх, саатуулах төв”-ийн энэ оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 28а-2/116 дугаар албан бичиг, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 28/1718 дугаар албан бичгээр ирүүлсэн хүсэлт, ажлын байрны онцлог, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлд нийцүүлэн “Өдөр тутмын хүрэм, өмд”-ний эдэлгээний хугацааг “Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах шууд чиг үүрэг гүйцэтгэх алба хаагч”-ийн ангилалд “2 жил” гэснийг зөвхөн “Эрүүлжүүлэх, саатуулах байр”-д үүрэг гүйцэтгэх алба хаагчид “1 жил”-ээр тооцон олгохыг тайлбар хэсэгт нэмэлтээр тусгах зэрэг болно.

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах санал батлагдсанаар дүрэмт хувцасны зардалд шаардагдах хөрөнгийг өмнөх загварын дүрэмт хувцасны нөөц, эдэлгээний хугацаатай уялдуулан үе шаттайгаар бэлтгэх бодлого, чиглэлийг барьж, улсын төсөвт хүндрэл учруулахгүйгээр дотооддоо шийдвэрлэх бүрэн боломжтой байна” гэсэн саналыг тусган хүргүүлжээ.

### Гурав. Дүгнэлт:

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн цагдаагийн алба хаагчийн нормын хувцас, хэрэглэлийн эдэлгээний чанар, ашиглалтын байдалд хийсэн аудитын багаас дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

**Нэг.** Алба хаагчдаас авсан санал асуулгаар “Хээрийн хувцасны дотор болон дангаар өмсөх зориулалттай хар өнгийн ханцуйтай, захгүй цамц шаардлагатай, Өвлийн шинэ загварын гутал чийг маш их татдаг хөл хайрдаг тийм учир хуучин загвараар нь хийж олгох, борооны цув хуучин хэвэнд аваачих, зуны шар хантаазыг зангуутайг өөрчилж урдаа цахилгаантай болгох, хээрийн хувцас, агсамжийг хантааз хэлбэрт оруулбал зохимжтой, хантаазан агсамжинд энгэрийн камер гар станц, гав, тандагч гэх мэт тусгай хэрэгсэл зүүж хэрэглэх боломжтой байвал харагдах байдал сүрлэг, эд хэрэгсэл эвдрэл авах магадлал бага байх болов уу, цувны загвар, хийцийг сайжруулах, нэвтэрч, жиндүүлдэг тул өөрчлөх, хуучин загвар нь сайн, нормын хувцасны төрлийг нь цөөрүүлж, хангалтаа нэмэх, бүх хувцсыг биед эвтэйхэн байдлаар шийдэж материалын чанарт анхаарах, хээр, парад бүгдийг нь нэг үйлдвэрээр оёулмаар байна, үйлдвэр болгон өөр өөр хэмжээстэй байна, нарийн мэргэжлийн алба хаагч нарт хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлтэй болгомоор байна, хагас түрийтэй гутал, шар хантааз, тусгай хэрэгслийн иж бүрдэл, сүүлд тавьж өгсөн өвлийн гутал өмсөхөд хэцүү дулаанаа барьдаггүй, гүйж харайхад тохиромжгүй, данхар том байна” гэж дүгнэсэн байна.

**Хоёр.** Аудитын явцад дээрх санал асуулгад дурдагдсан асуудлуудыг судалж үзэхэд Санхүү аж ахуйн албанаас судлан, дүгнэж, засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах саналд “Борооны хүрэм, өмд” (загвар 2-25, 2-26) нь шаардлагатай үед зориулалтын дагуу дүрэмт хувцасны гадуур өмсөхөд тохиромжгүй байсныг сул хэлбэртэй, урт хормойтой цувны шийдэлтэй болгон загварыг шинэчлэн, нэршлийг “Борооны цув” болгох, “Гэрэл ойлгогчтой хантааз” (зуны, өвлийн, загвар 2-27, 2-28)-ыг байгууллагын соёлч, жагсаалч байдал, гадаад өнгө үзэмжийг сайжруулах, байгаль цаг уур, улирлын байдал, алба хаагчийн эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдал, албаны бэлэн байдал (нуруунд өгч буй 4152 грамм жинтэй механик ачааллыг бууруулж, тэнцвэржүүлэх)-ыг хангах зорилгоор тоногтой суран бүсний станцын гэр, гар чийдэнгийн гэр, хийн бортогоны гэр, дохиур модны гэр, хийн сумны гэр, шалгах төхөөрөмжийн гэр, баримт бичгийн цүнх зэрэг 7 иж бүрдлийг хантаазны энгэрийн гадна болон дотор талын халаас, нэмэлт үүрэнд байршуулах, мөн гадаадын бусад орны цагдаагийн алба хаагчийн хэрэглэж буй хантаазны загвартай дүйцүүлэн хар, саарал өнгөний хосолсон шийдэлтэйгээр шинэчилж, нэршлийг

“Гэрэлтүүлэгчтэй зуны хантааз” болгон өөрчлөх, Тоногтой суран бүсний иж бүрдэл (загвар 5-01-11, 5-14) нь үхрийн ширэн материалтай, (гар бууны гэр, станцын гэр, бороохойны гэр, гар чийдэнгийн гэр, хийн бортогоны гэр, бугуйн гавны гэр, дохиур модны гэр, шалгах төхөөрөмжийн гэр, хэвлэх төхөөрөмжийн гэр, хийн бууны сумны гэр, баримт бичгийн цүнх) гэсэн 11 иж бүрдэлтэй байгаа нь гудамж, талбайд үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нь хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслийг иж бүрдлийн гэрэнд хийж, хэрэглэхэд дунджаар “4152 грамм”-ын жинтэй механик ачааллыг нуруундаа үүрдэг болгох зэрэг саналуудыг тусгасныг дэмжиж шийдвэрлүүлэх нь зүйтэй.

**Дөрөв. Санал:**

Судалгаанд оролцсон алба хаагчдаас зарим нэр төрлийн хувцасны тухайлбал, шинэ хангалтын өвлийн гутал, хээрийн хувцас, цэнхэр цамцны материалын чанар байдал, борооны цув, агсамж, хантаазны, загвар зэрэгт шүүмжлэлтэй байгаа тул Санхүү, аж ахуй албанаас хийгдэж байгаа судалгаа шинжилгээ, түүний үр дүн, нормын хувцас, хангалтын материалын технологи, давуу тал, судлагдсан байдал болон Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 155 дугаар тогтоолоор баталсан “Дүрэмт хувцасны загвар, түүний эдэлгээний хугацаа, дүрэмт хувцасны мөнгөн хангамж олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахаар Хууль зүй, дотоод хэргийн сайдад энэ оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 01/366 дугаартай албан бичгээр санал хүргүүлсэн талаарх ажил арга хэмжээний мэдээлэл боловсруулж анги, байгууллагын дарга, захирагч нарт хүргэн алба хаагчдад тайлбарлуулах зохион байгуулалт авахыг Санхүү, аж ахуйн алба /цагдаагийн хурандаа Д.Батчулуун/-д даалгах саналтайг Танд илтгэн танилцуулъя.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд дотоод аудит хийсэн талаар”

2023 оны 09 дүгээр  
сарын 27-ны өдөр

№ 1/152

Улаанбаатар  
хот

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.3-т заасны дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал, дотоод аудит хариуцсан байцаагч, цагдаагийн хошууч Б.Наранбаяр, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа П.Тулга нар “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд дотоод аудит хийлээ.

**Нэг.Өнөөгийн нөхцөл байдлын талаар:**

Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг цаг үеийн нөхцөл шаардлагад нийцүүлэх, хуульд заасан баталгаагаар хангах ажлыг эрчимжүүлэх, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгуулах, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах замаар тэдний аюулгүй байдлыг хангах, мэдлэг, өөрийгөө хөгжүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор 2020-2023 онд хэрэгжүүлэх “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/163 дугаар тушаалаар баталсан байна.

Дээрх тушаалын хавсралтаар “Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, “Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт”, “Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг тус тус баталжээ.

Хөтөлбөрийн 5 зорилтыг хангахад чиглэсэн нийт 89 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд Хуулийн хэлтэс хариуцан зохион байгуулж, биелэлт үр дүнг тооцоход 2021 онд 66.4, 2022 онд 93.3, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 86.2 хувьтай байна.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг зохион байгуулж, хариуцан хэрэгжүүлэх нэгжүүдийг хүснэгтээр харуулбал:

д/д	Анги, байгууллага	Хэрэгжилт хариуцах	Хамтран хэрэгжүүлэх
1	Хуулийн хэлтэс	24	8
2	Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага	17	29
3	Аюулгүй байдлын хэлтэс	12	6
4	Санхүү, аж ахуйн алба	8	6
5	Соён гэгээрүүлэх, албаны сургалтын хэлтэс	8	5



6	Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтэс	7	2
7	Хүний нөөцийн хэлтэс	6	1
8	Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба	5	6
9	Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төв	5	5
10	Хяналт шалгалт, дотоод аудитын хэлтэс	4	-
11	Албад	3	12
12	Интерполын үндэсний төв товчооны ажлын алба	3	1
13	Хэвлэл, мэдээллийн төв	3	-
14	Урьдчилан сэргийлэх хэлтэс	2	-
15	Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэс	1	3
16	Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба	1	-
17	Нийслэлийн цагдаагийн удирдах газар	1	-

Уг хөтөлбөрийн хүрээнд төсвөөс зарцуулсан мөнгөн дүнг оноор харуулбал;

Он	2020	2021	2022	2023
Алба хаагчийн тоо	647	480	479	341
Мөнгөн дүн	22.238.700.000	17.932.600.000	5.130.850.000	15.029.100.000

Хөтөлбөр хэрэгжих үе шатанд гэмт хэрэг, зөрчилд өртөж хохирсон алба хаагчдын тоон үзүүлэлтийг оноор харуулбал;

Он	2020	2021	2022	2023
Зөрчил	20	9	4	
Хүн	34	9	4	
Гэмт хэрэг	146	210	210	140
Хүн	154	223	106	146

Хөтөлбөрийн хэрэгжилтийн шатанд дараах үр дүн, үр нөлөө гарсан байна. Үүнд:

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчид тулгамдаж байгаа асуудал, алба хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх санал, шаардагдах төсвийн талаар танилцуулгыг боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн ээлжит бус хуралдаанаар хэлэлцүүлэн, алба хаагчдын цалинг 38-66 хувиар нэмэгдүүлсэн;

-Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан "Цагдаагийн байгууллагын зарим ажил, үйлчилгээ, хангалтын жишиг норматив"-ын дагуу 6096 орон тоог нэмэгдүүлэх судалгаа гарсны дагуу нэмэгдүүлэх орон тооны саналаа жил бүр Төсвийн тухай хуульд заасан хугацаанд холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлснээр 2019 онд 123, 2020 онд 320, 2021 онд 650, 2022 онд 958, 2023 онд 20 орон тоо нийт 2071 орон тоогоор нэмэгдүүлж, тухай бүр нь алба нэгжүүдэд хуваарилж, алба хаагчдыг томилуулсан;

-Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвтэй хамтран "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл", "Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс"-ыг байгуулж, онолын суурь мэдлэгийг эзэмшүүлэх зорилгоор "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл

ахуй” сэдэвт сургалтыг цахимаар зохион байгуулж, сургалтад нийт 52 анги, байгууллагын 210 алба хаагчийг хамруулж, мэргэшүүлсэн;

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ахлагч албан тушаалын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор зохион байгуулсан шалгалтад тэнцсэн 668 иргэнийг “Төрийн жинхэнэ албаны нөөц”-д бүртгэж, Дотоод хэргийн Их сургуулийн Ахлагчийн сургуулийн “Цагдаа”, “Харуулчин” мэргэжлийг 326 иргэнд эзэмшүүлсэн бөгөөд алба, нэгж, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр 520 иргэнийг цагдаагийн тангаргийг өргүүлж, ахлагч албан тушаалын сул орон тоонд томилж, цагдаагийн бага цол олгуулсан;

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчийн сахилга, ёс зүйн зөрчлийн талаарх өргөдөл, гомдол, мэдээллийг шалгаж тогтоон, үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор явуулсан албаны шалгалт нь холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хийгдсэн эсэх хууль тогтоомжийн дагуу сахилгын арга хэмжээ оногдуулсан захиргааны акт нь хууль зүйн үндэслэлтэй эсэх, мөн алба хаагчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хууль бусаар хөндөж, зөрчиж байгаа эсэхийг судалж, Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, холбогдох зөвлөмж, чиглэлийг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдөр 01/349 дугаартай албан бичгээр цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад хүргүүлсэн;

-Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 453 дугаар тогтоолын дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагын албан хэрэгцээнд шаардлагатай хамгаалах тусгай хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, гудамж талбайн камержуулалт, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны МН-1а/02 дугаартай тушаалаар байгуулж, 5 нэр, төрлийн нэг бүрийн болон хамгаалах тусгай хэрэгслийг худалдан авах ажиллагаанд зориулж шийдвэрлэсэн 9,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээс “Хьюндай юниверс” маркийн том оврын автобус 4, “Хьюндай каунти” маркийн дунд оврын 2, “Тоёота хайс” маркийн микробус 2 ширхгийг тус тус худалдан авч, парк шинэчлэлт хийсэн;

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, олон улсын байгууллагуудтай хамтран алба хаагчдын мэдлэг ур чадвар, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор Итали-1, Филиппин-102, ХБНГУ-4, Вьетнам-3, Тайланд-2, Египет-1, нийт 10 удаагийн сургалтад нийт 113 алба хаагчийг гадаад улсад, гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, хууль сахиулах байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтарч БНЧУ-10, АНУ-40, БНСУ-11, Япон-6 нийт 67 алба хаагчийг дотоодын холбогдох сургалтад хамруулж, харилцан туршлага солилцсон байна.

Тус хөтөлбөрийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Хөтөлбөрийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээг цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллага 2 жилд, хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг цагдаагийн төв байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан болон хуулийн асуудал хариуцсан нэгж хамтран тус тус хийнэ” гэсэн заалтын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд 30 зорилтын хүрээнд 32 шалгуур үзүүлэлтээр хяналт шинжилгээ хийж, хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын үр дүнг цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд үнэлж, дүгнээгүй зөвхөн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тооцсон байна.

Үр дүнг тооцохгүйгээр тухайн зохион байгуулсан ажил, арга хэмжээ хэрхэн хэрэгжсэн, ахиц өөрчлөлт гарсан эсэх, зэрэг болон сөрөг үр дагавар, үр нөлөө юунаас шалтгаалан үүссэн болохыг тодорхойлох боломжгүй гэдгийг удирдах албан тушаалтан, хариуцсан алба хаагч нар бүрэн ухамсарлан ойлгох нь зүйтэй.

Цаашид хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нэгж тус бүрээр 32 шалгуур үзүүлэлтээр хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч дүгнэх, үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион байгуулсан нэгжийн удирдлага, алба хаагчдыг шагнаж урамшуулах, шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй, удирдлага, зохион байгуулалт, дотоод хяналтыг сул хэрэгжүүлсэн нэгжийн удирдлага, алба хаагчдын үйл ажиллагааг эрчимжүүлэх, алдаа, дутагдал, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

#### **Хоёр.Дүгнэлт:**

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичигт үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/163 дугаарын тушаалаар баталсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг бүрэн хангахад дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

**Нэг.Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нэгж тус бүрээр 32 шалгуур үзүүлэлтээр хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч дүгнэх, үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион байгуулсан нэгжийн удирдлага, алба хаагчдыг шагнаж урамшуулах, шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй, удирдлага, зохион байгуулалт, дотоод хяналтыг сул хэрэгжүүлсэн нэгжийн удирдлага, алба хаагчдын үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариуцлага тооцох.**

**Хоёр.Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн 1.6 “Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалахад зохих үр нөлөө үзүүлэх хууль тогтоомжийг шинэчилсэн, нэмэлт өөрчлөлт оруулсан байх”, 2.4 “Удирдах ажилтнаас алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчих явдал таслан зогсоогдоно”, 2.5 “Нөлөөлөл буурч, цагдаагийн байгууллагын нэгдмэл, төвлөрсөн удирдлагын зарчим хангагдаж, төрийн албаны чадахуйн зарчим хэрэгжинэ”, 2.6 “Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтсийн бүтэц, орон тоо оновчтой зохион байгуулагдана”, 3.5 “Алба хаагч, ажилтны аюулгүй байдлыг хангах шинэ техник хангамжийг нэвтрүүлсэн байх”, 3.6 “Нийгэм, эдийн засгийн баталгааг хангаж, алба хаагчдын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулсан байх” гэсэн заалтуудыг хангахад чиглэсэн үр дүнтэй ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй бол зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт хангагдахгүй байх, үйл ажиллагааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байгааг анхаарах шаардлагатай гэж дүгнэж байна.**

#### **Гурав.Санал, зөвлөмж:**

1.“Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн байдалд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын нэгж тус бүрээр 32 шалгуур үзүүлэлтээр хяналт шинжилгээ хийж, үнэлгээ өгч дүгнэх, үр дүнтэй ажил, арга хэмжээ зохион байгуулсан нэгжийн удирдлага, алба хаагчдыг шагнаж урамшуулах, шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй, удирдлага, зохион байгуулалт, дотоод хяналтыг сул хэрэгжүүлсэн нэгжийн удирдлага, алба хаагчдын үйл ажиллагааг эрчимжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг;

2.Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн 1.6, 2.4, 2.5, 2.6, 3.5, 3.6 заалтуудыг хангахад чиглэсэн үр дүнтэй ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхгүй бол зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт хангагдахгүй байх, үйл ажиллагааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэл байгааг анхаарч, хариу арга хэмжээг авч дүнг ирүүлэхийг;

3.Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 12 дугаар сарын 12-ны дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэхийг Хуулийн хэлтэст даалгах саналтай байгааг Танд илтгэн танилцуулья.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

“Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэс, Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хэвлэл мэдээллийн төвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тооцох, түүний мөрөөр хэрэгжүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох, чиг үүргийн хийдлийн байдалд дотоод аудит хийсэн талаар”

2023 оны 10 дугаар  
сарын 23-ны өдөр

№ 1/160

Улаанбаатар  
хот

Цагдаагийн ерөнхий газрын Дэд даргын баталсан удирдамжийн дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал, дотоод аудит хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав, Урьдчилан сэргийлэх хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Өсөхбаяр, Хэвлэл мэдээллийн төвийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Дэлгэрхангай, Хуулийн хэлтсийн чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Х.Наранбаатар, Судалгааны төвийн ахлах судлаач, цагдаагийн дэд хурандаа Б.Намсрай, Хүний нөөцийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Б.Батцэцэг, Интерполын үндэсний төв товчооны ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Б.Билгүүн нар “Цагдаагийн ерөнхий газрын Хуулийн хэлтэс, Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хэвлэл мэдээллийн төвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тооцох, түүний мөрөөр хэрэгжүүлэх хариу арга хэмжээг тодорхойлох, чиг үүргийн хийдлийн байдал”-д дотоод аудит хийлээ.

**Нэг.Өнөөгийн нөхцөл байдлын талаар:**

**1.1.ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН ТАНИЛЦУУЛГА**

Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл мэдээллийн төв нь анх 1997 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цагдаагийн алба хаагчийн албан болон мэргэжлийн сургалтад хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөнөөс ашиглах, олон нийтэд сурталчлах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын даргын 1997 оны 77 дугаар тушаалаар “Хэвлэл, мэдээллийн хэсэг” нэршилтэйгээр байгуулагдаж, “Нэр төр” сонины нарийн бичгийн дарга 1, сурвалжлагч 1, төлөөлөгч 1, нийт 3 офицерын орон тоотой байгуулагджээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2006 оны 618 дугаар тушаалаар Хэвлэл, мэдээллийн албыг “Хэвлэл, мэдээллийн төв” болгон өөрчилж, төвийн дарга 1, мэдээлэл хариуцсан ахлах байцаагч 2, мэдээлэл хариуцсан байцаагч 3, техникийн ажилтан 3, нийт 9 орон тоотойгоор баталсан байна.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллага, аж ахуйн нэгж, сайт, пейжийн тоо болон иргэд, олон нийтийн зүгээс цахим орчны хэрэглээ эрс нэмэгдсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны А/136 дугаар тушаалаар ахлах мэргэжилтэн 3, мэргэжилтэн 1, орон тоог нэмж, тус төвийн орон

тоог 14 болгож баталжээ.

Мөн даргын 2022 оны Б/04 дүгээр тушаалаар Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны Хангалт, үйлчилгээний төвийн бүтцэд байсан “Хэвлэх хэсэг”-ийг тус төвийн бүтцэд шилжүүлсэн ба одоо төвийн дарга 1, Цахим мэдээлэл, мониторингийн хэсгийн чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 3, Мэдээлэл дүрсжүүлэх хэсгийн чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 4, Мэдээлэл бэлтгэх, хэвлэх хэсгийн ахлах мэргэжилтэн 1, сэтгүүлч, редактор 1, мэргэжилтэн 2, эх бэлтгэгч 1, ахлах хэвлэгч 1, хэвлэгч, техникч 1, хянагч, дэвтэрлэгч 1, офицер 16, ахлагч 3, нийт 19 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тус төв нь “Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах бодлого боловсруулах, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ажлыг зохион байгуулах” чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Хэвлэл, мэдээллийн төвийн өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа хэдий ч улс төр, нийгэм, хүн ам зүй, цаг үеийн нөхцөл байдал, мэдээ, мэдээллийн эрчим, хүн амын дижитал болон сошиал медиа орчны хэрэглээний хэт өсөлт, мэдээ, мэдээллийн тархалтын хурд, хариу арга хэмжээ авах арга, тактик өдрөөс өдөрт хувьсан өөрчлөгдөж байгаа нь тус төвийн үйл ажиллагаанд техник технологийн шинэчлэл, хүний нөөцийн ур чадвар, мэдрэмж, ажлын гүйцэтгэл сайтай байхыг шаардаж байна.

Тус төвөөс 2021-2023 онд дараах үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүнд;

-Цагдаа, дотоодын цэргийн байгууллага, алба хаагчтай холбоотой болон гэмт хэрэг, зөрчлийн талаар өдөр тутмын сонин хэвлэл, цахим мэдээллийн хэрэгсэлд нийтлэгдсэн нийт 11709 мэдээ, мэдээллийн агуулгыг тоймлон нийт 553 удаа “Хэвлэлийн тойм”, 107 удаагийн “Долоо хоногийн тойм”-ыг бэлтгэж, Цагдаагийн ерөнхий газрын удирдлагуудад танилцуулж цаг үеийн мэдээ, мэдээллээр хангаж ажилласан;

-Цагдаагийн байгууллага, алба хаагч руу чиглэсэн сөрөг мэдээлэл цахим орчинд нийт 401 удаа нийтлэгдсэн бөгөөд хариу арга хэмжээний хүрээнд 21 удаа хэвлэлийн хурал зохион байгуулж, 210 удаа хариу тайлбар мэдээллийг давхардсан байдлаар 38 сайтад 5987 мэдээллийг цахим хуудсандаа нийтэлсэн;

-Шууд чиглэсэн сөрөг агуулгатай 69 мэдээллийг устгуулж, сөрөг 27 мэдээ, мэдээллийн гарчгийг өөрчилж, сөрөг мэдээлэл, шууд дамжуулалтуудад цаг алдалгүй 37 удаагийн хариу тайлбар мэдээлэл өгч, залруулга, тодруулга мэдээллийг бэлтгэж нийт 34 удаа цахим орчинд түгээсэн;

-Цагдаагийн байгууллага, алба хаагч руу чиглэсэн сөрөг мэдээллүүдийн хандалтыг бууруулах, мэдээллийг саармагжуулах зорилгоор 2729 удаагийн эерэг мэдээ, мэдээллийг цахим орчинд түгээсэн;

-Хэвлэл, мэдээллийн төвийн фейсбүүк цахим хуудаст иргэдээс ирүүлсэн гэмт хэрэг, зөрчлийн болон цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны талаар нийт 3858 санал, хүсэлтэд хариулт, хууль, эрх зүйн зөвлөгөө өгч, 79 мэдээллийг холбогдох байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн;

-Монголын Сэтгэл зүйчдийн нийгэмлэгтэй хамтран иргэд олон нийт, цахим хэрэглэгчдэд сэтгэл зүйн шалтгаанаас үүдэлтэй сөрөг үр дагавраас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл олгох зорилгоор “Сэтгэл зүйчтэй ярилцъя” видео контентын 10

дугаар бэлтгэж, Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл, мэдээллийн төвийн цахим хуудсанд байршуулсныг 80,000 орчим хүн үзэж, 105 сэтгэгдэл илэрхийлж, 1320 удаа бусадтай хуваалцсан;

-Иргэд, олон нийт, цахим хэрэглэгчдэд аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зарим төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг сэтгэл зүйн шинжлэх ухааны судалгааны үр дүнгээр тайлбарласан “Залилан мэхлэгчийн сэтгэл зүйн онцлог”, “Залилан мэхлэлтэд өртдөг хүмүүсийн сэтгэл зүйн онцлог”, “Мансууруулах бодисын сэтгэл зүйд үзүүлэх 4 сөрөг нөлөө”, “Хүмүүс яагаад согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолооддог вэ”, “Архи согтууруулах ундаанаас үүдэлтэй хүчирхийлэлд өртсөн хүүхдийн сэтгэл зүй” гэсэн сэдвээр 1 минут 20 секундээс 2 минутын богино хэмжээний 5 видео контентыг бэлтгэж, цахим орчинд түгээсэн ба нийт 456.000 үзэлт, 81 сэтгэгдэл, 1061 удаа бусадтай хуваалцсан байна.

-Цагдаагийн байгууллагын талаарх иргэдийн санал сэтгэгдэл, мэдээллийн хүртээмжтэй байдал”-д судалгаа хийж, Улаанбаатар хотын 6 дүүргийн нийт 25 байршилд, анкетын аргаар 711, биечилсэн ярилцлагын аргаар 354, нийт 1065 иргэнийг санамсаргүй түүврийн аргаар оролцуулж, дүнг Цагдаагийн ерөнхий газрын даргын зөвлөлийн гишүүд болон холбогдох алба, нэгжүүдэд танилцуулж, холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн.

Дотоод аудитаар тус төвийн үйл ажиллагаанд дараах эрсдэлүүд учирч болзошгүй байгааг анхааруулж байна. Үүнд;

- Мэдээлэл дүрсжүүлэх хэсгийн техникийн хүчин чадал хүрэхгүй байгаагаас зарим тохиолдолд алба хаагчийн ур чадварт суурилсан ажлын гүйцэтгэл хангагдахгүй байх, удирдах албан тушаалтнууд, алба хаагчдын дунд үүрэг гүйцэтгэлтэй холбоотой үл ойлголцол үүсэх;
- Цахим мэдээлэл, мониторингийн хэсгийн үйл ажиллагаанд контент бэлтгэх чиг үүрэг бий болсноор цахим орчинд гарсан мэдээ, мэдээллийн шүүлт дутуу хийгдэх, цаг хугацаа алдаж мэдээлэл авах, хожимдож хариу арга хэмжээг төлөвлөх, чанартай дүн шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал байх;
- Хэвлэл, мэдээллийн төвийн фейсбүүк хуудсанд ирж буй иргэдийн санал, хүсэлт, гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэлд хариу өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох нэгжид хүргүүлэх үйл ажиллагааг хариуцсан алба хаагч байхгүйгээс үйл ажиллагаанд доголдол үүсэх, байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх;
- Байгууллага, алба хаагч, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах сэтгүүл зүйн бүтээл, мэдээ, контентыг сэтгүүлч мэргэжилгүй, чиг үүргийн бус ахлах албан тушаалтан хянаж, засварлаж, редакторлаж байгаа нь олон нийтэд түгээж байгаа мэдээллийн агуулга, хүртээмж, нийтлэлийн шаардлагад нийцэхгүй байх;
- Алба хаагчдыг хэвлэл мэдээлэл, сэтгүүлзүй, контент бүтээх, мэдээлэлд дата анализ хийх чиглэлээр нарийн мэргэжлийн сургалтад хамруулаагүйгээс олон нийтийн цахим сүлжээнд тавигдсан мэдээлэлд хариу арга хэмжээг хэрэгжүүлэх туршлага, ур чадвар дутагдах;

- Алба хаагчдад орон нутагт томилолтоор ажиллаж олон талт мэдээ, мэдээлэл бэлтгэх, контент бүтээх ажилд зарцуулах төсөв, хөрөнгө байхгүйгээс ажлын гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлөх;
- Сэтгүүлчидтэй хувийн дугаар ашиглаж харьцдаг, албанд ашиглах гар утасны дугаар, нэгж олгогдохгүй, алба хаагчдын ашиглаж байгаа компьютер, техник хэрэгсэл нь албан ажлын шаардлага хангахгүй байгаагаас тус төвийн үйл ажиллагаа саатах;
- Төвийн даргаас санал авалгүйгээр алба хаагчдыг ажлын хэсэг, төлөвлөгөөт ажил, арга хэмжээнд хуваарилах, контент бэлтгэх ажил даалгаснаар үндсэн үйл ажиллагаанд хүндрэл үүсэх;
- Сонгуулийн жил эхлэхтэй холбогдуулан цагдаагийн байгууллага, алба хаагч руу чиглэсэн улс төрийн хүрээний, худал, ташаа, төөрөгдүүлсэн мэдээ, мэдээллүүдийн эрчим дээшлэхтэй холбогдуулан алба хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх;
- Алба хаагчдын сошиал медиа хэрэглээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор албаны мэдээлэл алдагдах, олон сувгаар дамжиж олон нийтэд түгээгдэх;
- Иргэд мэдээ, мэдээлэлд цензургүй хандаж, албаны эх сурвалжаас баталгаажаагүй, олон хүний анхаарлын төвд орсон сенсац бүхий мэдээг хурдтай түгээж байгаа нь хүний эрхийн зөрчил үүсэх, цагдаагийн байгууллагыг үгүйсгэх, үйл ажиллагааг нь үл ойшоон цагдаагийн байгууллага, алба хаагч, иргэд хоорондын харилцааг хурцатгах, албан үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх.

## **1.2. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЭЛТСИЙН ТАНИЛЦУУЛГА**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/24 дүгээр тушаалаар Урьдчилан сэргийлэх хэлтсийн орон тоог дарга 1, чиглэлийн ахлах мэргэжилтэн 2, ахлах мэргэжилтэн 8, Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн дарга 1, ахлах мэргэжилтэн 3, нийт 14 алба хаагчийн орон тоотойгоор баталсан байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 152 дугаар тогтоолоор цагдаагийн байгууллагын бүтцэд хүүхдийн байцаагчийн 103 орон тоо нэмэгдүүлсэнтэй холбогдуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/316 дугаар “Нэршил өөрчилж, орон тоо нэмэх, шилжүүлэх тухай” тушаалаар Урьдчилан сэргийлэх хэлтсийн бүтцэд өөрчлөлт оруулж тус хэлтсийн Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн дарга 1, ахлах мэргэжилтэн 2, мэргэжилтэн 1, 4 алба хаагчийн орон тоог Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хэлтэст шилжүүлжээ.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2021 оны Б/190 дүгээр тушаалаар Урьдчилан сэргийлэх хэлтсийн орон тоог хэлтсийн дарга 1, тасгийн дарга 1, чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, ахлах мэргэжилтэн 10, мэргэжилтэн 1 нийт 14 орон тоотойгоор баталсан ба одоогийн байдлаар сул орон тоо 1 байна.

Тус хэлтэс нь гэмт хэрэг, зөрчлийн бүртгэл судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх бодлого боловсруулах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.



Монгол Улсын Их Хурлаас баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 7.3.2-т "Иргэдийг гэмт хэрэгт өртөх, хохирохоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, түүнтэй тэмцэх тогтолцоонд инновацад суурилсан техник, технологийн дэвшлийг нэвтрүүлж, нөлөөллийн арга хэмжээг цогцоор хэрэгжүүлж, урьдчилан сэргийлэх чадавхыг дээшлүүлж, гэмт хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлнэ", Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 5.1.7-д "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг тэргүүлэх чиглэл болгох", Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.7-д "Гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно" гэж тодорхойлсон байна.

Тус хэлтсээс 2021-2023 онд дараах үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүнд;

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд эх дэлхий, байгаль орчноо хайрлан хамгаалж, зохицон амьдрах, дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор "Байгалиа бүтээе" нөлөөллийн аяныг 2022 оны 05, 10 дугаар саруудад Ерөнхийлөгчийн тамгын газартай хамтран зохион байгуулж, улсын хэмжээнд 11.0 сая мод тарьсан;

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар архи согтууруулах ундааны зохисгүй хэрэглээнээс үүдэлтэй хүн амын эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилго бүхий "Эрүүл монгол хүн" үндэсний хөдөлгөөнийг сурталчлах, идэвхжүүлэх, иргэдийг соён гэгээрүүлэх ажлын хүрээнд "Намайг Алгас" нөлөөллийн аяныг 2022 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд зохион байгуулснаар гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй нийт дуудлага, мэдээлэл өмнөх сарын мөн үетэй харьцуулахад 1044, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ гэмт хэрэг, зөрчил гаргасан дуудлага, мэдээлэл 337 нэгжээр тус тус буурсан;

-Зам тээврийн осол, хэргийн улмаас иргэдийн амь нас, эд хөрөнгө хохирохоос урьдчилан сэргийлэх, хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал, хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах зорилгоор зохион байгуулсан "Аажуу явбал аяндаа хүрнэ дээ" нөлөөллийн арга хэмжээний үр дүнд зам тээврийн осол өмнөх оноос 8.1, ослын улмаас нас барсан хүний тоо өмнөх оноос 5.7 хувиар тус тус буурсан эерэг үзүүлэлт гарсан;

-Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдыг гэмт хэрэг, сахилга ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаа, албаны нэр хүндийг өндөрт өргөх, иргэд олон нийтэд эергээр сурталчлах чиглэлээр мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг энэ оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс 03 дугаар сарын 14-ний өдрийн хооронд зохион байгуулж, видео контент 37, зурагт хуудас 7, нийт 44 мэдээллийг цахим орчинд түгээсэн нь давхардсан тоогоор 149.682 хүнд таалагдаж, 10.187 хүн сэтгэгдэл үлдээж, 407.834 хүн бусадтай хуваалцаж, 7.252.425 хүнд хүрсэн ба 10.187 санал, сэтгэгдлийн 86.1 хувь нь дэмжсэн, 7.0 хувь нь шүүмжилсэн, 7.9 хувь бусад сэтгэгдэл үлдээсэн үр дүнг үзүүлсэн;

-Иргэдийн ая тухтай амьдрах орчныг бүрдүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй хотыг бий болгох зорилтын хүрээнд "Ногоон бүс" төслийг боловсруулан 2022 онд Чингэлтэй дүүргийн 1, 2, 3 дугаар хорооны нутаг дэвсгэр нийт 51.7 га талбайг хамарсан телекамерын бүрэн хяналттай хороо болгох зорилт дэвшүүлэн нийт 178 цэгт 341 чиглэлийн телекамер байршуулсан. Энэ ажлын үр дүнд дээрх хороодын гэмт хэрэг, зөрчлийн дуудлага мэдээлэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад

48.6 хувиар буурсан эерэг үзүүлэлт гарсан ба цаашид уг төслийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах, хэрэгжилт үр дүнг тооцохоор аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар, Иргэдийн төлөөлөгчдийн хуралд мэдээлэл хүргүүлж, 13.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлсэн;

-Хууль зүй, дотоод хэргийн яамны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран “Байгалиа хамгаалъя-Хүн бүр байгаль хамгаалагч” ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгааны аяныг 2023 оны 04, 05 дугаар саруудад зохион байгуулж, ажилласны дүнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр бүлэгт заасан гэмт хэрэг улсын хэмжээнд энэ оны эхний 04 сарын байдлаар 161 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 77 нэгжээр буюу 32.4 хувиар буурсан эерэг үзүүлэлттэй байна;

-“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2023” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зам тээврийн осол, хэргийн улмаас иргэдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө хохирохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх, замын хөдөлгөөнд оролцогчдын буруу дадал, хандлагыг өөрчлөх, зөв үйлдэлд уриалах чиглэлээр “Нэг зам-Нэг соёл” нөлөөллийн аяныг энэ оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс нэг сарын хугацаанд улсын хэмжээнд зохион байгуулж ажилласны үр дүнд бүртгэгдсэн зам тээврийн осол 46.4, хүний амь нас барсан 3.1, хүүхэд нас барсан 44.4, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 26.6, эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 8.9 хувиар тус тус буурсан.

Дотоод аудитаар тус хэлтсийн үйл ажиллагаанд дараах эрсдэлүүд учирч болзошгүй байгааг анхааруулж байна. Үүнд;

- Цагдаагийн байгууллагаас хэрэгжүүлж байгаа урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт тодорхой бус байгаагаас алба хаагчийн ур чадварт суурилсан ажлын гүйцэтгэл хангагдахгүй байх, удирдах албан тушаалтнууд, алба хаагчдын дунд үүрэг гүйцэтгэлтэй холбоотой үл ойлголцол үүсэх;
- Цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, албаны болон алба хаагчдын нэр хүнд, эрх ашгийг хамгаалах ажлыг уялдуулан зохион байгуулах бодлого, төлөвлөлт, бие даасан нэгж байхгүй байгаагаас олон нийтийн сүлжээнд тавигдсан цагдаагийн алба, алба хаагчидтай холбоотой мэдээллийн мөрөөр хариу арга хэмжээг шуурхай авах, нийтлэгдэхээс нь өмнө таслан зогсоох үйл ажиллагаанд эрсдэл үүсэх.

### **1.3.ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ТАНИЛЦУУЛГА**

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/220 дугаар тушаалаар хэлтсийн бүтэц, орон тоо, цол, цалингийн зэрэглэлийг шинэчлэн баталж, нийт 13 алба хаагчийн орон тоотойгоос хэлтсийн дарга 1, чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, ахлах мэргэжилтэн 3, Алба хаагч, ажилтны эрх ашгийн хамгаалах тасгийн дарга 1, ахлах мэргэжилтэн 7 орон тоотойгоор “Хууль тогтоомжид нийцүүлэн цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ тогтоосон баримт бичгийг боловсронгуй болгох, хууль тогтоомж, эрхийн акт, шийдвэрийн төсөлд санал өгөх, эрх зүйн дүгнэлт гаргах, эрх зүйн актын нэгдсэн сан бүрдүүлэх, түгээх, байгууллага, алба хаагч, ажилтны хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн үед хууль зүйн зөвлөгөө өгөх, цагдаагийн байгууллагыг шүүхэд төлөөлөх ажлыг зохион байгуулах” үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тус хэлтсээс 2021-2023 онд дараах үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна. Үүнд;

-Цагдаагийн ерөнхий газарт холбогдох эрүү, иргэн, захиргааны 131 хэргийн шүүх хуралдаанд хариуцагч, нэхэмжлэгчийн төлөөлөгчөөр 265 удаа оролцож, 81 хэрэг эцэслэн шийдэгдсэнээс 80 хэрэг буюу 98,7 хувь нь байгууллагын талд шийдвэрлэгдсэн;

-Эрүүгийн хэрэгт хууль бусаар шалгагдсаны гэм хорын хохирол нэхэмжилсэн иргэний 52 хэрэгт Засгийн газрыг төлөөлөн 89 удаа оролцоноос 24 хэрэг эцэслэн шийдэгдсэнээс 24 хэрэг буюу 100 хувь Засгийн газрын талд шийдвэрлэгдсэн;

-Монгол Улсын хуулийн төсөлд санал өгөх, боловсруулах чиглэлээр Нэгдсэн Үндэсний байгууллагын конвенц болон түүний нэмэлт протоколуудын хэрэгжилтийн тайлан гаргах 7, холбогдох хууль тогтоомжийн 98 төслийг боловсруулж, хэлэлцүүлэгт бэлтгэх, батлуулах үүрэг бүхий Ажлын хэсэгт цагдаагийн байгууллагыг төлөөлөн ажиллаж, санал, дүгнэлт боловсруулж, Засгийн газрын тогтоолын төсөл, эрх зүйн актын 224 төсөлд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас санал авч, нэгтгэн боловсруулж, саналыг Хууль зүй, дотоод хэргийн яам болон холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлсэн;

-Монгол Улсын Их Хурлаас Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.2 дахь хэсгийг “Цагдаагийн алба хаагчийн ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар, цагдаагийн байгууллагын нууцалбал зохих албанд гүйцэтгэх ажилтнаар ажилласан 1 жилийг 1 жил 4 сараар тус тус тооцно.” гэж өөрчилсөнтэй холбогдуулан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас Нийгмийн даатгалын ерөнхий газартай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг хангах, хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар нэмэлт тодруулга, саналыг 2023 оны 01/118 дугаартай албан бичгээр Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн;

-Монгол Улсын Их Хурлаас Дотоодын цэргийн тухай хуулиар дотоодын цэргийн чиг үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахаар заасан бөгөөд алба хаагчдын үүрэг гүйцэтгэх нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, улсын онц чухал болон бусад объектын хамгаалалттай холбоотой эрх зүйн орчинг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулсан;

-Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж, эрх зүйн акт шинэчлэн баталсан, нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмын код 129, бусад 21 журам, дүрэм, зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх, хүчингүй болгох талаар цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас саналыг авч, нэгтгэн боловсруулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар батлуулан мэдээллийг тухай бүр цагдаа, дотоодын цэргийн байгууллагад хүргүүлсэн.

Тус хэлтсийн Алба хаагч, ажилтны эрх ашгийн хамгаалах тасгаас 2021-2023 онд дараах үр дүнтэй ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллажээ. Үүнд;

-Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг цаг үеийн нөхцөл шаардлагад нийцүүлэх, хуульд заасан баталгаагаар хангах ажлыг эрчимжүүлэх, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нөлөөлж байгаа шалтгаан нөхцөлийг арилгуулах, үйл ажиллагаандаа дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм, журмыг сурталчлан таниулах замаар тэдний аюулгүй байдлыг хангах, мэдлэг,

өөрийгөө хөгжүүлэх чадварыг дээшлүүлэх зорилгоор 2020-2023 онд хэрэгжүүлэх "Цагдаа, дотоодын цэргийн алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хөтөлбөр"-ийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/163 дугаар тушаалаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд биелэлт үр дүнг тооцоход 2021 онд 66.4, 2022 онд 93.3, 2023 оны эхний хагас жилийн байдлаар 86.2 хувьтай байна;

-Дээрх хугацаанд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 630 алба хаагч 583 гэмт хэргийн шинжтэй үйлдэлд өртөж, үүнээс 19 алба хаагч золгүй байдлаар нас барж, 88 алба хаагчийн биед гэмтэл тогтоогдож, 146 тохиолдолд нь байгууллагын эд зүйл, алба хаагчийн дүрэмт хувцас, эд зүйлд хохирол учирсан ба хэргийн шийдвэрлэлт, холбогдох хууль тогтоомж, даатгалын гэрээний дагуу олгогдох тэтгэмж, нөхөн олговрыг олгуулах, буруутай этгээдээр хохирол нөхөн төлүүлэх ажиллагаанд хяналт тавин ажилласнаар 113 алба хаагчид учирсан 89,660,000 төгрөгийн хохирлыг мөрдөн шалгах ажиллагааны явцад нөхөн төлүүлж, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу алба хаагч болон тэдний ар гэрт 453,700,000 төгрөгийн тэтгэмжийг олгуулж, даатгалын байгууллагатай байгуулсан гэнэтийн ослын даатгалын гэрээний дагуу 19 алба хаагчид 29,1 сая төгрөгийн нөхөн төлбөрийг гаргуулсан;

-Албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэрэгт өртөж хохирсон, холбогдсон алба хаагчийн эрхийг хамгаалах чиглэлээр алба хаагч болон тэдний өмгөөлөгч нартай хамтран эрүүгийн хэргийн шүүхэд 2 гомдол, иргэний хэргийн шүүхэд 2 нэхэмжлэл, прокурорын байгууллагад 12 хүсэлт, Авлигатай тэмцэх газарт 3 хүсэлт, Мөрдөн байцаах албаны Тусгай субъектийн үйлдсэн гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст 10 хүсэлт, Хэвлэл мэдээллийн зөвлөлд 2 гомдол тус тус гаргаж шийдвэрлүүлсэн;

-Албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэрэгт холбогдсон алба хаагчдын эрхийг хамгаалах чиглэлээр тус тасагт хандсан 37 алба хаагчийн хүсэлтийг хүлээн авч, холбогдсон хэргийн нөхцөл байдлыг судалж, холбогдох байгууллагад хүсэлт хүргүүлэн шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагааны явцад гэрчийн мэдүүлэг өгч ажилласнаар 29 алба хаагчид холбогдох 20 хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлүүлсэн;

-“Алба хаагчдын чөлөөт индэр” фейсбүүк хязгаарлалттай группээр дамжуулан “Алба хаагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр зохион байгуулж байгаа шинэлэг ажил, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ” сэдвээр нийт 102 удаагийн шууд дамжуулалт /live/ хийж, эрх зүйн мэдээ, мэдээллийн 285 постер, гарын авлага 57-г байршуулж, цахим хуудсаар болон албан бичиг, шуудангаар 165 санал хүсэлтийг хүлээн авч, удирдлагад танилцуулан шийдвэр гаргуулж, холбогдох хууль тогтоомжийн төсөлд тусгуулж ажилласан;

-Цагдаагийн алба хаагчдын нийт ажилласан нэг жилийг 3 сар нэмэгдүүлэн тооцох зохицуулалтыг Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгуулахаар санал боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганаар батлагдсан;

-Дотоодын цэргийн алба хаагчдын аймгийн төвөөс бусад суманд тасралтгүй 5 жил ажилласан тохиолдолд урамшуулал олгодог болох асуудлыг Дотоодын цэргийн тухай хуульд нарийвчлан тусгуулах санал боловсруулан Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганаар батлагдсан.

-Ажлын байрны бэлгийн дарамт үзүүлдэг удирдах ажилтнуудын талаар мэдээллийг хүлээн авч, Дотоод хяналт-аюулгүй байдал хариуцсан нэгжийн алба хаагчидтай хамтран шалгалт явуулж, буруутай 3 албан тушаалтныг ажлаас чөлөөлөх шийдвэрийг цагдаагийн төв байгууллагын удирдлагаар гаргуулсан.

Дотоод аудитаар тус хэлтсийн үйл ажиллагаанд дараах эрсдэлүүд учирч болзошгүй байгааг анхааруулж байна. Үүнд;

- Хуулийн хэлтсийн алба хаагчдыг чадавхжуулах, гүйцэтгэлийг бодитой үнэлэх, алба хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлээгүйгээс ажлын үр дүнд сөргөөр нөлөөлөх, байгууллагын хэвийн үйл ажиллагаанд саад учрах, албаны нэр хүнд унах;
- Цагдаагийн алба хаагч, ажилтны эрх ашгийг хамгаалах чиг үүргийн алба хаагчид цагдаагийн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэрийг шүүхийн болон захиргааны байгууллагад хамгаалах чиг үүрэг бүхий нэгжид харьяалагдаж байгаа нь алба хаагчдын эрх ашгийг хараат бусаар хамгаалах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, алба хаагчдын итгэл үнэмшил алдагдах, хууль ёсны эрх ашгаа хамгаалуулахад саад учрах.

### **Хоёр.Олон улсын туршлагын талаар:**

Олон улсын цагдаагийн дарга нарын холбооны хууль сахиулах бодлогын төв нь цагдаагийн байгууллагын зүгээс хэвлэл мэдээлэлтэй хэрхэн харилцах стандартыг 2019 онд шинэчилэн боловсруулсан.

Уг стандарт нь хэвлэлийн агентлаг, нийгмийн сүлжээгээр дамжуулан цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах, эрэн сурвалжлах зар, сэрэмжлүүлэг түгээх, албаны үйл ажиллагаа, хууль сахиулах ажлын үр дүнг олон нийтэд танилцуулах үед баримтлах зөвлөмжүүдийг багтаасан байдаг.

Хууль сахиулах байгууллага нь хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж эрх тэгш, нээлттэй, шударга, үнэн зөв мэдээллийг түгээдэг ба энэ нь цаашид буруу ташаа мэдээлэл, үндэслэлгүй шүүмжлэл бий болохоос зайлсхийх үндсэн арга нь болдог.

Хэвлэл мэдээллийн байгууллага, олон нийттэй харилцах үйл ажиллагааг зохион байгуулахын тулд олон нийттэй харилцах ажилтан эсхүл хэвлэлийн төлөөлөгч ажиллуулж болно. Хэрэв ийм орон тоо байхгүй бол цагдаагийн байгууллагын дарга нь олон нийтийн өмнө байгууллагыг төлөөлнө.

Хэвлэлийн төлөөлөгч нь харилцааны ур чадварын болон нийгмийн сүлжээнд тавигдсан мэдээлэлд шүүлт дүн шинжилгээ хийх талаар сургалтанд хамрагдсан, цагдаагийн дүрэмт хувцастай болон энгийн алба хаагч байна.

Жишээ нь, Лондон хотын цагдаагийн газрын дэд дарга буюу захиргааны удирдлагын газрын харъяанд орон тоо 23, үүнээс 15 нь цагдаа, 8 нь энгийн ажилтнаас бүрдсэн олон нийттэй харилцах болон хэвлэл мэдээллийн баг ажилладаг. Баг нь цагдаагийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухайд нь, үнэн зөв түгээх, хэвлэлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, худал мэдээллийн эсрэг хариу арга хэмжээг авах үүрэгтэй байдаг.

Оросын Холбооны улсын Дотоод хэргийн яамны Хэвлэлийн төв нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах, байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтийн

бодитой санал бодлыг бий болгох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр суртал ухуулга явуулах чиг үүрэгтэй.

Европын цагдаагийн газрын хэвлэл мэдээлэлтэй харилцах тухай судалгаанд дурьдсанаар нөхцөл байдлын талаар бодит мэдээллийг олон нийтэд хүргэх нь цагдаагийн олон нийттэй харилцах албаны үндсэн үүрэг бөгөөд хүүхэд залуус, төрийн байгууллагууд, нийгмийн цөөнх зэрэг тодорхой зорилтот бүлэг рүү мессеж өгөх хэлбэрээр олон нийттэй харилцах бодлогыг хэрэгжүүлдэг байна.

Цагдаагийн байгууллага нь хэвлэл мэдээлэлтэй харилцах журмыг боловсруулах, олон нийтэд хүргэх мэдээллийн сэдэв агуулгыг тодорхойлох, сэдэв, асуудлын эмзэг байдалд үнэлгээ хийхдээ хэвлэл мэдээллийн байгууллагын туслалцааг авдаг.

Цагдаагийн байгууллага, алба хаагчийн нэр хүнд, үйл ажиллагаатай холбоотой ташаа (Misinformation), худал (Disinformation) мэдээллийг хүлээн авсаны дараа /а/ мэдээллийн эх сурвалж, шалтгаан, үнэн бодит байдлыг шалгах, үнэлгээ хийх, удирдлагад танилцуулах, /б/ хууль, эрх зүйн үр дагавар, цаашид ямар хариу арга хэмжээ авбал эрх зүйн үндэслэлтэй байхыг судлах, дүгнэлт гаргах, /в/ түгээгдсэн мэдээллийн мөрөөр цагдаагийн байгууллагаас гаргах шийдвэрийн хувилбарыг санал болгох гэсэн 3 үе шаттай арга хэмжээ авахыг зөвлөдөг байна. Үүнд;

- Албаны үйл ажиллагаа, алба хаагчийн нэр төрд халдаж, олон нийтийн дунд буруу, ташаа ойлголт үүссэн, тайлбар хийхээс өөр аргагүй байгаа нөхцөлд үнэн зөв байдлыг магадлан шалгаж тухайн байгууллагын удирдлагаас мэдээлэл өгөх;

- Нуугдмал болон эргэлзээтэй мэдээллийг ил тод болгох;

- Тухайн мэдээлэл нь илтэд хов живийн шинжтэй, олон нийтийн анхаарал татсан сэдэв биш бол тайлбар өгөлгүй орхих зэрэг болно.

Уг хариу арга хэмжээний хувилбарууд нь цагдаагийн байгууллагын хуулийн асуудал эрхэлсэн нэгж болон хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албадын хамтын ажиллагааны дүнд хэрэгжинэ.

Америкийн Нэгдсэн улсын Хууль зүйн яамнаас гаргасан Цагдаагийн байгууллагаас олон нийттэй харилцах стратегид дурьдсанаар хууль сахиулагч болон түүний үйл ажиллагаа нь иргэд, хэвлэл мэдээллийн байнгын сэдэв бөгөөд олон нийтийн сүлжээнд байршсан мэдээллүүд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцуулахад үнэн худлыг дэнслэх шүүлтүүргүй байдаг.

Америкийн “PEW research” байгууллагын судалгаагаар шүүх, прокурор, төрийн байгууллагуудаас цагдаагийн байгууллагын мэдээлэлд итгэх иргэдийн итгэлийн түвшин 59 хувь буюу шүүх, прокуророос 2 дахин өндөр байсан.

Мөн Брэндон их сургуулийн судалгаагаар цагдаагийн байгууллага олон нийтийн сүлжээ ашиглан өөрсдийн үйл ажиллагааг сурталчлах, хэвлэлийн мэдээлэлд хариу үйлдэл үзүүлэхдээ тодорхой шалгууртай хандаж “Хэт суртал ухуулга” гэх ойлголтыг төрүүлэхээс зайлсхийж байхыг зөвлөсөн байна.

Дэлхий дахинд сүүлийн жилүүдэд аж үйлдвэрийн IV хувьсгал, мэдээллийн технологийн эрчимтэй хөгжил, цар тахал, нийгэм, эдийн засгийн хямрал, зарим улс оронд өрнөж буй дайн бүхий нөхцөл байдлаас шалтгаалан олон улсад макро болон микро орчны олон хүчин зүйлт сөрөг нөлөөлөл бүхий мэдээллийн урсгал асар хурдтай эрчимжиж, улс орны дотоод аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий цагдаа, дотоодын

цэргийн байгууллагын үйл ажиллагаа төдийгүй төр засаг, олон нийтийн аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг үр дагавар нэмэгдэж байна.

Ийм нөхцөл байдалд цахим орчинд дахь мэдээлэл, олон нийтийн санаа бодлыг байнгын тогтмол мэдэрч ойлгох, хариу арга хэмжээг шуурхай төлөвлөх зайлшгүй шаардлага тулгарч байгаагаас шалтгаалан Америкийн Нэгдсэн улсын арми өөрийн бүтэц дэх хэвлэл мэдээлэл, цахим орчин хариуцсан алба хаагчдыг орон тоог эрчимтэй нэмэгдүүлж, мэдээллийн тэмцэл явуулах, байнгын бэлэн байдлыг хангах чадавхийг бүрдүүлсэн байна.

Дээрх чиг үүрэгтэй алба хаагчдын болон далд эх сурвалжийн тоо эрс нэмэгдсэн болох нь Оросын Холбооны болон Украин улсын цэрэг дайны ажиллагаанд Украйны талыг барьсан мэдээ, мэдээллийг эрчимтэй түгээж байгаагаар нотлогдож байгаа талаар <https://www.usar.army.mil/News/News-Display/Article/1941812/army-reserve-works-to-expand-public-affairs-capabilities/> сайтад мэдээлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хэвлэл, мэдээллийн төвөөс цахим орчинд албан ёсны цахим хуудас, болон фейсбүүк хуудсаар дамжуулан мэдээ мэдээллийг түгээдэг ба 80 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч нартай тогтвортой харилцаа тогтоож, холбогдох үнэн бодит, хууль ёсны мэдээ мэдээллээр ханган ажиллаж байгаа бөгөөд хариу арга хэмжээг дараах арга, тактикаар явуулж байна.

ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ТӨВӨӨС ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБА ХААГЧ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧИЛТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ҮЗҮҮЛЭХ ХАРИУ ҮЙЛДЛИЙН ТАКТИК, АРГА



### Гурав.Дүгнэлт:

Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар 2.6 сая фейсбүүк хэрэглэгч, Харилцаа, холбооны зохицуулах хороонд 303 сайт албан ёсны бүртгэлтэй байгаагаас 154 мэдээллийн сайт идэвхтэй үйл ажиллагаа явуулж, цахим орчинд улс төр, нийгэм эдийн засгийн мэдээллийн талаас илүү хувьд нь ямар нэгэн байдлаар төр засгийн шийдвэрт нөлөөлөх манипуляцын<sup>1</sup> шинжийг агуулсан мэдээллийг түгээж байгаа нь нууц биш

<sup>1</sup> Манипуляци гэдэг нь аливаа нэг үзэл санаа, түүх, нийгэм, улс төр, эдийн засгийн үйл явдал эсвэл тодорхой хүмүүсийн бодит, үнэнч байдлыг бус харин зориуд мушгин гуйвуулсан, гүтгэсэн, хөөргөн магтсан буруу ойлголт, төсөөлөл төрүүлж олон нийтийг далдаас удирдах нийгэм-сэтгэл зүйн арга, технологийг хэлнэ.

бөгөөд үүнээс **сэргийлэх хязгаарлах болон тэмцэх** гэсэн 2 үндсэн арга, аргачлал байдаг.

Цагдаагийн байгууллагын зүгээс энэхүү олон хүчин зүйлт сөрөг нөлөөлөлд ямарваа нэгэн хязгаарлалтын арга хэмжээг идэвхтэй хэрэгжүүлэх нь цензур тогтоосон, хэвлэн нийтлэх эрх, эрх чөлөө, олон нийтийн мэдэх эрхэд халдсан мэт нөхцөл байдал үүсгэж болзошгүй эрсдэлтэй байх тул мэдээллийн далд, халхавчтай эх сурвалжийг ашиглах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Мэдээллийн тэмцэл явуулж буй субъектуудын хувьд хэвлэл мэдээллийн болон цахим орчинд өөрийн ил болон далд эх сурвалжуудаар мэдээ, мэдээлэл түгээж аливаа сөрөг мэдээллийг саармагжуулах, агуулга, зорилгыг нь өөр зүйлд чиглүүлэх, өөрчлөх, эргүүлэх, хөндлөнгийн мэдээлэл түгээх зэргээр мэдээллийн сенсацыг урьтаж удирдахыг хичээж, шаардлагатай тохиолдолд лобби *Төр захиргааны байгууллага, албан тушаалтны үзэл бодол, шийдвэрийг өөрт ашигтайгаар өөрчлөхийг оролдож, нөлөөлөх арга* хийх аргуудыг ашиглаж байгаа бөгөөд бид өөрсдийнх нь эсрэг илүү үр дүнтэй, ирээдүйд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

“Фейсбүүк” олон нийтийн сүлжээнд сэтгэгдэл хэлбэрээр хариу арга хэмжээ /троллинг<sup>2</sup>/ явуулах нь хоцрогдсон бөгөөд 2021 оноос эхлэн “Meta” корпорац “facebook”-д сэтгэгдэл хэсэгт томоохон шинэчлэл хийсэн нь таны бичсэн сэтгэгдэл таны бусад найзын хүрээлэлд шууд харагддаг болсон тул сэтгэгдэл хэлбэрээр хариу арга хэмжээг хэрэгжүүлбэл тухай мэдээллийн хандалт тархалтыг улам нэмэгдүүлдэг болжээ.

Цахим орчинд төрийн тусгай албаны зүгээс троллинг хийх нь маш ёс зүйгүй, мэргэжлийн алдаатай үйлдэл бөгөөд гадаадын тусгай албад дээрх байдлаар троллинг хийхдээ хэзээ ч өөрсдийн хүч нөөц бололцоог ашигладаггүй дандаа хөндлөнгийн байгууллага, бүлэглэлээр дамжуулан хийлгэж байна.

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, цахим орчинд мэдээллийн манипуляцийн аргыг голчлон ашигладаг бөгөөд тухайн аргачлал нь нийгмийн сэтгэл зүйн төлөв байдлыг судалсны үндсэн дээр мэдээллийн зорилтод үйл явдлыг зохион байгуулалттайгаар үүсгэж, хөндлөнгийн эх сурвалжаар олон нийтэд түгээх сонгодог арга барил бөгөөд манипуляцийн үндсэн хэлбэр нь субъект өөрийн санааг нууцалж, объектод тааруулж сонгосон мэдээллийг өгч, далдуур хяналт тавьдаг аргачлал юм.

Цахим орчинд дахь мэдээлэл, олон нийтийн санаа бодлыг байнгын тогтмол мэдэрч ойлгох, хариу арга хэмжээг шуурхай төлөвлөх зайлшгүй шаардлага тулгарч байгаагаас шалтгаалан олон улсын жишигт нийцүүлэн цагдаагийн байгууллагын бүтэц дэх хэвлэл мэдээлэл, цахим орчин хариуцсан алба хаагчдыг орон тоог нэмэгдүүлж, мэдээллийн тэмцэл явуулах, байнгын бэлэн байдлыг хангах чадавхийг бүрдүүлсэн байх шаардлагатай байна.

Дотоод аудитын явцад цугларсан мэдээлэл, баримт бичиг, олон улсын туршлагад үндэслэн дараах сайжруулалтыг хийх шаардлагатай гэж дүгнэж байна. Үүнд:

Нэг.Цахим орчинд дахь мэдээлэл, олон нийтийн санаа бодлыг байнгын тогтмол мэдэрч ойлгох, хариу арга хэмжээг шуурхай төлөвлөж, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох

<sup>2</sup> Троллинг нь цахим сүлжээний харилцааны соёлын хэм хэмжээг зөрчиж бусдын харилцаа, танин мэдэхүй, мэдлэгийн солилцоо, иргэдийн амар тайван байдлыг алдагдуулах, ярианы сэдвээс хазайж уншигчдын сэтгэл хөдлөлийг ашиглан талцуулж, маргаан үүсгэж буй үйлдлийг хэлнэ.



ажлыг шуурхай зохион байгуулах зорилгоор Хэвлэл мэдээллийн төв, Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хуулийн хэлтсийн Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тасгийг нэгтгэн “Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах газар” болгох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.

Хоёр. Хэвлэл мэдээллийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн Цахим мэдээлэл, мониторингийн тасаг 1, Мэдээлэл бэлтгэх, хэвлэх тасгийг тус тус байгуулж, цахим мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн 1, цахим мэдээллийн хариуцсан мэргэжилтэн 3, хэвлэлийн төлөөлөгч 2, зураглаач 1, сэтгүүлч-1 нийт 8 орон тоог шинээр нэмэгдүүлэх, орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн техник, хэрэгслээр хангах асуудлыг шийдвэрлүүлэх.

Гурав. Цагдаагийн алба хаагч, ажилтны эрх ашгийг хамгаалах чиг үүргийн алба хаагчид цагдаагийн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэрийг шүүхийн болон захиргааны байгууллагад хамгаалах чиг үүрэг бүхий нэгжид харьяалагдаж байгаа нь алба хаагчдын эрх ашгийг хараат бусаар хамгаалах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, алба хаагчдын итгэл үнэмшил алдагдах, хууль ёсны эрх ашгаа хамгаалуулахад саад учрах эрсдэлийг бууруулах зорилгоор Хуулийн хэлтсийн Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тасгийг “хэлтэс” болгон “Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах газар”-ын харьяанд шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх.

Дөрөв. Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж байгаа урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах, алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааны үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, мөрдөж ажиллах шаардлагатай гэж дүгнэж байна.

#### **Дөрөв.Санал, зөвлөмж:**

1.Цахим орчинд дахь мэдээлэл, олон нийтийн санаа бодлыг байнгын тогтмол мэдэрч ойлгох, хариу арга хэмжээг шуурхай төлөвлөж, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох ажлыг шуурхай зохион байгуулах зорилгоор Хэвлэл мэдээллийн төв, Урьдчилан сэргийлэх хэлтэс, Хуулийн хэлтсийн Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тасгийг нэгтгэн “Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах газар” болгох асуудлыг судалж, шийдвэрлүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах /ХНХ, ХМТ, УСХ, ХХ/;

2.Хэвлэл мэдээллийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн Цахим мэдээлэл, мониторингийн тасаг 1, Мэдээлэл бэлтгэх, хэвлэх тасгийг тус тус байгуулж, цахим мэдээлэл хариуцсан ахлах мэргэжилтэн 1, цахим мэдээллийн хариуцсан мэргэжилтэн 3, хэвлэлийн төлөөлөгч 2, зураглаач 1, сэтгүүлч-1 нийт 8 орон тоог шинээр нэмэгдүүлэх, орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн техник, хэрэгслээр хангах асуудлыг шийдвэрлүүлэх /СААА, ХНХ, ХМТ/;

3.Баталгаажсан судалгаа, мэдээлэл, дүн шинжилгээ, технологийн дэвшил буюу инновацад суурилсан оновчтой арга, тактикаар аливаа хууль бус үйлдэл гарсны дараа биш гарахаас өмнө урьдчилан сэргийлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор Урьдчилан сэргийлэх хэлтсийг “Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах газар”-ын харьяанд шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ХНХ, УСХ/;

4.Цагдаагийн алба хаагч, ажилтны эрх ашгийг хамгаалах чиг үүргийн алба хаагчид цагдаагийн байгууллагын удирдлагаас гаргасан шийдвэрийг шүүхийн болон захиргааны байгууллагад хамгаалах чиг үүрэг бүхий нэгжид харьяалагдаж байгаа нь алба хаагчдын

эрх ашгийг хараат бусаар хамгаалах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, алба хаагчдын итгэл үнэмшил алдагдах, хууль ёсны эрх ашгаа хамгаалуулахад саад учрах эрсдэлийг бууруулах зорилгоор Хуулийн хэлтсийн Алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тасгийг “хэлтэс” болгон “Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах газар”-ын харьяанд шилжүүлэх асуудлыг судалж, шийдвэрлүүлэх /ХНХ, ХХ/;

5.Цагдаагийн байгууллагаас зохион байгуулж байгаа урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах, алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагааны үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, мөрдөж ажиллах /ХНХ, ТЗБХ, ХМТ, УСХ, ХХ/;

6.Зөвлөмжийн биелэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 11-ний дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэхийг Хүний нөөцийн хэлтэст даалгах саналтай байгааг Танд илтгэн танилцуулья.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.БОЛД ТАНАА

**ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН**

2023 оны 08 дугаар  
сарын 24-ний өдөр

Улаанбаатар  
хот

Аудитын нэр: Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2023 оны эхний хагас жилийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дотоод аудит.

Аудит хийгдсэн нэгж: Байршуулсан мэдээллийн хугацаа хоцролтын байдлаар цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагын 55 нэгж, мэдээллийн чанарын байдлаар Дотоодын цэргийн 805 дугаар анги, Чингэлтэй, Баянзүрх, Багануур дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүд, Архангай, Говь-Алтай, Ховд, Орхон аймгуудын цагдаагийн газрууд.

Аудитын объект: Цагдаа, дотоодын цэргийн анги байгууллагуудын шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийн чанар, хуулийн хэрэгжилтийг 2023 оны эхний хагас жилийн байдлаар хамруулав.

Аудитын төрөл, код: Нийцлийн аудит, ЦЕГ-ДХАБГ/НА-2023/12

Аудитын хугацаа: 2023.08.01-2023.08.24

Аудитын багийн ахлагч: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Манлайбаатар, ахлах байцаагч, цагдаагийн хурандаа Б.Намгинжав.

Аудитын багийн гишүүн: Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит /санхүүгийн/ хариуцсан ахлах байцаагч, цагдаагийн хошууч Э.Анхчимэг, Б.Наранбаяр.

**1. ТАНИЛЦУУЛГА**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын төсөв санхүү, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах үйл ажиллагаа нь "Шилэн дансны тухай" хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам", Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны "Мэдээллийн ил тод байдлыг хангах, сурталчлах /Код 135/" журам болон бусад холбогдох эрх зүйн акт зэрэг баримт бичгээр зохицуулагдаж байна.

Аудитын баг нь Цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын мэдээллийн хугацаандаа, бүрэн байршуулсан байдал, мөн түүвэрлэн авсан 8 нэгжийн 2023 оны эхний хагас жилд шилэн дансны нэгдсэн системд оруулсан мэдээллийн чанар, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд дотоод аудит хийж гүйцэтгэлээ.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл /2023 оны эхний хагас жилийн байдлаар/

## Хүснэгт 1

№	Мэдээллийн төрөл	Нийт мэдээлэх	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцорсон	Хэрэгжилт
1	Сар бүр мэдээлэх	1,705	1,678	27	98.4
2	Бүтэн жилээр мэдээлэх	165	164	1	99.4
3	Тухай бүр мэдээлэх	2,255	2,233	22	99.0
<b>Дүн</b>		<b>4,125</b>	<b>4,075</b>	<b>50</b>	<b>98.8</b>

**Бусад хяналт, шалгалтын байгууллагаар илэрсэн зөрчил, дутагдал:**

Үндэсний аудитын газар болон орон нутгийн аудитын газарт Цагдаа, дотоодын цэргийн 55 байгууллага /нууцын зэрэглэлтэй 1 байгууллага/ 2022 оны санхүүгийн тайланг гаргаж хүргүүлж, түүвэрт хамрагдан 18, нийт 36 байгууллагын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудит хийгдэж, “Өөрчлөлтгүй” санал дүгнэлттэй шалгагдсан байна.

Санхүүгийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 17 асуудлаар 2.636.965,2 мянган төгрөгийн зөрчил заагдсан. /Хүснэгт 1. мян. төг/

## Хүснэгт 2

Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Нийт зөрчил		Эзлэх хувь
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
-	-	2	94.163.3	15	2.542.801,9	17	2.636.965,2	12.7

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар:**

Төсөв өмч хөрөнгөтэй холбоотой /гэрээ/ шийдвэр, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын гэрээг бүрэн байршуулаагүй, хугацаа хоцроосон, жилийн эцэст бөөн дүнгээр мэдээлсэн зэрэг Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөнөөс албан шаардлага, зөвлөмж авсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтээр зөрчил заагдаж, нийт 2.636.965,2 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 15 зөвлөмж зөрчлийг Эрүүгийн цагдаагийн алба, Тээврийн цагдаагийн алба, Сүлд чуулга, Тээврийн цагдаагийн албаны Төмөр замын цагдаагийн газар, Дотоодын цэргийн 05, 805 дугаар анги, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн цагдаагийн газар, Баян-Өлгий, Дархан-Уул, Хөвсгөл, Өмнөговь, Сүхбаатар аймгийн цагдаагийн газар, Багануур дүүргийн цагдаагийн хэлтэс, Говьсүмбэр аймаг дахь цагдаагийн хэлтэс зэрэг 17 нэгж авсан байна.

## **2.АУДИТЫН ЗОРИЛГО БА ЦАР ХҮРЭЭ**

### **Нэг. Аудитын зорилго**

“Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны дотоод аудитын төлөвлөгөө”-ний 2.4 дэх хэсэгт заасны дагуу цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2023 оны эхний хагас жилийн байдлаарх Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд аудит хийж, цагдаагийн байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах, илэрсэн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр санал, зөвлөмж боловсруулан, хүргүүлж, төсөв, санхүүгийн ил тод, нээлттэй байдлыг сайжруулахад дотоод аудитын зорилго оршино.

### **Хоёр. Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт**

Цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагаас 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн хугацаа хэтрэлт, түүвэрлэн авсан 8 анги байгууллагын мэдээллийн чанар, бүтцийн байдлыг аудитад хамруулсан.

### **Гурав. Аудитын зохион байгуулалт**

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийн тавигдсан хугацаа, агуулга, үнэн зөв, ойлгомжтой, иж бүрэн байдлыг тулган баталгаажуулсан болно.

Тухайн байгууллагын тайлант хугацаанд Сангийн яамны төрийн сангийн дансаар хийгдсэн гүйлгээний мэдээллийг хуулгаар авч, Шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээлэлтэй тулгалаа.

Тулгалт хийсэн мэдээллийг боловсруулахдаа бодитой, хүртээмжтэй байдлыг харгалзан шилэн дансны цахим хуудсанд хэрэглэгчээр нэвтэрч мэдээллийг авсан болно.

## **3.АУДИТААР ИЛЭРСЭН АСУУДАЛ**

**Нэг.** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үнэлэхдээ цагдаа, дотоодын цэргийн 55 анги, байгууллагын 2023 оны эхний хагас жилд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулсан мэдээллийг нэгтгэн үзэхэд, нийт 15 төрлийн 4,125

мэдээлэл байршуулахаас 4,075 мэдээллийг хугацаанд нь, 50 мэдээ хугацаа хоцорч байршуулжээ. /Хавсралт- 1/

Санхүү, аж ахуй алба 2, Гэрээт хамгаалалт 6, Автобааз 6, Сүлд чуулга 1, Дотоодын цэргийн 05 дугаар анги 1, Дотоонын цэргийн 810 дугаар анги 13, Экологийн цагдаагийн алба, Архангай, Дорнод аймгийн цагдаагийн газрууд 1, Баянхонгор аймгийн цагдаагийн газар, Хархорин сумын цагдаагийн хэлтэс 5, Замын-Үүд сумын цагдаагийн хэлтэс, Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн цагдаагийн газрууд 2 мэдээллийг тус тус хоцорч байршуулсан.

**Хоёр.** Аудитын хүрээнд шилэн дансны цахим хуудасны 3 дэд цэсэнд түүвэрлэн авсан 8 нэгжийн байршуулсан мэдээллийг тулгаж үзэхэд дараах асуудал илэрлээ.

Мэдээлэл оруулахдаа хавсралтад заасан маягтын үзүүлэлтийг дутуу нөхөх, байршуулбал зохих мэдээллийг бүрэн байршуулахгүй байх, "PDF формат"-аар байршуулаагүй, мэдээлэл нь цаг хугацаандаа баталгаажуулснаар харагдаж байгаа боловч тухайн мэдээлэл нь хоосон, хамааралгүй мэдээлэл байршуулах, "Шилэн дансны тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан "Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй зэрэг алдаа байна. Үүнд:

- **Дотоодын цэргийн 805 дугаар анги** тайлант хугацаанд гүйлгээ хийсэн /төрийн байгууллагаас бусад/ 49 байгууллага, иргэнтэй "Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан **ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл**" оруулаагүй, "Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал", "хөтөлбөр зориулалт" хэсэгт мэдээлэл оруулахдаа баталгаажуулсан сарын мэдээг бүрэн хавсаргаагүй, харилцагч байгууллага, иргэнтэй байгуулсан гэрээг байршуулаагүй, "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ" хэсэгт 2 сард 10,192,000 гүйлгээг байршуулаагүй, "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт 2 сард 10,192,000 гүйлгээг байршуулаагүй;

- **Чингэлтэй дүүргийн цагдаагийн газар** тайлант хугацаанд гүйлгээ хийсэн /төрийн байгууллагаас бусад/ 52 байгууллага, иргэнтэй "Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан **ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл**" оруулаагүй, ахлах нягтлан бодогч 3 сард 1 маягт оруулсан боловч ямар байгууллагатай мэдэгдэл гаргасан эсэх нь тодорхойгүй, цахим хуудсанд оруулсан баримтын тэргүүг доош нь харуулсж байршуулсан, эмх цэгцгүй, хавсралт нь баримтын шаардлага хангахгүй байна. "Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал", "хөтөлбөр зориулалт" хэсэгт мэдээлэл оруулахдаа

баталгаажуулсан сарын мэдээг бүрэн хавсаргаагүй, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ” хэсэгт 2 сард 25,381,185 төгрөгийн гүйлгээг байршуулаагүй, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт 5 сард Метал фасад ХХК, МТ Чингэлтэй ХХК-ны гүйлгээнүүдийн дүнг зөрүүтэй мэдээлсэн, 7,251,116 төгрөгийн гүйлгээг байршуулаагүй;

- **Баянзүрх дүүргийн цагдаагийн газар** тайлант хугацаанд гүйлгээ хийсэн /төрийн байгууллагаас бусад/ 46 байгууллага, иргэнтэй “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан **ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл**” оруулаагүй, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал”, “хөтөлбөр зориулалт” хэсэгт мэдээлэл оруулахдаа баталгаажуулсан сарын мэдээг бүрэн хавсаргаагүй, тайлант хугацаанд 2 мэдээлэл хоцроосон, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт 1 сард байршуулсан 3 мэдээллийн огноог 1899-12-31 гэж оруулсан, 6 сард 28,860,100 төгрөгийн гүйлгээ байршуулаагүй;

- **Багануур дүүргийн цагдаагийн газар** тайлант хугацаанд гүйлгээ хийсэн /төрийн байгууллагаас бусад/ 43 байгууллага, иргэнтэй “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан **ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл**” оруулаагүй, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал”, “хөтөлбөр зориулалт” хэсэгт мэдээлэл оруулахдаа баталгаажуулсан сарын мэдээг бүрэн хавсаргаагүй, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт 2, 3 саруудад 10,000,000 төгрөгийн гүйлгээг зөрүүтэй мэдээлсэн;

- **Архангай аймгийн цагдаагийн газар** тайлант хугацаанд гүйлгээ хийсэн /төрийн байгууллагаас бусад/ 36 байгууллага, иргэнтэй “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан **ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл**” оруулаагүй, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал”, “хөтөлбөр зориулалт” хэсэгт мэдээлэл оруулахдаа баталгаажуулсан сарын мэдээг хавсаргаагүй, 1 мэдээлэл хоцроосон, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ” хэсэгт 3 дугаар сарын санхүүжилтийг 274.0 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн, 23,528,178 төгрөгийн нэр данс зөрүү орлого, зарлагыг мэдээлээгүй, 4 дүгээр сард санхүүжилтийг 11,879,100 төгрөгөөр илүү, 6 дугаар сард 14.0 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт нэр данс зөрүү зарлага 23,528,178 төгрөг, 5 дугаар сард шатахууны үнэ 13,389,700 төгрөгийг мэдээлээгүй;

- **Говь-Алтай аймгийн цагдаагийн газар** тайлант хугацаанд гүйлгээ хийсэн /төрийн байгууллагаас бусад/ 38 байгууллага, иргэнтэй “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан **ашиг сонирхлын зөрчилгүйг**

**илэрхийлсэн мэдэгдэл” оруулаагүй**, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал”, “хөтөлбөр зориулалт” хэсэгт мэдээлэл оруулахдаа баталгаажуулсан сарын мэдээг хавсаргаагүй, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ” хэсэгт 1 сарын санхүүжилтийг 348,329,938 төгрөгөөр дутуу мэдээлсэн, 2 сард 440,416,612 төгрөгийн 5 гүйлгээг огт мэдээлээгүй, 3 сард 411,848,800 төгрөгийн 5 гүйлгээг дутуу мэдээлсэн, 4 сард 359,386,100 төгрөгийн 2 гүйлгээ, 5 сард 379,137,200 төгрөгийн 2 гүйлгээ, 6 сард 356,019,600 төгрөгийн 2 гүйлгээг тус тус байршуулаагүй, 6,617,437 төгрөгийн гүйлгээг давхар мэдээлсэн, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт 2 сард 40,688,738 төгрөгийн, 4 сард 8,000,000 төгрөгийн гүйлгээг байршуулаагүй, 6 сард 5,000,000 гүйлгээг давхар байршуулсан;

- **Ховд аймгийн цагдаагийн газар** тайлант хугацаанд гүйлгээ хийсэн /төрийн байгууллагаас бусад/ 48 байгууллага, иргэнээс 10 байгууллагатай “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан **ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл**”-г ахлах нягтлан бодогч мэдээлсэн, бусад 38 байгууллагат, төсөв захирагч 48 байгууллага, иргэнд мэдэгдэл гаргаагүй, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал”, “хөтөлбөр зориулалт” хэсэгт мэдээлэл оруулахдаа баталгаажуулсан сарын мэдээг хавсаргаагүй, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ” хэсэгт 1 сард 8,060,450 төгрөг, 4 сард 11,270,000 төгрөгийн гүйлгээнүүдий мэдээлээгүй, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт 1 сард 4 гүйлгээ мэдээлсэн боловч мөнгөн дүнг оруулаагүй, 4 сард 6,825,000 гүйлгээ мэдээлээгүй;

- **Орхон аймгийн цагдаагийн газар** тайлант хугацаанд гүйлгээ хийсэн /төрийн байгууллагаас бусад/ 41 байгууллага, иргэнтэй “Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан **ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн мэдэгдэл**” оруулаагүй, “Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангилал”, “хөтөлбөр зориулалт” хэсэгт мэдээлэл оруулахдаа баталгаажуулсан сарын мэдээг хавсаргаагүй, “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт 6 сард 18,000,000 гүйлгээг давхар байршуулсан зэрэг зөрчил тус тус илэрч байна.

#### 4. ДҮГНЭЛТ

**Нэг.** Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хувьд Шилэн дансны тухай хуулийн дагуу холбогдох мэдээллүүд олон нийтэд 100 хувь мэдээлэгдсэн нь төсвийн ил тод байдал хангагдаж, иргэдээс төсвийн хэрэгжилтэд хяналт тавих нөхцөлийг бий болгосон тул уг хуулийн үндсэн зорилтын хэрэгжилт **“ХАНГАЛТТАЙ”** түвшинд байна. Харин шилэн дансанд мэдээлэл байршуулсан хугацааны хэрэгжилтийн дүнг нэгтгэж үзвэл дундаж үзүүлэлтээр **98.8** хувьтай байна гэж дүгнэв.



**Хоёр.** Байршуулсан мэдээллийг тулган үзэхэд, хуулийн хугацаанд мэдээллээ бүрэн байршуулсан 40, хугацаа хоцорч мэдээлэл байршуулсан 15 байгууллага байна.

**Гурав.** Харин 2022 оны эхний хагас жилийн байдлаар хугацаа хоцорч 70 мэдээлэл байршуулсан нь зөрчил, дутагдал **28.6 хувиар буурсан** сайн үр дүн харагдах боловч шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа батлагдсан хавсралт маягтын дагуу бүрэн нөхдөггүй, байршуулсан мэдээллээ сайтар нягтлаагүйгээс байршуулсан мэдээлэл нь хоосон эсвэл буруу байх тохиолдол их гарч байна.

**Дөрөв.** Хэд хэдэн данс бүхий цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын хувьд санхүүгийн программаас мэдээллийг нэгтгэн татах болон данс бүрээр хавсралт маягт нэмэх боломжгүйгээс шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг гараар шивдэг нь мэдээлэл байршуулах үүрэг бүхий алба хаагчдын ажлын ачааллыг нэмэгдүүлж байна.

**Тав.** Цаашид цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагууд нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоол, Сангийн яамнаас сүлжээгээр хүргүүлж байгаа зөвлөмж, заавар болон Цагдаагийн байгууллагын удирдлагаас Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиглэлээр хүргүүлсэн зөвлөмж, үүрэг, ажлын чиглэлийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

## 5. ЗӨВЛӨМЖ

**Нэг.** Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулахдаа батлагдсан стандарт маягтаар бүрэн мэдээлэх, нөхөн байршуулдаг мэдээллийг шинэчилж байх, "PDF формат"-аар байршуулсан мэдээллийн чанар, агуулгыг анхаарч, мэдээллийг нэвтрэх, хэвлэх, татаж авах боломжтойгоор байршуулах;

**Хоёр.** "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ" хэсэгт байгууллагын санхүүжилтийн орлого, зарлагыг сар бүр тогтмол мэдээлэх;

**Гурав.** "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан "мэдэгдэл" хэсэгт захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө холбогдох албан тушаалтан нь гүйлгээ бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг байршуулах;

**Дөрөв.** "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"-ийн хэсэгт тухайн ажил, гүйлгээний мөнгөн дүнг харгалзахгүйгээр мөнгө, хөрөнгө зарцуулсан болон

өглөг, авлагатай холбоотой шийдвэрүүдийг бүрэн мэдээлж, шийдвэрийг “PDF формат”-аар хавсаргах;

**Тав.** “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ” хэсэгт зарим байгууллагууд цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын гүйлгээг шивж оруулж байгаа нь зарлагын мөнгөн гүйлгээний тоо, дүнг өндөр дүнгээр нэмэгдүүлж байгаа тул нийт нэгжүүд тухай мэдээллийг мэдээлэх эсэх талаар Үндэсний аудитын газраас чиглэл авч, нэгжүүдэд нэгдсэн зөвлөмж хүргүүлэн, хэрэгжүүлэх, өмнөх гүйлгээнүүдийн залруулгыг хийх

**Тав.** Арван сая төгрөгөөс дээш үнийн дүнгээр санхүүжих, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа байгууллага нь энэ талаарх холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулж байх;

## 6. САНАЛ

Аудитын явцад цугларсан баримт, мэдээлэл, аудитын үр дүнд илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах чиглэлээр аудитын багаас дараах зөвлөмжийг холбогдох нэгжид хүргүүлэх саналтай. Үүнд:

**Нэг.** Дотоод аудитаар зөрчил гаргасан болон бусад нэгжүүдийн төсөв захирагч, ахлах нягтлан бодогч, Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлэл байршуулах үүрэг бүхий алба хаагчдад хугацаатай үүрэг, ажлын чиглэл хүргүүлэн, зөрчлийг засуулах, зөрчил давтан гаргасан буюу засаагүй нэгжүүдэд хариуцлага тооцож, дүнг ирүүлэх /CAAA/;

**Хоёр.** Тус газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Зөвлөмж хүргүүлэх тухай” 6/3646 дугаартай албан бичгээр хүргүүлсэн 8 заалт бүхий зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлэх талаар үүрэг, чиглэлийг нэгжүүдэд хүргэж, дүнг тооцож ирүүлэх /CAAA, НЦУГ/;

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ДОТООД ХЯНАЛТ-ШАЛГАЛТ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАЗАР

ТАНИЛЦУУЛГА

Усны гутлын зарцуулалтын дүнгийн тухай

2023 оны 08 дугаар  
сарын 09-ний өдөр

№1/128

Улаанбаатар  
хот

Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагчаас өгсөн үүргийн дагуу Дотоод хяналт-аюулгүй байдлын газрын дотоод аудит хариуцсан чиглэлийн ахлах байцаагч, цагдаагийн хурандаа М.Азжаргал, ахлах байцаагч, цагдаагийн хошууч Ё.Мөнхзул нар 2023 оны 7, 8 дугаар сард цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хэмжээнд албаны хэрэгцээнд усны гутал орлогод авсан болон зарцуулсан байдлыг хянан үзэхэд дараах нөхцөл байдлууд тогтоогдож байна. Үүнд:

**Нэг. Усны гутал авсан эх үүсвэрийн /орлогын/ талаар:**

Улаанбаатар хотод болсон үер усны гамшгийн үед үүрэг гүйцэтгэж ажилласан цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын алба хаагчдад нөөцөд бүртгэлтэй 350, төсвийн санхүүжилтээр худалдан авсан 150, хандив, тусламжаар өгсөн 2745, нийт 3245 ширхэг усны гутал тарааж олгохоор нөөц бүрдүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуй албаны төрийн сан дахь 100900012038 тоот данснаас урсгал төсвийн санхүүжилтээр "Ихэр түнхэл" ХХК-иас 33.000 төгрөгийн нэгж үнэтэй 150 хос усны гутлыг 4.950.000 /дөрвөн сая есөн зуун тавин мянга/, 150 хос ажлын бээлийг 247.500 /хоёр зуун дөчин долоон мянга таван зуун/, нийт 5.197.500 төгрөгөөр худалдан авчээ.

Санхүү, аж ахуй албаны даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 14/1426 дугаартай албан бичгээр өгсөн хүсэлтийн дагуу "Зоонозын өвчин судлалын үндэсний төв"-өөс 450, Гаалийн ерөнхий газраас 245, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2000, лам нараас 50, нийт 2745 ширхэг усны гутлыг хандив, тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан боловч Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Гаалийн ерөнхий газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас зарлагын баримтаа цаг тухайд нь гаргаж өгөөгүйгээс шалтгаалан орлогод авч, санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлэхэд хүндрэл учирч байна.

Байгууллагын нэр	Авсан огноо	Бэлтгэн нийлүүлэгчийн нэр	Нэр төрлийн нэр	Нэгж үнэ	Тоо хэмжээ /хос/	Нийт мөнгөн дүн
ХҮТ-ийн нөөцөд бүртгэлтэй	2019.01.01		Усны гутал		350	
СААА-наас худалдан авсан	2023.07.06	"Ихэр түнхэл" ХХК		33.000	150	4.950.000
Зоонозын өвчин судлалын үндэсний төв	2023.07.06	СААА-ны даргын албан хүсэлтээр			450	
Гаалийн ерөнхий газар	2023.07.10				245	
Лам нараас	2023.07.09				50	
Улаанбаатар хотын	2023.07.06				2000	

Захирагчийн ажлын алба						
Нийт дүн					3245	

Худалдан авалтын үйл ажиллагааг удирдлагаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу Санхүү, аж ахуйн албаны Хангамжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа Г.Баялагмаа, мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч Т.Уранбилэг нар холбогдох судалгааг хийж, хууль, журмын дагуу явуулж, дүнг Санхүү, аж ахуйн албаны даргад танилцуулж, шийдвэрлүүлсэн байна.

Хандив, тусламжаар өгсөн усны гутлыг тус албаны Захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Отгонбаатар, Хангалт, үйлчилгээний төвийн мэргэжилтэн, цагдаагийн дэслэгч О.Гантуяа нар хүлээн авч, Хангалт, үйлчилгээний төв болон Нийслэлийн цагдаагийн удирдах газрын Санхүү, аж ахуйн хэлтсээс холбогдох нэгжүүдэд зохих ёсоор хүлээлгэн өгсөн болох нь санхүүгийн анхан шатны баримтаар тогтоогдож байна.

#### Хоёр. Усны гутлын зарцуулалтын талаар:

Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албаны даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр баталсан "Улаанбаатар цагдаагийн хүрээний анги, байгууллагын алба хаагчдад усны гутал, борооны цув олгох хуваарь"-ийн дагуу 34 нэгжид 2000 ширхэг борооны цув, 3201 ширхэг усны гутлыг тарааж, одоо үлдэгдэл гал, усны хамгаалалттай 44 ширхэг гутал Хангалт, үйлчилгээний төвийн нөөцөд байна.

Нийслэлийн цагдаагийн удирдах газарт хуваарилагдсан 500 ширхэг усны гутлаас 174 ширхгийг алба хаагчдад олгож, үлдэгдэл 326 ширхгийг Нийслэлийн онцгой комиссын штабт хүлээлгэн өгсөн байна.

#### Гурав. Дүгнэлт:

Улаанбаатар цагдаагийн хүрээний анги, байгууллагын алба хаагчдад 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдөр нөөцөд бүртгэлтэй 350, төсвийн санхүүжилтээр худалдан авсан 150, хандив, тусламжаар өгсөн 2745, нийт 3245 ширхэг усны гутлаас 3201 ширхэгийг 34 нэгжид тарааж, одоо үлдэгдэл гал, усны хамгаалалттай 44 ширхэг гутал Хангалт үйлчилгээний төвийн нөөцөд бүртгэлтэй байна.

Хандив, тусламжаар 2745 ширхэг усны гутлыг үнэ төлбөргүй хүлээн авсан боловч орлогод авч, санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, алба хаагчдад хүлээлгэн өгсөн усны гутлыг тухайн алба хаагчийн нэр дээр бүртгэж, картлаагүй байгааг анхаарч, санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг шуурхай бүрдүүлж, дүнг 2023 оны 08 дугаар сарын 28-ны дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх шаардлагатай байгааг анхаарах нь зүйтэй.

Цаашид хандив, тусламжаар аливаа бараа материал авахдаа стандартын шаардлагад нийцсэн /өнгө үзэмж, хэлбэр хийц, чанар, эрүүл мэндэд нөлөөлөх эсэх/ эсэхийг хянан үзэх, санхүүгийн анхан шатны баримтыг тухай бүрт нь бүрдүүлж байх, байгууллагын нэр хүндэд эрсдэл учрах эсэх, хөндлөнгийн аудитын байгууллагаас хэрхэн үнэлэх талаар судалж, бодитой шийдвэр гаргахад анхаарч ажиллах шаардлагатай гэж дүгнэж байна.

#### Гурав. Санал:

1. Хандив, тусламжаар 2745 ширхэг усны гутлыг үнэ төлбөргүй хүлээн авсан боловч орлогод авч, санхүүгийн анхан шатны баримтыг бүрдүүлээгүй, алба хаагчдад хүлээлгэн өгсөн усны гутлыг тухайн алба хаагчийн нэр дээр бүртгэж, картлаагүй байгааг анхаарч, санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг шуурхай бүрдүүлж, дүнг 2023 оны 08 дугаар сарын 28-ны дотор Дотоод хяналт-аюулгүй байдлын газарт ирүүлэх /CAAA/;

2. Цаашид хандив тусламжаар аливаа бараа материал авахдаа стандартын шаардлагад нийцсэн /өнгө үзэмж, хэлбэр хийц, чанар, эрүүл мэндэд нөлөөлөх эсэх/ эсэхийг хянан үзэх, санхүүгийн анхан шатны баримтыг тухай бүрт нь бүрдүүлж байх, байгууллагын нэр хүндэд эрсдэл учрах эсэх, хөндлөнгийн аудитын байгууллагаас хэрхэн үнэлэх талаар судалж, бодитой шийдвэр гаргахад анхаарч ажиллах талаар зөвлөмж хүргүүлэх саналтай байгааг илтгэн танилцуулья.

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА,  
ДОТООДЫН ЦЭРГИЙН КОМАНДЛАГЧ,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Ж.БОЛД

УДИРДЛАГЫН ШИЙДВЭР:.....  
.....  
.....

ХЯНАСАН:  
ДЭД ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

П.ОРОСТОГОО

ТАНИЛЦСАН:  
ДОТООД ХЯНАЛТ-АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ГАЗРЫН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Д.МАНЛАЙБААТАР

ЦЕГ-ЫН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ,  
САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

Н.АЛТАНСҮХ

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:  
ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН  
ЧИГЛЭЛИЙН АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

М.АЗЖАРГАЛ

АХЛАХ БАЙЦААГЧ,  
ЦАГДААГИЙН ХОШУУЧ

Ё.МӨНХЗУЛ